



ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН



Улаанбаатар хот

2023 >





ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН

---



**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН - 2023**

**Боловсруулсан:**

**С.Түмэндэлгэр**, МУБИС-ийн Дэд профессор,  
ЖҮХ-ны дэргэдэх Эрдэмтэн судлаачдын бүлгийн ахлагч

**О.Буянаа**, ЖҮХ-ны Ажлын албаны Салбар дундын  
бодлого зохицуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан  
ахлах мэргэжилтэн

**Хянасан:**

**Т.Энхбаяр**, ЖҮХ-ны Нарийн бичгийн дарга бөгөөд  
Ажлын албаны дарга

**С.Батцэцэг**, ЖҮХ-ны Ажлын албаны Тогтвортой  
хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

**Холбоо барих:**

Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний Гудамж  
Утас: (976) 70071116  
И-мэйл: secretariat@ncge.gov.mn

## ӨМНӨТГӨЛ



Монгол Улсын Их Хурлаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталсан нь төрөөс Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүнийг эрх тэгш хөгжих, хөгжлийн үр шимээс эн тэнцүү хүртэх боломжоор хангах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, хөгжлийн урт, дунд, богино хугацааны зорилтыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлэхэд чухал алхам болсон юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 -д зааснаар Засгийн газар нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг Улсын Их Хуралд 2 жил тутам тайлагнах, тайлан бэлтгэх ажлыг Жендэрийн үндэсний хороо үндэсний хэмжээнд зохион байгуулах үүрэгтэй байдаг.

Засгийн газар хууль батлагдсанаас хойш 2021 онд анх удаа Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хэлэлцүүлсэн бол 2023 онд хоёр дахь удаагийн тайланг ийнхүү танилцуулж байна.

Тус тайланг жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, бодлого, Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газраас 2021-2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хамарч зөвлөх чиг үүрэг бүхий Жендэрийн үндэсний хороо боловсруулсан бөгөөд ЗГХЭГ, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаар цахим, танхим хосолсон хэлбэрээр 17 удаа хэлэлцүүлж, агуулгын болон техникийн 70 орчим саналыг тусгаж ажиллалаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг үнэлэх, тайлангийн агуулгын хүрээг гаргахдаа олон улсын болон үндэсний түвшний үр дүнгийн шалгуур үзүүлэлт, УИХ-аас өгсөн зөвлөмж, чиглэлд нийцүүлж жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, жендэр судлалын асуудлыг тухайлан хамруулсан бөгөөд бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт 50% буюу “хэрэгжих шатанд” байна. Тайланд анх удаа төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд үйл ажиллагааны болон үр дүнгийн 41 шалгуураар үнэлгээ хийж танилцуулсан бөгөөд цаашид жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулахад түлхэц өгнө гэж итгэж байна.

Тайланг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан ЖҮХ-ны дэргэдэх Эрдэмтэн судлаачдын бүлгийн ахлагч, дэд профессор С.Түмэндэлгэр, мэдээлэл, баримтаар хангаж, санал зөвлөмж өгч хамтран ажилласан ЖҮХ-ны гишүүд, Хорооны дэргэдэх Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, Эрдэмтэн судлаачдын бүлэг, Жендэрийн салбар зөвлөл, салбар хороодын дарга, гишүүд, жендэрийн мэргэжилтнүүддээ болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүн амын санд талархал илэрхийлье.

Жендэрийн үндэсний хорооны  
Нарийн бичгийн дарга бөгөөд  
Ажлын албаны дарга

 Т.Энхбаяр



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ	7
ЗУРАГ, ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	8
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ, АРГА ЗҮЙ	11
Тайлан бичих үндэслэл, шаардлага	11
Тайлангийн зорилго, ач холбогдол	12
Тайлангийн хамрах хүрээ, хугацаа	12
Тайлангийн агуулга	12
НЭГ. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ	14
1.1. Жендэрийн эрх тэгш байдлын хангах талаарх хөгжлийн үзүүлэлт: Монгол Улс олон улсын хэмжээнд	14
1.2. Монгол Улсын жендэрийн нөхцөл байдал: Өөрчлөлт ба сорилт	16
1.3. Хууль тогтоох байгууллагаас өгсөн бодлогын зөвлөмж, түүний хэрэгжилт	19
ХОЁР. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, МАНЛАЙЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН	32
2.1. Засгийн газраас Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчны шинэчлэлийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн	32
2.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах институц дэх ахиц дэвшил	35
2.3. Үндэсний тогтолцоог бэхжүүлэх, чадавхжуулах бодлого, үйл ажиллагаа	49
2.3.1. Жендэрийн үндэсний хорооны үүрэг оролцоо	49
2.3.2. Удирдлагын академийн үүрэг оролцоо	53
2.4. Хөгжлийн олон талт хамтын ажиллагаа, түншлэл	55



**ГУРАВ. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН**

3.1. Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, зорилт, хүрэх үр дүн	59
3.1.1. Алсын хараа 2050-Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого ба жендэр	59
3.1.2. Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны бодлого (хөгжлийн зорилтот хөтөлбөр) ба жендэр	61
3.1.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)	62
3.1.4. Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого (2022-2031)	63
3.2. Салбар, орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах богино хугацааны стратеги төлөвлөлт, онцлог	64
3.2.1. Салбарын хөгжлийн үзэл баримтлал, стратеги төлөвлөлт	64
3.2.2. Салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт	70
3.2.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	70
3.3. Жендэрийн статистик ба хүйсээр ангилсан мэдээллийн бүрдүүлэлт, ашиглалт	73

**ДӨРӨВ. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН**

4.1. Улсын төсвийн санхүүжилт, хэрэгжилт, тайлагналт	76
4.2. Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт арга зүй нэвтрүүлэх үйл явц, үр дүн	78
4.3. Орон нутаг ба байгууллагын хөгжлийн түвшний жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн арга зүй, туршилтын явц, үр дүн	86

**ТАВ. ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН**

5.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, ахиц дэвшил	88
	89



5.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ	91
5.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн	100
5.3.1.Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	101
5.3.2.Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ	102
<b>ЗУРГАА. ЖЕНДЭР СУДЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН</b>	106
<b>ДОЛОО. СУРГАМЖ БА СОРИЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ</b>	111
7.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, хүний нөөцийн удирдлага, манлайллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт	111
7.2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт	113
7.3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, санхүүгийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт	114
7.4. Жендэрийн мэдрэмжтэй бодлогын гүйцэтгэл, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт	115
7.5. Жендэр судлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт	116
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	117





## ТОВЧИЛСОН ҮГ

АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖЭТБХтХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЗГҮАХХАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ШУТИС	Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар





## ЗУРАГ, ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын ахиц дэвшлийн урьдчилсан дүн, 2022 он

Зураг 2. Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж, 2020 он

Зураг 3. Хэвлэл мэдээлэл, нөлөөллийн ажил, 2022 он

Зураг 4. Сургалтын байгууллага дахь сэтгэл зүйчийн тоо, 2022 он

График 1. ЖҮХ-ны гишүүд, хамаарах хэвслээр, 2023 он

График 2. ЖҮХ-ны гишүүд, хүйсээр, 2023 он

График 3. “Хорооны гишүүний цаг” уулзалтын ирцийн мэдээ, хувиар, 2023 он

График 4. ЖҮХ-ны Ажлын албаны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, 2021, 2022 он

График 5. Жендэрийн дэд салбар зөвлөл, жендэрийн дэд салбар хороо бүхий агентлаг, сум, хороо, хувиар, 2022 он

График 6. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл бүхий Жендэрийн салбар зөвлөл болон салбар хороо, хувиар, 2022 он

График 7. Жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны хурал, 2021, 2022 он

График 8. Жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны гишүүд, жендэрийн мэргэжилтэн, хүйсээр, 2021, 2022 он

График 9. Жендэрийн салбар зөвлөлийн хурал, яам тус бүрээр, 2022 он

График 11. Сургалтын тоо, хамрагдсан байгууллагаар, 2021, 2022 он

График 12. Сургалтад оролцогчид, хүйсээр, 2021, 2022 он

График 13. Жендэрийн тэгш бус байдлын индекс, 2022 он

График 14. ЖҮХ-ны Ажлын албаны үйл ажиллагааны санхүүжилт төгрөгөөр, 2021, 2022 он

График 15. ЖЭТБХТХ-иар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, яамдаар, 2022 он


График 16. ЖЭТБХТХ-иар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, аймаг, нийслэлээр, 2022 он

График 17. ЖЭТБХТХ-иар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, дүүргээр, 2022 он

Хүснэгт 1. ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсгийн хэрэгжилт /Засгийн газар/

Хүснэгт 2. ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсгийн хэрэгжилт /Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо/

Хүснэгт 3. ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсгийн хэрэгжилт /Яам/



Хүснэгт 4. ЖЭТБХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсгийн хэрэгжилт /Орон нутаг/

Хүснэгт 5. ЖҮХ-ны хуралдаан, тогтоолын агуулга, 2020-2023 он

Хүснэгт 6. ЖҮХ-ны төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжилт хувиар, 2021-2022 он

Хүснэгт 7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг хангах хүрээнд хийсэн ажлууд, 2021, 2022 он

Хүснэгт 8. Зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар зөвлөл, салбар хороод, 2022 он

Хүснэгт 9. Жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны бие даасан жендэрийн мэргэжилтэн, 2022 он

Хүснэгт 10. Жендэрийн сургалтын зорилго, чиглэл

Хүснэгт 11. Жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны зохион байгуулсан сургалтад оролцогчдын мэдээлэл, 2021, 2022 он

Хүснэгт 12. Мэргэшүүлэх багц сургалтын хичээлийн агуулгаар дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийн мэдлэг, ур чадвар олгосон төрийн албан хаагчийн тоо

Хүснэгт 13. Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо, 2021, 2022 он

Хүснэгт 14. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх цахим сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо, 2021, 2022 он

Хүснэгт 15. Дэлхий дахин, бүс нутаг дахь оролцоо, гадаад хамтын ажиллагаа, 2021, 2022 он

Хүснэгт 16. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт, хүрэх түвшин

Хүснэгт 17. Бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө баталсан Засгийн газрын тогтоол, 2020-2022 он

Хүснэгт 18. ЖЭТБХтХ-ийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, 2021, 2022 он

Хүснэгт 19. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээ, 2022, 2023 он

Хүснэгт 20. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилт, мянган төгрөгөөр, 2011-2022 он

Хүснэгт 21. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хүрээнд захиргааны төв болон орон нутгийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах үйл ажиллагаа, 2021, 2022 он



Хүснэгт 22. Сургуулийн өмнөх боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээний төсөл арга хэмжээний тоо, санхүүжүүлэх дүн, 2020-2022 он

Хүснэгт 23. 2020-2022 онд ашиглалтад орсон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж

Хүснэгт 24. Цалингийн сүлжээний шатлал  
(Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол)

Хүснэгт 25. Цалингийн сүлжээний шатлал  
(Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол)

Хүснэгт 26. Цалингийн сүлжээний шатлал  
(Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол)

Хүснэгт 27. Үндсэн цалингийн өсөх хувь  
/Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 122-р тушаал/

Хүснэгт 28. Үндсэн цалингийн өсөх хувь  
/Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 122-р тушаал/

Хүснэгт 29. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн зорилт тус бүрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт, 2021, 2022 оны үзүүлэлтээр

Хүснэгт 30. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин, 2021, 2022 оны харьцуулалт

Хүснэгт 31. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар салбарт баримтлах бодлогуудын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээ /2023 оны 9 сарын 19-ний байдлаар/

Хүснэгт 32. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээ /2022 оны 12 сарын 31-ний байдлаар/

Хүснэгт 33. Жендэрийн боловсрол олгох зорилго бүхий хичээлийн хөтөлбөрийг сургалтад нэвтрүүлсэн байдал, 2023 он

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ, АРГА ЗҮЙ

### Тайлан бичих үндэслэл, шаардлага

1. Монгол Улсын УИХ-аас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХтХ)-ийг 2011 онд баталсан бөгөөд тус хуулийн 5.1.3-т “Төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх”-ийг төрийн хариуцлагын зарчим хэмээн заасан.

Тус хуулиар төр, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд болон гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэхэд Улсын их хурал, Засгийн газар, Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хороо, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, Төрийн албаны зөвлөл, олон нийтийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг, оролцооны талаарх зохицуулалтыг тусгаснаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх эрхзүйн суурь үндэс нь болсон юм.

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХтХ)-ийн 16 дугаар зүйлийн 16.1.7 зааснаар Засгийн газар нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг Улсын Их Хуралд 2 жил тутам тайлагнах үүрэгтэй.

Засгийн газар хууль батлагдсанаас хойш 2021 онд анх удаа Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг хэлэлцүүлсэн бөгөөд 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 09/2528 тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдад зөвлөмж ирүүлсэний дагуу 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран зохион байгуулсан “Хуулийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” онол практикийн бага хурлаар ЖЭТБХтХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хэлэлцсэн байна.

Энэ хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг бүх шатанд нэвтрүүлэх, жендэр судлалыг хөгжүүлэх зорилгоор “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 10 дугаар тогтоол гарч, ЗГХЭГ, ЭЗХЯ, Сангийн яам, БШУЯ-д хэрэгжилтийг хангуулахаар хүргүүлсэн.



Тус тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахаар тогтоолд заасан.

3.Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.” гэж заасан бөгөөд тус төлөвлөгөөний хэрэгжилт, холбогдох төсвийн зарцуулалт, үр дүнг жил бүр Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй.

Иймд Монгол Улсын Их Хурлаас Засгийн газарт хүргэсэн зөвлөмж, чиглэл, Засгийн газрын жендэрийн тэгш байдлыг хангах талаар хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, ахиц дэвшил, цаашид анхаарах чиглэлийг тоймлон Монгол Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэхээр энэ удаагийн Засгийн газрын тайланг танилцуулж байна.

### **Тайлангийн зорилго, ач холбогдол**

Энэхүү тайлан нь Монгол Улсын Засгийн газар жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар Монгол Улсын Их Хуралд 2 жил тутам тайлагнах бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хууль, бодлогын хэрэгжилтийн явцын болон үр дүнгийн шалгуурт суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нэг хэсэг болгон Засгийн газар үйл ажиллагааныхаа ололт, амжилт, сургамжийг цэгнэн дүгнэж, холбогдох зөвлөмж гаргаж, улмаар хууль, бодлогын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

### **Тайлангийн хамрах хүрээ, хугацаа**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, бодлого, Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2021-2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон арга хэмжээг хамарна.

### **Тайлангийн агуулга**

Тус тайлангийн 1, 2, 3, 4 дүгээр бүлгийг бичиж боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024), түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21, 22 дахь илтгэл, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн Үндэсний сайн дурын илтгэл, ЖЭТБХТХ-д заасан жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаарх төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын цахим тайлан, Жендэрийн үндэсний хороо, үндэсний төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага,



судлаачдын тайлан илтгэл, Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сангийн жендэрийн статистик үзүүлэлтүүд Дэлхийн эдийн засгийн форумас жил бүр гаргадаг жендэрийн зөрүүтэй байдлын 2021, 2022, 2023 оны тайлан, Дэлхийн Банкны “Эмэгтэйчүүд, бизнес ба хууль” судалгааны 2023 оны тайлан, холбогдох бусад эх сурвалж ашиглав. Түүнчлэн ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (2021)-г тус тайлангийн суурь үзүүлэлт болгож ашиглалаа.

Тайлангийн 5 дугаар бүлгийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгож, захиргааны дотоод болон хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, мэдээлэлд суурилан боловсруулав. Тайлангийн 6 дугаар бүлгийг их дээд сургуулийн хөтөлбөрт тусгагдсан жендэрийн сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэлд үндэслэсэн болно.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан нь долоон бүлгээс бүрдэнэ.

Тайлангийн **нэгдүгээр бүлэгт** жендэрийн эрх тэгш байдлын хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн хураангуй, **хоёрдугаар бүлэгт** жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, удирдлага зохион байгуулалт, манлайллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, **гуравдугаар бүлэгт** жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, **дөрөвдүгээр бүлэгт** жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, санхүүгийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, **тавдугаар бүлэгт** жендэрийн бодлого төлөвлөлтийн гүйцэтгэл, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, **зургаадугаар бүлэгт** жендэр судлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, **долоодугаар бүлэгт** Засгийн газраас жендэрийн эрх тэгш байдлын хангах чиглэлээр 2021, 2022 онд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний үр дүн, сургамж, сорилт, цаашид анхаарах чиглэлийг тодорхойллоо.

Тус тайланд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг Засгийн газраас бусад байгууллага болон зарим тохируулагч агентлагийн холбогдох мэдээлэл тусгагдаагүй болно.





## НЭГ. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

### 1.1. Жендэрийн эрх тэгш байдлын хангах талаарх хөгжлийн үзүүлэлт: Монгол Улс олон улсын хэмжээнд

Жендэрийн эрх тэгш байдлын хангах талаар улс орнуудын хөгжлийн ахиц дэвшил, нэн ялангуяа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш бус байдал, зөрүүг хэмжиж, эрэмбэлэн, холбогдох зөвлөмж чиглэл өгдөг зарим индекс болон цар тахлын үед олон улсад “сайн туршлага”-аар шалгарсан боловсрол, шинжлэх ухаан, цахим хөгжлийн салбарт нэвтрүүлсэн санаачилга, амжилтыг тайланд онцлон авч үзлээ.

Манай оронд хамаарах олон улсын жендэрийн хөгжлийн үзүүлэлтүүд хууль эрхзүйн орчны шинэчлэлийн хүрээнд ахиц дэвшилттэй байгаа бол хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт, нэн ялангуяа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендэрийн тэгш байдлын зөрүүгийн үзүүлэлтийн хувьд ухралттай байна.



**Эмэгтэйчүүд, бизнес ба хууль эрхзүйн орчны үзүүлэлт** (World bank, 2023): Тус индексийн хувьд Монгол Улс ахиц дэвшилтэй байна.

Дэлхийн банкнаас гаргадаг энэхүү индекс нь дэлхийн 190 улс орны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнесийн орчныг дэмжсэн эрх зүйн

орчны үзүүлэлтүүдийг хянадаг.

Тус үзүүлэлтэд шилжилт хөдөлгөөн, ажлын байр, цалин хөлс, гэрлэлт, эцэг эх байх, бизнес эрхлэлт, хөрөнгө эзэмшил, тэтгэвэр гэсэн дэд үзүүлэлтүүд хамаардаг бөгөөд Монгол Улс ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал баталж мөрдүүлсэн, хүүхдээ асарч буй аав, ээжид хүүхэд асарсны тэтгэмж олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэсэн гол үзүүлэлтээр ахиц дэвшил үзүүлсэн 20 улс орны тоонд багтсан байна.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал”-ыг Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1-д зааснаар цалин хөлс тогтооход баримтлах бөгөөд бүх



салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааны цар хүрээ, түвшин, нөхцөл зэрэгтээ тохируулан хэрэглэх боломжтой юм.

Зарчмын хэрэгжилтийг хянах гол шалгуур үзүүлэлт нь цалин хөлс тогтоохтой холбоотой гарсан гомдол, маргаан байх бөгөөд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар сум, дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд ижил үнэлэмж бүхий ажилд адил цалин хөлс олгохгүй байгаа талаар гомдол ирээгүй байна.

Ийнхүү Монгол Улс “Эмэгтэйчүүд, бизнес ба хууль эрх зүйн орчны үзүүлэлт”-ээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өндөр насны тэтгэврийн эрх зүйн зохицуулалтаас бусад бүх үзүүлэлтийг хангаж, эрх зүйн орчны үнэлгээ 90,6% буюу **“тодорхой үр дүнд хүрсэн”** байна.

Түүнчлэн Засгийн газраас Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Хууль зүйн туслалцааны тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгаж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойш тус хуулийн зарчим, агуулгыг салбарын хуулиудад тусгахад томоохон ахиц дэвшил гарсан юм.

**“Gateways to Public Digital Learning”** буюу **“Олон нийтийн дижитал сургалтын гарцууд” санаачилгыг хэрэгжүүлэгч улс:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 77 дугаар чуулганы хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 13-27-ны өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан “Хувьсаж буй боловсрол” дээд хэмжээний чуулга уулзалтаар UNESCO, UNICEF хамтарч “Gateways to Public Digital Learning” санаачилгыг зарласан.

Тус санаачилгын хүрээнд Монгол Улс нь цар тахлын үед теле хичээлийг ерөнхий боловсролын сургуулиудад эхлүүлж, танхимын хичээлийг эхлүүлэхдээ 5/9 стратегийг хэрэгжүүлж, Medle.mn цахим платформыг ажиллуулж, хичээлийн хоцрогдол нөхөх зорилгоор Suraad.mn платформыг нэвтрүүлж, хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулахаар зорьж ажилласан, цар тахлын үед үдийн цай хөтөлбөрийг үдийн хоол хөтөлбөр болгож, эмэгтэй сурагчдын сурах орчныг сайжруулж, ариун цэврийн байгууламжийг ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулан өөрчилж шинэчилж, авсан амлалтаа хэрэгжүүлснээр жендэрийн тэгш байдлыг хангах үйл хэрэгт сайн туршлага болсон (БШУЯ-ны тайлан, 2023).





**Жендэрийн ялгаатай байдлын үзүүлэлт /индекс/:** Тус индексийн хувьд Монгол Улс өмнөх онтой харьцуулахад ухарсан үзүүлэлттэй байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр тооцон гаргаж байгаа жендэрийн ялгаатай байдлын үзүүлэлтээр Монгол Улс 2021 онд 156 улсаас 69 дүгээрт, 2022 онд 145 улсаас 70 дугаарт байсан бол 2023 онд 146 улсаас 80 дугаарт эрэмбэлэгдээд байна (World economic forum, 2023).

Тус индексийн дэд индекс болох боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа бол эмэгтэйчүүдийн парламент дахь оролцоо, ажиллах хүчний оролцооны байдал нь уг үзүүлэлт ухрахад нөлөөлсөн байна.

2023 онд батлагдсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын тусгай арга хэмжээ болж, цаашид үр дүнгээ өгөх юм.

Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн барьсан Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хуулийн төслийг боловсруулахад Засгийн газар хамтран ажиллаж, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүй, бодлогын орчны шинэчлэлд манлайлал үзүүлж ажиллахын зэрэгцээ Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллалаа.

## 1.2. Монгол Улсын жендэрийн нөхцөл байдал: Өөрчлөлт ба сорилт

Тухайн улс үндэстний ахуй соёл, хөгжлийн ялгаатай байдалд суурилсан нөхцөл байдлыг тодруулахад улс орны жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ, статистик үзүүлэлтээс гадна төр, иргэний нийгэм, бизнесийн салбарын санал, иргэдийн үнэлгээ чухал байр суурь эзэлдэг.

Иймд тайлангийн хугацаанд боловсруулагдсан Тогтвортой хөгжлийн зорилгын Үндэсний сайн дурын илтгэл болон бусад хөндлөнгийн судалгаа, дүн шинжилгээний тайланг энэ хэсэгт эшлэл болголоо.

Үндэсний хэмжээнд хийгдсэн үнэлгээ, судалгааны үр дүнгээс харахад жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, хамгаалах хүчин чармайлтаа хадгалахын сацуу, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах, хөдөлмөрийн оролцоон дахь хүйсийн ялгааг

бууруулах, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдлыг бууруулахад онцгой анхаарах шаардлагатай байна.




Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн Үндэсний сайн дурын илтгэл (Mongolia voluntary national review: Implementation of the Sustainable Development Goals, 2023):

Тогтвортой хөгжлийн зорилгын жендэрийн тэгш байдлыг хангах, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах зорилгын хувьд олон улсын түвшинд ахиц дэвшил гарсан ч даван туулах сорилтууд байсаар байна (Sustainable development goals, 2023).

Монгол Улсын Засгийн газар, ЭЗХЯ-наас 2022 онд боловсруулж, 2023 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад танилцуулсан Үндэсний сайн дурын илтгэлд Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг 2030 онд зорилтот түвшинд хүргэхийн тулд нийт тодорхойлсон 134 зорилтын 27.6 хувийн хэрэгжилтийн одоогийн эрч ахицыг хадгалах, 54.5 хувийн хэрэгжилтийг нэн даруй эрчимжүүлэх, харин 17.2 хувьд нь онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэжээ.

Зураг 1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын ахиц дэвшлийн урьдчилсан дүн, 2022 он.



Эх сурвалж: YCX, 2023.



Тодруулбал, Хүнсний аюулгүй байдлыг хангаж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжих (ТХЗ-2), Чанартай боловсролыг дэмжих (ТХЗ-4), Жендэрийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах (ТХЗ-5), Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах (ТХЗ-6), Эдийн засгийн өсөлт, зохистой ажлын байрыг бий болгох (ТХЗ-8), Тэгш бус байдлыг бууруулах (ТХЗ-10), Хариуцлагатай хэрэглээг дэмжих (ТХЗ-12) зэрэг 7 зорилгын хувьд тодорхой ахиц дэвшил гарсан хэдий ч Монгол Улс 2030 он хүртэлх зорилгыг биелүүлэхийн тулд **“улам их хүчин чармайлт гаргах хэрэгтэй”** гэдгийг онцолсон байна.

Түүнчлэн Тогтвортой хөгжлийн 5 дугаар зорилгын эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг зогсоох зорилтын **хэрэгжилтийн ахиц дэвшлийг хадгалах**, бүх түвшинд жендэрийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, бүх охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлж хүчирхэгжүүлэх зохистой бодлого, хэрэгжиж болох хууль тогтоомжийг батлан сайжруулах зорилтын **хэрэгжилтийн ахиц дэвшлийг хурдасгах** талаар холбогдох зөвлөмжийг өгсөн (*“Хүснэгт 29. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт тус бүрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт”-ээс*).


Мөн Ядуурлыг бууруулах (ТХЗ-1), Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (ТХЗ-11), Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах (ТХЗ-13), Энх тайван, шударга ёсыг цогцлоох (ТХЗ-16), Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (ТХЗ-17) зэрэг зорилгуудын хэрэгжилтийг хангахын тулд **“онцгой анхаарал хандуулах шаардлагатай”**, Эрүүл мэндийг дэмжих (ТХЗ-3), Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх (ТХЗ-7), Инновацыг дэмжиж, дэд бүтцийг сайжруулах (ТХЗ-9), Хуурай газрын экосистемийг хамгаалах (ТХЗ-15) зэрэг зорилгуудын хувьд **“Хэрэгжилт бага буюу зогсонги байдалтай”** гэж үнэлсэн бөгөөд эдгээр нь жендэрийн тэгш байдал, хүртээмжтэй өсөлттэй уялдаатай юм.

Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилгын тэргүүлэх 12 чиглэлд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах” 5 дугаар зорилгыг оруулсан нь Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт, Монгол Улсын хөгжлийн урт ба дунд хугацааны зорилтыг жендэрийн мэдрэмжтэй хангах шаардлага хэрэгцээг харуулж байна.

**Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос хойш өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж (Жендэрийн үндэсний хороо, 2020):**



**Зураг 2.** Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт сургамж, 2020 он.



Тус үндэсний хэмжээний дүн шинжилгээг Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас хариуцан анх 2005 онд хийсэн бол 15 жилийн дараа ЖҮХ-ноос хариуцан дотоодын эрдэмтэн, судлаачдын хүчээр гүйцэтгэн 2020 онд хэвлэн нийтэлж, бүх нийтэд танилцуулсан. Энэ хүрээнд ЖЭТБХТХ-д заасан 7 салбар, хүрээнд бий болсон жендэрийн харилцааны төлөв байдлыг шинжлэн судалсан бөгөөд судалгаагаар илэрсэн жендэрийн тэгш бус байдал, зөрүү буураагүй, хадгалагдсан хэвээр байна. Тухайлбал, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн оролцоо өмнөх онтой харьцуулахад аль аль хүйсийн хувьд 0.2-1.6 пунктээр, дундаж наслалт 0.23-0.28 пунктээр тус тус өссөн боловч зөрүүгийн үзүүлэлт өөрчлөгдсөнгүй (Үндэсний статистикийн хороо, 2023).

Иймд нийгэм, улс төр, эдийн засаг зэрэг хүрээ тус бүрээр нарийвчлан дүн шинжилгээ хийж, оновчтой арга хэмжээ авч, бодлогын **хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай** байна (Холбогдох мэдээллийг “Хүснэгт 29. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт тус бүрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт”-ээс).

### 1.3. Хууль тогтоох байгууллагаас өгсөн бодлогын зөвлөмж, түүний хэрэгжилт

1.3.1. Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны хуралдаанаар хэлэлцсэн ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, танилцуулга нь Монгол Улсын хууль тогтоох байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Засгийн газрын анхны тайлан байсан.

Байнгын хорооны сонсголын дүнд Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдад ирүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулах 5 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 54 хувьтай байгаа нь зөвлөмжийн хэрэгжилтийг **“эрчимжүүлэх шаардлагатай”** байгааг харуулж байна. Үүнд:

**Зөвлөмж 1.** Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба болон жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны бүтэц, орон тооны асуудалд онцгой анхаарч, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах, төсвийн



зарцуулалтад хяналт тавьж ажиллах зөвлөмжийн хэрэгжилт 30%-тай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Жендэрийн салбар зөвлөл болон салбар хороог иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлтэй өргөтгөн байгуулж, гишүүдийн чиг үүргийг тодорхой зааж, ажиллах журмыг шинэчлэн мөрдүүлэх талаарх зөвлөмж, үлгэрчилсэн загварыг боловсруулж, 2022 онд хүргүүлсэн.


Дээрх үлгэрчилсэн загварыг жендэрийн салбар зөвлөл болон салбар хороодод мөрдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, жендэрийн бие даасан мэргэжилтэнг ажиллуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, түүний албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах ажлыг ЖҮХ-ны 2023 оны төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна (Дэлгэрэнгүй мэдээллийг тус тайлангийн 2 дугаар бүлгийн 2.1 болон 4 дүгээр бүлгээс).

**Зөвлөмж 2.** ЖЭТБХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 10.4, 11.3.2 дахь заалтын биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулж ажиллах, хэрэгжилтийг хангаж чадаагүй нөхцөлд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хувьд хүчин чармайлт сул, хэрэгжилт 30%-тай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

ЖЭТБХтХ-ийн 21 дүгээр зүйлд Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг заасан бөгөөд уг хуулийн 10.1, 10.3, 10.4, 11.3.2 дахь заалтын биелэлтэд хяналт тавих, төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх тайланг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг тусгасан.

Энэ хүрээнд ЖҮХ-ны 2023 оны төлөвлөгөөнд хуульд заасан дээрх тайлан мэдээллийг боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулж хэлэлцүүлэхээр тусгаж, Засгийн газраас дэмжлэг үзүүлж, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

Мөн түүнчлэн ЖҮХ-ны 2022 оны 2 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байгаа “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө”-нд төрийн байгууллагын удирдлагын багт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэнцвэртэй томилж, хуульд заасан квотын хэрэгжилтийг хангах зорилт, арга хэмжээг тусгасан бөгөөд Засгийн газрын бүрэлдэхүүнд 3 эмэгтэй сайд, эмэгтэй аймгийн Засаг дарга анх удаа томилогдон ажиллаж байна.



Түүнчлэн яамдын газар, хэлтсийн дарга нарын түвшинд хүйсийн тэнцвэртэй байдалд ахиц гарч байгаа хэдий ч хуульд заасан квотын хэрэгжилт 30-35%-тай буюу “хэрэгжилт хангалтгүй” байна.

Тухайлбал, ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д “томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15%-иас, дүүрэгт 20%-иас, суманд 25%-иас, хороонд 30%-иас доошгүй байх” гэж зааснаас Засгийн газрын түвшинд, сайд нарын түвшинд квот 2021 онд хангагдаж байсан бол 2022 онд хангагдаагүй, дэд сайдын түвшинд тайлангийн хугацаанд хангагдаагүй байна.

**Хүснэгт 1.** ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсгийн хэрэгжилт / Засгийн газар/

Улс төрийн албан тушаал	2021			2022		
	Хүйс		Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх	Хүйс		Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх
	эр	эм		эр	эм	
Сайд	15	4	21% Тийм	19	3	13.63 % Үгүй
Дэд сайд	12	2	14.2% Үгүй	14	2	12.5% Үгүй

Харин аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарын түвшинд хуульд заасан квот хангагдаагүй, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын орлогч нарын хувьд хуульд заасан квот хангагдсан хэвээр байна.





**Хүснэгт 2.** ЖЭТБХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсгийн хэрэгжилт/  
Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо/

Албан тушаал	Нийт	2021				Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх	Нийт	2022				Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх
		Эрэгтэй		Эмэгтэй				Эрэгтэй		Эмэгтэй		
		тоо	хувь	тоо	тоо			тоо	хувь	тоо	хувь	
Аймаг, нийслэлийн Засаг дарга	22	22	100	0	0	Үгүй	22	21	95.5	1	4.5	Үгүй
Аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч	40	33	82.5	7	17.5	Тийм	24	22	91,6	2	8,3	Үгүй
Дүүргийн Засаг дарга	9	8	88.8	1	11.2	Үгүй	9	8	88.8	1	11.2	Үгүй
Дүүргийн Засаг даргын орлогч	23	17	74	6	26	Тийм	9	6	66.6	3	33.3	Тийм
Сумын Засаг дарга	330	279	84.5	51	15.4	Үгүй	330	274	83	56	17	Үгүй
Хороодын Засаг дарга	162	78	48.1	84	51.8	Тийм	205	109	53,1	96	46,8	Тийм

ЖЭТБХтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэгт “төрийн захиргааны удирдах албан тушаалтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагын даргын 15 хувиас, ... , яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх гэж зааснаас 2022 оны байдлаар яамдын ТНБД, агентлагийн дарга нарын түвшинд хуульд заасан квот хангагдаагүй, харин яамны газар хэлтсийн дарга нарын түвшинд нийт дүнгээрээ квот хангагдсан боловч БШУЯ, ГХЯ, ХНХЯ, Сангийн яам, Соёлын яам, ХЗДХЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ хангасан, БХБЯ, БХЯ, УУХҮЯ, ЦХХХЯ, ЭХЯ, ЭЗХЯ-д хангагдаагүй байна.

Яамдын газар, хэлтсийн дарга нарын хүйсийн харьцаа 2019 онд 40.1:59.9% байсан бол 2022 онд 36:64%-тай болж 4.1%-иар буурсан үзүүлэлттэй байна.



Хүснэгт 3. ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсгийн хэрэгжилт /яам/

Улс төрийн албан тушаал	2021			2022		
	Хүйс		Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх	Хүйс		Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх
	эр	эм		эр	эм	
Төрийн нарийн бичгийн дарга	12	2	14.2% Үгүй	15	1	6.25% Үгүй
Яамны газар, хэлтсийн дарга	114	60	34.4% Тийм	154	87	36% Тийм

Хүснэгт 4. ЖЭТБХТХ-ийн 10 дугаар 10.1.2 дахь хэсгийн хэрэгжилт /орон нутаг/

Албан тушаал	Нийт	2021				Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх	Нийт	2022				Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх
		Эр		Эм				Эр		Эм		
		тоо	хувь	тоо	хувь			тоо	хувь	тоо	хувь	
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	22	17	77.5	5	22.7	Үгүй	22	19	86.3	3	13.6	Үгүй
Аймаг нийслэлийн ЗДТГ-ын газар, хэлтэс албадын дарга	253	203	80.2	50	19.7	Үгүй	156	96	61.5	60	38.4	Үгүй
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	9	8	88.9	1	11.1	Үгүй	9	8	88.9	1	11.1	Үгүй
Дүүргийн ЗДТГ-ын газар, хэлтэс, албадын дарга нар	60	34	56.6	26	43.3	Тийм	72	33	45.8	39	54.1	Тийм
Сумын Засаг даргын Тамгын газрын дарга	330	182	55.6	147	44.5	Тийм	327	170	51.9	157	48	Тийм



*Тайлбар: 2022 оны тайлангийн хугацаанд Дундговь аймгийн 2 сумын Засаг даргын Тамгын газрын дарга томилогдоогүй болно.*

Цаашид Төрийн албаны зөвлөлтэй хамтран, удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг сонгон шалгаруулах тогтолцооны түвшинд Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотын хэрэгжилтийг хангах, түүнчлэн зарим салбарт тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэх тодорхой зохицуулалтыг хийх хэрэгцээ шаардлагатай байгаа нь сүүлийн 5 жилийн холбогдох тайлан мэдээнээс харагдаж байна.


**Зөвлөмж 3.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлан таниулах чиглэлд салбар, орон нутгийн түвшинд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах зөвлөмжийн хүрээнд Засгийн газраас тодорхой хүчин чармайлт гаргаж, мэдээллийг хүртээмжтэй хүргэхэд анхаарч 70%-тай буюу **“тодорхой үр дүн”** гаргасан байна.

“Жендэрийн мэдрэмжтэй мэдээлж сурвалжлах” редакциудад зориулсан удирдамжийг хэвлүүлэн түгээж, сургалт, чадавхжуулах ажлыг жил бүр тогтмол зохион байгуулж хэвшсэний зэрэгцээ Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтарсан санамж бичиг байгуулан ажилласнаар ОНРТтХуулийн 8.2-т заасан Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх, үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангах бодлого баримтлах заалтыг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэхэд ахиц гарч байна.

Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз дотоод бүтэцдээ анх удаа Жендэрийн хороо байгуулан хүний нөөцийн болон уран бүтээлийн бодлогоо жендэрийн мэдрэмжтэй төлөвлөж хэрэгжүүлдэг болохоо зарлалаа.

Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизийн “Өглөө” хөтөлбөрөөр долоо хоногийн Баасан гараг бүр “жендэрийн тэгш боломж-тэгш хариуцлага” хөтөлбөрийг бэлтгэн нийт 16 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж хүргэсэн нь телевизийн салбарт шинэ туршилга боллоо.

ЖҮХ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөлтэй хамтран эмэгтэйчүүдийг улс төрд идэвхтэй оролцоход саад болж буй нийгэмд байгаа жендэрийн хортой хэвшмэл ойлголтыг халах, шийдвэр



гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэй улс төрчдийн талаарх нийгмийн хэвшмэл дүр төрх хүлээлтийг залруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг холбогдох бүх байгууллагатай хамтран ажиллалаа. Төрийн албан хаагчид, жендэрийн сургагч багш, жендэрийн манлайлагч нарыг сургаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чадавхыг бэхжүүлэх зорилгоор 12 төрийн байгууллагын нийт 200 гаруй албан хаагч, ИТХ-н төлөөлөгчийг сургалаа. Жендэрийн мэдрэмжтэй 77 эрэгтэй удирдагч, Улс төрийн намын 103 жендэрийн манлайлагчдыг тодрууллаа.

Төслийн дэмжлэгтэйгээр Улс төрийн намууд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний туршлагаа хуваалцах, бодлогын түвшинд шийдвэрлэх асуудлыг хэлэлцэх зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 300 гаруй төлөөлөгчтэй “Улс төрийн намын оролцоо, манлайлал” Үндэсний форумыг Жендэрийн үндэсний хороо анх удаа зохион байгууллаа. Эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх, шийдвэр гаргах түвшинд ажиллах ур чадварыг ахиулах арга хэмжээг үндэсний түвшинд өргөн хүрээнд зохион байгуулж улс төрийн бүх шатны сонгуульд нэр дэвшихээр горилж буй эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэн бэлтгэхэд ЖҮХ хамтран ажиллалаа.

Зураг 3. Хэвлэл мэдээлэл, нөлөөллийн ажил, 2022 он.

**Хэвлэл мэдээлэл, нөлөөллийн ажил**

№	Огноо	Гарчиг	Хамтрагч байгууллага
Хэвлэл мэдээлэл			
1.	09.09	"Гэр бүлд ээлтэй орчин" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
2.	09.16	Хөдөлмөр эрхлэлт" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
3.	09.23	"Ажлын байрны ээлтэй орчин" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
4.	09.30	"Гэр бүлийн дэмжлэг ба харилцаа" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
5.	10.07	"Эрэгтэйчүүдийн чанартай урт наслалт" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
6.	10.14	"Эрэгтэйчүүдийн чанартай урт наслалт-сайн туршлагауд" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
7.	10.21	"Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
8.	10.31	"Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт-үндэсний чадавхийг бэхжүүлэх нь" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
9.	11.04	"Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
10.	11.11	"Хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх нь" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
11.	11.18	"Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, даван туулах хуулийн боломжууд" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
12.	11.25	"Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян эхэллээ" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
13.	12.05	"Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, хэрхэн шийдвэрлэх тухай" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
14.	12.09	"Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн ойлголт мэдлэг ямар түвшинд байна? Бид хэрхэн хамтран ажиллах вэ?" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
15.	12.16	"Жендэрийн статистикийг хөгжүүлэх, хэрэглэхийн ач холбогдол, үр нөлөө" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ
16.	12.23	"Жендэрийн статистикийг хөгжүүлэх, хэрэглэхийн ач холбогдол, үр нөлөө" сэдвээр	ЖҮХАА МҮОНТБ

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны [www.ncge.gov.mn](http://www.ncge.gov.mn) цахим хуудсаар дамжуулан цаг үеийн мэдээ, мэдээлэл, хэвлэгдэн гарсан ном товхимол, фото болон видео болон сургагч багш нарын мэдээлэл, салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн мэдээлэл тогтмол нийтэлж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 246,278 хандалттай байна.

Мөн олон нийтийн сүлжээнд ЖҮХ-ны (<https://www.facebook.com/gender.gov.mn>)-ыг нүүр хуудсыг ажиллуулж, 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 8500

гаруй дагагчтай байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 16302 болж, 2 дахин өссөн байна.



Түүнчлэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд нь өөрийн байгууллагын цахим хуудсаар жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд 2022 оноос шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, охид эмэгтэйчүүдийг хүрчирхэгжүүлэх хүрээнд [www.tentsuu.mn](http://www.tentsuu.mn) цахим хуудсыг тусгайлан ажиллуулж, жендэрийн мэдлэг ойлголтыг олон нийтэд хүргэж байна.

**Зөвлөмж 4.** Бүх шатны сургалтын байгууллагад орон тооны сэтгэл зүйч ажиллуулах зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд хэдийгээр ковид, цар тахлын хүндрэлтэй үе байсан хэдий ч БШУЯ-наас хүчин чармайлт гаргаж, **70%-тай буюу “тодорхой үр дүн”-тэй** ажилласан байна.

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 124 сэтгэл зүйчийг ажиллуулж байсан бол 2023-2024 оны хичээлийн жилд энэ тоог хоёр дахин нэмэгдүүлэн мэргэжлийн 280 ажилтантай болсон байна.

2023-2024 оны хичээлийн жилд шинээр сэтгэл зүйч ажиллуулахаар төрийн өмчийн 112 сургууль хүсэлт ирүүлснийг үндэслэн боловсролын сэтгэл зүйч бэлтгэх 6 дахь удаагийн сургалтыг зохион байгуулж байна (БШУЯ-ны тайлан, 2023).

**Зураг 4.** Сургалтын байгууллага дахь сэтгэл зүйчийн тоо



БШУЯ-наас Боловсролын багц хуулийн төслийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж, батлуулснаар сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, ахлах, дээд боловсролын сургалтын агуулга, удирдлагад жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх эрх зүйн орчныг сайжруулахад дорвитой алхам хийсэн болно.

**Зөвлөмж 5.** Засгийн газраас баталсан эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийг сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тусгайлсан хөтөлбөр, арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлд тогтолцооны болон практик түвшинд онцгой анхаарч **70%-тай буюу “тодорхой үр дүн”-тэй** ажиллалаа.

Эмэгтэйчүүдийн практик болон стратеги хэрэгцээг урт хугацаанд тогтвортой хангаж, хөдөлмөрийн оролцооны түвшинг зохист түвшинд нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Тус хуулийн төсөлд эмэгтэй бизнес эрхлэгчийг эрх зүйн хүрээнд нарийн тодорхойлж, дэмжих бүтцийг бий болгохыг зорьсон.

Түүнчлэн ХЗДХЯ-наас Төрийн өмчит үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын бүрэлдэхүүний хүйсийн харьцааг хуульчлах саналыг тусгаж хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Мөн хөдөлмөрийн орчинд дарамт хүчирхийлэл, ялангуяа бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд бэлгийн дарамтыг Эрүүгийн хуульд тусгаж, холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байнгын болон түр ажлын байраар хангах зорилго бүхий “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Хүүхэд хамгаалагч төсөл”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-үүдийг 2021-2022 онд хэрэгжүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 18.9 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Хөтөлбөр, арга хэмжээнд 2021 онд давхардсан тоогоор 39.8 мянган хүн хамрагдсанаас 21.8 мянга буюу 54.9% нь эмэгтэйчүүд байна.

Хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 22.9 мянган ажлын байрыг бий болгож, хадгалснаас 4.6 мянга нь байнгын, 11.8 мянга нь түр, 6.4 мянга нь цагийн ажлын байр байна.





Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тоот тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байнгын болон түр ажлын байраар хангах зорилго бүхий “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-үүдийг 2022-2023 онд хэрэгжүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 46.8 тэрбум төгрөгийг зарцуулж ажилласан.

Хөтөлбөр, арга хэмжээнд 2022 онд давхардсан тоогоор 85.3 мянган хүн хамрагдсанаас 50.7 мянга буюу 59.5% нь эмэгтэйчүүд байна.

Хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 42.8 мянган ажлын байрыг бий болгож, хадгалснаас 7.8 мянга нь байнгын, 27.3 мянга нь түр, 7.6 мянга нь цагийн ажлын байр байна.

Цаашид дээрх төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж, байнгын ажлын байрыг бий болгох, байнгын ажлын байранд зуучлагдан, тогтвортой ажиллаж байгаа ажиллах хүчний хүйсийн харьцааг судалж, жендэрийн мэдрэмжтэй дахин төлөвлөлтийг хийж ажиллах шаардлагатай байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд цахим болон шаардлагатай ур чадвар олгох сургалт дэмжлэгт хамруулах замаар тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилготой “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг 2022 оноос хэрэгжүүлж, 3482 иргэн хамрагдан 618,228,325 төгрөгийг зарцуулж 556 ажлын байр бий болсон байна.





Хөтөлбөрийн хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал,

- Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 31 иргэн хамрагдаж 270,000,000 төгрөг зарцуулж, 61 ажлын байр бий болсон;
- Хүүхэд харах төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 31 иргэн хамрагдаж, 37,240,000 төгрөг зарцуулсан;
- Ур чадвар олгох, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих богино хугацааны сургалтад 1173 иргэн хамрагдаж, 191 ажлын байр бий болж 181,511,400 төгрөг зарцуулсан;
- Цагаар ажиллахыг дэмжих арга хэмжээнд 2137 иргэн хамрагдаж 304 түр ажлын байр бий болж, 89,976,925 төгрөгийг тус тус зарцуулсан;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг арга хэмжээнд 24,500,000 төгрөг зарцуулсан;
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнд 110 иргэн хамрагдсан байна.

Хэдийгээр хэрэгжүүлсэн арга хэмжээний статистик байгаа боловч “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-өөс бусад хөтөлбөрийн хувьд байнгын ажилд зуучлагдсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн мэдээллийг нарийвчлан гаргаж, хөтөлбөрийн үр нөлөөг тогтмол үнэлж, дахин төлөвлөлт хийж байх шаардлагатай.

**1.3.2. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороотой** хамтран 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдөр “Хуулийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” бага хурал зохион байгуулсан.

Тус бага хурлын үр дүнд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Чиглэл өгөх тухай” 2022 оны 10 дугаар тогтоолыг баталж, дор дурсан 3 заалт бүхий чиглэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ЭЗХЯ, Сангийн яам, БШУЯаманд тус тус хүргүүлсэн бөгөөд тус тогтоолын хэрэгжилт **50%-тай буюу “хэрэгжих шатанд”** байна. Үүнд:

**Чиглэл 1.** ЖЭТБХтХ-ийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зөвлөмж, хуулиар үүрэг хүлээгч бүх тал идэвхтэй хамтран ажилласан.

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө”-г ЖҮХ-ны 2022 оны 02 дугаар тогтоолоор батлан мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд 2021, 2022 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох зөвлөмж хүргэж ажилласан.



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон холбогдох гэрээ конвенц, Конвенцын хорооноос болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн байгууллагуудаас өгсөн зөвлөмж, асуулгын хэрэгжилтийг хангаж, тайлангийн хугацаанд “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 10 дугаар тайлан (2022 он), “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 5 дахь удаагийн тайлан (2022 он), “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын хэрэгжилтийн талаар Монгол Улсын ээлжит 7 дахь тайлан (2022 он)-г хүргүүлэн амжилттай хамгаалж, хэрэгжилт **70%-тай буюу “хэрэгжих шатанд”** байна.

**Чиглэл 2.** Жендэр судлалыг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд ЖҮХ, түүний Ажлын алба, БШУЯ-тай хамтран жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг бүх шатны сургалтын байгууллагын хөтөлбөрт тусгах ажлыг дэмжин ажиллаж байна.

Жендэр судлал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн бие бялдар, физиологи, оюун санаа, сэтгэлзүйн ялгаатай хэрэгцээ шаардлагыг судалж, улмаар нийгэм, эдийн засаг, улс төрийн бүхий л хүрээ, харилцааг бүрэн дүүрэн ойлгож, оновчтой шийдэл, шийдвэрийг олох, бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр ашигт чанарыг сайжруулахад чухал үүрэгтэйгээс гадна бүхий л шинжлэх ухаанд хөрвөх шинж чанартай байдаг.

Оксфорд зэрэг дэлхийн шилдэг их, дээд сургуулиуд нь хүмүүнлэгийн ухааны тэнхимийн хүрээнд жендэр судлалыг бие даасан сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлж, төгсөлтийн дараах магистр, докторын хөтөлбөрт оюутан, судлаачдыг чиглүүлж байна.

Түүнчлэн улс, орнууд төрийн болон хувийн хэвшлийн томоохон нэр хүндтэй их, дээд сургуульд түшиглэн жендэр судлалыг ахисан түвшинд хөгжүүлэхийн зэрэгцээ дэргэдэх эрдэм шинжилгээ, сургалтын төвөөр дамжуулан жендэрийн тэгш байдлыг хангах хууль, бодлогын үнэлгээ, саналыг гаргаж, бусад орны адил төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэмжих, бие даасан болон хамтарсан судалгаа, шинжилгээг хөхиүлэн дэмжих, шаардлагатай санхүүжилтийг олгох арга хэмжээг авдаг.

Иймд энэ чухал судлагдахууныг төрийн оролцоо, дэмжлэгээр үндэсний түвшинд хөгжүүлэх нь чухал бөгөөд Засгийн газраас БШУЯ, ЭЗХЯ, Сангийн яамны хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд анхаарч байна.





## ХОЁР. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, МАНЛАЙЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт, хөгжлийн олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд Засгийн газраас тодорхой ажлууд хийсэн бөгөөд **хэрэгжилт 70% буюу “хэрэгжих шатанд”** байна. Цаашид гарсан ахиц дэвшлийг хадгалах шаардлагатай юм.

### 2.1. Засгийн газраас Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчны шинэчлэлийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн


Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах хүрээнд 5 аргачлалыг баталж, мөрдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

Түүнчлэн тус хуулийн 13 дугаар зүйлд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” -даа хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох талаар зохицуулсан бөгөөд энэ хүрээнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал (12.1.2)-ыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аргачлалын “Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах” хүрээнд 6.2-т заасан “Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө”-г тандан судлах асуудлын Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө хэсгийн 5-д “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх” гэсэн асуудлыг тусгасан.

Тус аргачлалд заасны дагуу “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх” үнэлгээг хийхдээ Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх, Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх гэсэн 2 суурь асуудлыг ашиглахаар зохицуулсан (Хууль тогтоомжийн жендэрийн үнэлгээ зөвлөх үйлчилгээний тайлан, 2019).

Иймд хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг судлах явцад нийгмийн, хүний эрхийн нөлөөллийг судлахын зэрэгцээ жендэрийн үр нөлөөг тооцох зайлшгүй шаардлагын улмаас ЖҮХ-оос боловсруулсан “Хууль тогтоомжийн жендэрийн үнэлгээ” аргачлалыг 2019, 2020, 2022 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, салбарын яамд зэрэг холбогдох талуудыг байлцуулан



туршсаны зэрэгцээ Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулах талаар судалж байна.

2021-2022 онд Улсын их хуралд өргөн барьсан болон баталсан зарим хууль тогтоомжид хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу жендэрийн үнэлгээг хийж үзэхэд хуулийн төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах чиглэлд тодорхой ахиц гарсан байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Шүүх шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-д жендэрийн үзэл баримтлал тусгаж батлагдсан.

-2021 онд шинэчлэн найруулж баталсан Хөдөлмөрийн тухай хуульд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, хөдөлмөрийн гэрээний хувилбарууд (бүтэн бус цагаар ажиллах, гэрээс ажиллах, зайнаас ажиллах, туслах малчин, гэрийн үйлчлүүлэгчээр ажиллуулах г.м) зохицуулалтыг шинээр тусгаж, жендэрийн үр нөлөөг харгалзсан ажлын цаг, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа (эцгийн чөлөө, үрчилсэн эцэг\эхэд олгох тэтгэмж, уян хатан нөхцөлөөр ажиллах)-ны зохицуулалтууд шинээр тусаж, ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх үүднээс хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх талаар үүрэгжүүлэх зэрэг жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэхэд дэвшил гаргасан хууль болсон.

-Хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй, тогтвортой хүргэх, хамгааллын үйлчилгээний үе шат, кейс менежментийг бүтэн зургаар нь тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хянаж санхүүжүүлэх зохицуулалт хангалтгүй, хамтарсан багийн үйлчилгээнд зардал хуваарилахгүй байгаа зэрэг холбогдох судалгааны зөвлөмж, дүгнэлтэд дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд 2020 онд хийсэн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээ, "Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалтын дүн шинжилгээ" болон 2021 онд хийсэн "Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал тодорхойлох судалгаа"-ны зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

-2022 онд шинэчлэн найруулсан Хууль зүйн туслалцааны тухай хуульд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ялгаварлан гадуурхах,




хүсэлт гаргасан хүүхдийн эсрэг гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хүсэлт гаргасан 18 насанд хүрээгүй хохирогч, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, төлбөрийн чадваргүй хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэрч хүүхэд, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүйгээр авах эрхтэйг тогтоосноороо жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэж хуульчилсан болохыг харуулж байна.

-Шүүх шинжилгээний тухай хуулийг шинэчлэн найруулсан бөгөөд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууц хадгалах, аюулгүй байдлыг хангах зарчмууд болон яллагдагч, шүүгдэгчийг нүцгэлэх шаардлагатай бол зөвхөн түүнтэй ижил хүйсийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг байлцуулж болохыг тусгасан зэргээр жендэрийн талаас анхаарвал зохих зохицуулалтыг оруулжээ.

-Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тодорхойлж, “хүний эмзэг мэдээлэл”-д хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг багтаан, хувь хүний нууцад хамаарахыг тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Боловсролын багц хуулийн төсөлд боловсролын зорилгыг бүх шатны боловсролын хөтөлбөр, арга зүйд заавал тусгах, өмчийн хэлбэр харгалзахгүй боловсролын байгууллага хэрэгжүүлэх агуулгад “жендэрийн эрх тэгш байдал” гэсэн агуулга тусгагдсан. Уг хуультай хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөлд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.”, “ялгаатай хэрэгцээ гэдэгт хөгжлийн бэрхшээл, нийгмийн болон хэл, соёлын ялгаатай байдлаас хамаарсан онцлог хэрэгцээг ойлгоно”, суралцагч нь “бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх үйлдэл гаргахгүй байх” үүрэг хүлээх, “Багш нь суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, нийгмийн болон хэл, соёлын ялгаатай суралцагчтай ажиллах арга зүй эзэмшсэн байна.”, “Багш нь суралцагчийн ялгаатай байдал, сурлагын амжилтын үнэлгээ, хувийн нууцыг хадгална.”, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн суралцах, хөгжих үйлийг дэмжих ганцаарчилсан сургалт болон багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах зориулалтын танхимтай байна.” зэрэг зохицуулалтууд тусч, 2023 онд батлагдсан.





Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/236 дугаар тушаалаар байгуулагдан хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн баталсан. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс ангид байх зарчмыг баримтлахаар тусгасан.

Цаашид Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон тэдгээрийг дагаж гарсан холбогдох аргачлалуудыг жендэрийн агуулгаар баяжуулж сайжруулах шаардлага хэрэгцээ байна.

## 2.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах институц дэх ахиц дэвшил

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо нь төр, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач, хэвлэл мэдээлэл, ажилтан, ажил олгогчийн төлөөлөл, оролцоо бүхий Жендэрийн үндэсний хороо, төрийн захиргааны төв байгууллага дахь жендэрийн салбар зөвлөл, нутгийн захиргааны байгууллага дахь жендэрийн салбар хороо, жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, эрдэмтэн судлаачдын бүлэг, тэдгээрийн хамтын ажиллагааг төвлөрүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах хорооны Ажлын албаны тогтвортой байнгын, идэвхтэй үйл ажиллагаа болон иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, ажил олгогчдын дэмжлэг, хүчин чармайлтын үр дүнд бэхжин төлөвшиж байна.

**Засгийн газар**, ЖЭТБХТХ-ийн 16 дугаар зүйлд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх Засгийн газрын бүрэн эрхийг, 17 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрхийг заасан.

ЖЭТБХТХ болон Засгийн газрын тухай хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал хамаарах бөгөөд Жендэрийн үндэсний хороог тэргүүлж, түүний үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2020 оны 7 сарын 7-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Соёлын яам, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам тус тус шинээр байгуулагдсан.

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд орсон энэ өөрчлөлт нь соёл, цахим хөгжлийн салбараар дамжуулан хүний хөгжилд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтийг олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх эрх зүйн болон институцийн үндсийг бэхжүүлсэн.





Эдийн засаг, хөгжлийн яам нь жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг Тогтвортой хөгжлийг зорилгыг хэрэгжүүлэх хурдасгуур, үндэсний 12 тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн зорилтуудыг жендэрийн аргазүйгээр дэмжиж, хөгжлийн дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгаж, салбар дундын зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх талаар хамтран ажиллаж байна.

Соёлын яам нь тус салбарт жендэрийн талаар дунд хугацаанд баримтлах жендэрийн нэгдсэн стратегийг батлан мөрдүүлж, бүх нийтэд жендэрийн боловсролыг түгээхэд салбарын хувь нэмрийг тодорхойллоо.

Цахим хөгжил, харилцаа, холбооны яам төр, хувийн хэвшил дэх бүх төрлийн үйлчилгээний хүртээмжийг тэгш хүртээмжтэй хэнийг ч орхигдуулахгүй чирэгдэлгүй хүргэх, технологийн ур чадварыг үндэсний хэмжээнд хөгжүүлэх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, алслагдсан орон нутгийн иргэдийг мэдээлэл, технологийн дэвшлээр сурах, хөгжих нөхцөл бий болгох, улмаар цахим хуваагдлаас урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоог бүрдүүллээ.


Түүнчлэн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын шийдвэрээр 2023 онд Цахим хөгжил, харилцаа, холбооны салбарт жендэрийн талаар баримтлах чиглэл, үйл ажиллагааны стратеги (2023-2026)-ийг баталж, хэрэгжилтийг эхлүүлсэн байна.

**Жендэрийн үндэсний хороо**, “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 350, 2023 оны 38 дугаар тогтоолоор ЖҮХ-ны бүрэлдэхүүнд тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, тус хорооны орлогч даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ажиллахаар зохицуулсан.



График 1. ЖҮХ-ны гишүүд, хамаарах хэвшлээр

ЖҮХ-ны гишүүд, хамаарах хэвшлээр




Энэ өөрчлөлт төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, салбар хоорондын зохицуулалтыг шуурхай хангах, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болж байна. Түүнчлэн хорооны гишүүдэд ЗГХЭГ, Соёлын яам, ЦХХХЯ, ЭЗХЯ, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз (МҮОНРТ), Монголын Үндэсний Худалдаа

Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо (МАОЭНХ), Хэвлэлийн хүрээлэн, Монгол нутгийн удирдлагын холбоо (МНУХ), Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) зэрэг төр, төрийн бус байгууллагуудын төлөөллийг шинээр нэмж, салбар хүрээгээ тэлсэн байна.

График 2. ЖҮХ-ны гишүүд, хүйсээр

ЖҮХ гишүүд, хүйсээр



ЖҮХ-ны бүрэлдэхүүнд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг /бүлгийн ахлагч/, Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлэг /бүлгийн ахлагч/ тус тус албан ёсоор орж жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл хэрэгт бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Жендэрийн үндэсний хороо нь 2021, 2022, 2023 онд жилд 1-4 удаа хуралдаж, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, салбар дундын стратеги төлөвлөгөө, ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүн, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйлсэд манлайлан ажилласан Жендэрийн үндэсний шинжээч, зөвлөх, болон төрийн албан хаагчийг төрийн дээд шагналд тодорхойлох зэрэг асуудлыг хэлэлцэж, нийт 13 тогтоол баталсан байна.




## Хүснэгт 5. ЖҮХ-ны хуралдаан, тогтоолын агуулга, 2021-2023 он

Он	Сар, өдөр	Тогтоолын агуулга
2021	01 сарын 13	Ээлжит хуралдааны тов зарлах, хэлэлцүүлэх асуудал батлах тухай
	03 сарын 05	Төлөвлөгөө батлах тухай
		Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг танилцуулах тухай
	06 сарын 07	Удирдах зөвлөл байгуулах тухай
	07 сарын 07	Тогтоолын хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай
Мэдээлэл сурталчилгааны талаар авах арга хэмжээний тухай		
2022	02 сарын 24	Төлөвлөгөө батлах тухай
	10 сарын 05	Салбар дундын стратеги төлөвлөгөө батлах тухай
2023	03 сарын 02	Төлөвлөгөө батлах тухай
		Салбар, орон нутгийн жендэрийн бодлого, стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай
		Салбар дундын баг байгуулах тухай
		Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай
		Хэрэгжилтийг зохион байгуулах тухай

Эх сурвалж: ЖҮХ-ны хуралдааны тогтоолууд, 2021-2023

График 3. “Хорооны гишүүний цаг” уулзалтын ирцийн мэдээ, хувиар



Түүнчлэн, Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/- ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хорооны гишүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэн дэмжих, харилцан мэдээлэл солилцох зорилго

бүхий “Хорооны гишүүний цаг” 14 хоног тутмын өглөөний уулзалтыг тогтмолжуулж, 2023 оны 10 сарын 3-ны өдрийн байдлаар 8 удаа зохион байгуулсан бөгөөд, дунджаар 49% ирцтэй байна. Уг үйл ажиллагаа нь хорооны гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл хэрэг дэх оролцоог тогтмолжуулах, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах санал санаачилга гаргахад чухал хувь нэмэр оруулж байна.

**Хүснэгт 6.** ЖҮХ-ны төлөвлөсөн арга хэмжээ, хэрэгжилт хувиар, 2021-2022 он

№	Үзүүлэлт	2021	2022
1	Төлөвлөсөн арга хэмжээний тоо	34	41
2	Хэрэгжилтийн хувь	83%	98%

Тайлангийн хугацаанд нийт 75 (2021 онд 34, 2022 онд 41) арга хэмжээг төлөвлөж, дунджаар **94%** хэрэгжилттэй байна.

Цаашид хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг илүү нарийвчлалтай тогтмол үнэлэх үүднээс төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх бүхий л үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн оролцоог хангаж, оролцооны аргыг ашиглахыг зорьж байна.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 77 дугаар захирамжаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлогын үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд стратегийн дэмжлэг үзүүлэх, зөвлөх чиг үүрэг бүхий **“Бодлогын зөвлөл”-ийг** хорооны дэргэд байгуулсан.

Тус зөвлөл анхдугаар хуралдааныг 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан бөгөөд 2023 онд хуралдааныг Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай уялдуулан зохион байгуулсан бөгөөд ЖҮХ-ны Ажлын албаны даргын 2023 оны А/17 тушаалаар “Нөлөөллийн ажлын хэсэг”-ийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Нөлөөллийн ажлын үр дүнд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд заасан хүйсийн квотыг нэмэгдүүлэх, Улс төрийн намын болон намын санхүүжилтийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих, дотоод ардчилалтай, жендэрийн тэгш байдлыг дэмжсэн төрийн санхүүжилтыг бүрдүүлэх, хуулиудын үзэл санаа, зохицуулалтыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг дэмжих Лобби бүлэг” Улсын Их Хурлын дэргэд байгуулагдан ажиллалаа.

Бодлогын зөвлөл, Лобби бүлэг болон иргэний нийгмийн хамтын санаачилга, манлайллын үр дүнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан нэр дэвшигчийн хүйсийн квотыг 2024 онд 30%, 2028 оноос 40% байхаар нэмэлт өөрчлөлтийг тусган баталсан нь улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын тусгай арга хэмжээ болсон.



Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо нь салбар дундын зохицуулалтыг хангах чиглэлд анхаарахын зэрэгцээ төр, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, бизнес, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний оролцоо, санаачилгыг дэмжих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд хөгжлийн түншлэгчдийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн нэгдмэл байдлыг хангаж, төрийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтэд чиглүүлэх, олон улсын болон бүс нутгийн түвшинд Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоо, чадавхын талаар танилцуулж, сурталчлах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар тулгамдаж байгаа үндсэн асуудлуудыг шийдвэрлэхэд төвлөрч ажиллалаа.

**Хүснэгт 7.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг хангах хүрээнд хийсэн ажлууд, 2021-2022 он

2021 он	Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөтөлбөр” төслийн Монгол дахь Удирдах зөвлөл
	“Эрэгтэйчүүдэд зориулсан нөхөн сэргээх, зөвлөгөө өгөх загвар төв байгуулах хэрэгцээ, шаардлагын судалгаа”-г танилцуулах хэлэлцүүлэг
	Эрэгтэйчүүд, хөвгүүдэд зориулсан нөхөн сэргээх зөвлөгөө өгөх, загвар төвийг ямар байгууллагыг түшиглэн байгуулах талаарх зөвлөлдөх уулзалт
	“Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” судалгааны ажлын хүрээнд холбогдох уулзалт, судалгааны дүн, санал зөвлөмжийг танилцуулах, салбар дундын хэлэлцүүлэг
	“Жендэрийн эрх тэгш байдлыг хангасан шийдвэр гаргалт” сэдэвт цахим хэлэлцүүлэг
	“Монгол дахь албан бус бичил, жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнест үзүүлсэн Ковид-19 цар тахлын нөлөөллийн үнэлгээ” сэдэвт цахим хэлэлцүүлэг
	“Маскулинити-эр жендэр нь яагаад хүчирхийллийн үр дагаварт хүргэж байгааг ойлгох нь” цахим хэлэлцүүлэг
	“Монгол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдлын суурь судалгааны хүрээнд үндэслэсэн зарим тодорхой асуудал” цахим хэлэлцүүлэг
	“Жендэр ба хөгжил-2021” Үндэсний чуулган



2022 он	“Улаанбаатарын тунхаглал”-ын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, ажлын уялдааг хангах зорилготой Хөгжлийн түншлэгчдийн 3 удаагийн уулзалт
	ЖЭТБХтХ батлагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан “ЖЭТБХтХ-ийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” онол практикийн хурал
	“Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 10 дугаар тайлан (2022 он)
	“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 7 дахь тайлан
	“Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 5 дахь удаагийн тайлан (2022 он)
	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-тай хамтарч бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн “Өглөөний цай” уулзалт
	“Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал: Хөдөлгөөнөө эрчимжүүлье” форум
	Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээний “Дэвших зам” 14 хоног тутмын вебинар
	“Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн нэгдсэн цогц дижитал платформ /tentsuu.mn/
	Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагч эмэгтэйчүүдийн зөвлөх үйлчилгээ
	Яамдын Бодлого төлөвлөлтийн газрын удирдлагын жендэрийн тэгш байдлыг хангах талаарх манлайллыг бэхжүүлэх улирал тутмын уулзалт
Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороотой хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан шинэчлэн боловсруулж батлуулсан “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”, холбогдох нөлөөллийн ажлууд	


Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба, Засгийн газрын 2020 оны 80 дугаар тогтоолоор ЖҮХ-ны дүрэмд өөрчлөлт оруулж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 57 дугаар захирамжаар ЖҮХ-ны Ажлын албаны бүтцийг Тогтвортой хөгжлийн бодлогын хэлтэс болон Жендэрийн дүн шинжилгээ, мэдээлэл судалгааны хэлтэстэй, 14 хүний орон тоотой байхаар тогтоосон.

Засгийн газраас ЖЭТБХтХ-ийн хэрэгжилтийг салбар дундын зохицуулалтаар хангах бие даасан бүтэц тогтолцоог бий болгож, тогтвортой ажиллуулж байгаа нь үр дүнгээ өгч байна.





**График 4.** ЖҮХ-ны Ажлын албаны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар



Ажлын алба нь салбар дундын зохицуулалт, хууль тогтоомж, орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудал, нийгмийн түншлэл хамтын ажиллагаа, жендэрийн үндэсний чадавх, сургалтын бодлого, бүх нийтийн жендэрийн боловсрол, олон нийтийн жендэрийн боловсрол, соён гэгээрэл, хэвлэл мэдээллийн асуудлыг хамаарч 2021, 2022 онд нийт 169 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж дунджаар **95.4%-тай** буюу “амжилттай” ажилласан байна.





Цаашид жендэрийн мэдээлэл судалгаа, дүн шинжилгээний чиглэлд болон холбогдох хууль тогтоомжид жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусган нэвтрүүлэх ажлыг улам эрчимжүүлэх, энэ хүрээнд хүрсэн амжилтаа ахиулж бататгах нь сорилт болж байна.

ЖЭТБХТХ-иар хамгаалсан 7 хүрээ, салбарт жендэрийн тэгш байдлыг хангах, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэж байгаа тул Ажлын албаны бүтэц, орон тоог зохистой хэмжээнд хүргэж, төлөвлөх асуудлыг дахин авч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

**Жендэрийн салбар зөвлөл, жендэрийн салбар хороод, 2022 оны байдлаар** ЖЭТБХТХ-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагад 16 жендэрийн салбар зөвлөл, нутгийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүрэгт 31 жендэрийн салбар хороо ажиллаж байгаа бол сумдад 208, хороодод 75 жендэрийн дэд салбар хороо, 4 яам (ХЗДХЯ, БХБЯ, ХНХЯ, БХЯ) -ны харьяа 10 агентлагт жендэрийн дэд салбар зөвлөл ажиллаж байна.

Ийнхүү салбарын яамдаас харьяа агентлаг нэгжид, аймаг, нийслэлийн түвшнээс сум, дүүргийн түвшинд жендэрийн дэд зөвлөл, хороод байгуулагдан салбар, орон нутгийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэврүүлэх бүтэц тогтолцоо бэхжиж байна.

Жендэрийн салбар зөвлөл болон хороод нь жилд 1-7, дунджаар 3 удаагийн хурал зохион байгуулж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж байна.



Жендэрийн салбар зөвлөл, салбар хорооны хурлын тоо өнгөрсөн хоёр жилд 20-30 хувиар өссөн ахицтай байгаа хэдий ч 2021 онд ХЗДХЯ, Сонгинохайрхан дүүрэг, 2022 онд ХЗДХЯ, ЭМЯ, Сэлэнгэ аймаг, Баянзүрх, Чингэлтэй дүүрэг хуралдаагүй байна.



Жендэр салбар зөвлөл, салбар хорооны үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй хэрэгжих, жендэрийн бодлого, төлөвлөлтийг хийхэд удирдлагын санаачилга, манлайллаас гадна жендэрийн мэргэжилтний тогтвор суурьшилтай ажиллах байдал, хариуцлагын тогтолцоо сул байгаа байдал нөлөө үзүүлж байна.

Цаашид салбарын жендэрийн бодлого, орон нутгийн дэд хөтөлбөр /бодлого, арга хэмжээ/-ийн зорилт, арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлэх үүднээс салбар зөвлөл, хороодын хуралдааныг улирал тутам /хамгийн багадаа улиралд нэг удаа/-д төсвийн цаглабартай уялдуулан тогтмол хуралдуулах чухал байна.

Монгол Улсын ЗГҮАХХАТ-ийн 4.2.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Жендэрийн салбар зөвлөл, салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай үлгэрчилсэн загварыг боловсруулж, бүх салбар, орон нутагт хүргүүлж ажиллалаа. 2022 оны байдлаар уг аргачлалд нийцүүлж, салбарын төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны бүрэлдэхүүнд багтаасан 9 (ХНХЯ, ЭМЯ, БХБЯ, БШУЯ, БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ) яам, нийслэл болон нийслэлийн 6 дүүрэг (Нийслэл, нийслэлийн Багахангай, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул), 15 аймаг (Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий) байна. Ийнхүү жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны үйл ажиллагаанд олон талт оролцоог хангаж, иргэний хяналтыг нэмэгдүүлсэн нь чухал алхам болж байна.

**Хүснэгт 8.** Зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар зөвлөл, салбар хороод, 2022 он

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын ЗГҮАХХАТ 4.2.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Хорооны Ажлын албанаас хүргүүлсэн холбогдох аргачлалд нийцүүлсэн яам: ХНХЯ, ЭМЯ, БХБЯ, БШУЯ, БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ/	15	9	60%
2	Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын ЗГҮАХХАТ 4.2.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Хорооны Ажлын албанаас хүргүүлсэн холбогдох аргачлалд нийцүүлсэн: Нийслэл, нийслэлийн Багахангай, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул), 15 аймаг (Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий)	31	22	71%

**Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг**, Жендэрийн үндэсний хорооны 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолын дагуу “Жендэрийн үндэсний шинжээч-зөвлөх бүлэг” анх байгуулж, Хорооны Нарийн бичгийн даргын шийдвэрээр 8 шинжээчийг сонгосон бөгөөд бүлгийн ахлагчаар 2014 оноос Үндэсний шинжээч Т.Амгалан, 2017 оноос Үндэсний шинжээч Б.Долгор, 2020 оноос Үндэсний шинжээч Ж.Занаа, 2022 оноос Үндэсний шинжээч Б.Онон, 2023 оноос Үндэсний шинжээч Д.Сүхжаргалмаа тус тус 2 жил тутамд ээлжлэн сонгогдон ажиллаж байна.

Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг нь 2020 оныг хүртэл жендэрийн сургалтын тогтолцоо, дүн шинжилгээ хийх чадавх туршлагыг бий болгоход түлхүү анхаарч ажилласны үр дүнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт салбар, орон нутагт бүрэн хийгдэж, тухайн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран оролцооны аргаар үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэхэд тодорхой ахиц гаргасан.

2021-2022 онуудад цар тахлын үе болон түүний дараах нөхцөл байсан хэдий ч Жендэрийн үндэсний шинжээчид бие даан болон хамтран олон улсын түвшинд 2, үндэсний хэмжээнд 15, салбарт 17, орон нутагт 3 үйл ажиллагааг зохион байгуулж, Засгийн газар, ЖҮХ-нд идэвхтэй дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Тухайлбал, жендэрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хууль тогтоомжид жендэрийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал, охидын үзлэгийг өсвөр настны нас, хүйсийн онцлогт нийцсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үр дүнтэй хөгжүүлэх, түүнлэн “Охидын үзлэг” гэх хэллэгээс бүр мөсөн татгалзах, улмаар өсвөр нас нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй ажиллах арга замыг тодорхой заасан удирдамж чиглэлийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, цаашид нөхөн үржихүйн урьдчилан сэргийлэх үзлэгийн зорилго, ач холбогдлыг охид, хөвгүүдэд сайтар ойлгуулах, мэдлэг олгох, бэлгийн болон хувийн ариун цэврийг сахих зөвөлгөө өгөх, урьдчилан сэргийлэх үзлэгт сайн дураараа хамрагддаг дадал бий болгох, хандлага төлөвшүүлэх талаарх дүгнэлт, аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн талаарх хуулийн төсөлд санал зөвлөмж өгч ажилласны зэрэгцээ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/ -ний төслийг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ ТББ-аар дамжуулан эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог бэхжүүлэх, сонгуульт албанд олон нийтийн итгэлийг хүлээн ажиллах, нийгмийн өөрчлөлтөд манлайлан оролцох хүсэл эрмэлзлэлтэй эмэгтэйчүүдийг дэмжих зорилготой “Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ”-г байгуулж, бэхжүүлэх ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.



Тайлант хугацаанд соёл, цахим хөгжил, эрчим хүчний салбарт жендэрийн талаар баримтлах стратеги чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад аргагүйн дэмжлэг үзүүлж ажилласнаар бүх салбарт жендэрийн стратеги төлөвлөлт батлагдан хэрэгжиж байна.


2021 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв /Korean Women's Development Institute/-өөс зохион байгуулсан “Ази дахь эмэгтэйчүүдийн улс төрийн чадавхыг сайжруулах, хүчирхэгжүүлэх” Олон улсын форум, 2022 онд Индонезийн Бали мужид Азийн Сангаас зохион байгуулсан Асралын эдийн засаг (care economy)-ийн талаарх бүсийн зөвлөгөөн, Туркийн Станбул хотноо зохион байгуулагдсан CAREC /Central Asia Regional Economic Cooperation/-ын форумд Хороог төлөөлөн эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, орлогожуулах сэдвээр мэдээлэл хийж, Монгол Улсын жендэрийн хөгжлийн ахиц дэвшлийг дэлхий нийтэд түгээн сурталчилж ажиллав.

Тус бүлэг нь салбар, орон нутаг, нийгмийн бүхий л талбарт жендэрийн тэгш байдлыг хангах аливаа үйл хэргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Засгийн газар, Жендэрийн үндэсний хороонд цөм хувь нэмэр оруулдаг, үйл ажиллагаа нь тогтворжсон нэгж болсныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ бүлгийн үйл ажиллагааг орон нутаг, бүсийн хөгжлийг дэмжихэд түлхүү чиглүүлэхэд анхаарч байна.

**Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлэг,** Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлэг нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын жендэрийн чиглэлээр мэргэшсэн, жендэр, жендэрт холбогдох хичээлийг бакалаврын болон ахисан түвшинд заадаг 30 гаруй багш, судлаачдын сайн дураар нэгдсэн бүлэг юм.

Тус бүлгийг 2020 оныг хүртэл МУИС-ийн профессор А.Солонго, 2020 оноос одоог хүртэл МУБИС-ийн дэд профессор С.Түмэндэлгэр ахлан ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолоор Жендэрийн асуудлаарх Эрдэмтэн судлаачдын бүлгийн ахлагчийг ЖҮХ-ны бүрэлдэхүүнд гишүүнээр нэмсэн.

Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлэг нь 2020 оныг хүртэл боловсролын салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжих, бага, дунд, их дээд боловсролын сургалтын агуулгад жендэрийн агуулгыг тусган нэвтрүүлэх, хууль эрх зүйн өөрчлөлтийг хийхэд нөлөөллийн ажлуудыг хийж ажилласны зэрэгцээ жендэрийн тэгш байдлыг хангах ойлголт мэдлэгийг их дээд сургуулийн оюутан сурагчид, политехник, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрт нэгтгэхэд түлхүү анхаарч ажилласан байна.



Тайлант хугацаанд Эрдэмтэн судлаачдын бүлэг нь их дээд сургуулийн сургалтын агуулгад жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж, ЖҮХ-ны дэмжлэгтэйгээр илүү өргөн хүрээнд далайцтай зохион байгуулж ажилласнаар жендэр судлалыг шинжлэх ухааны түвшинд хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх эхлэл суурийг тавьж чадсан байна. (Жендэр судлалыг хөгжүүлэх чиглэлээр гарсан ахиц дэвшлийг зургаадугаар бүлгээс үзнэ үү.)

**Жендэрийн мэргэжилтэн,** Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, олон талт хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хамаардаг албан тушаал бөгөөд янз бүрийн ажил мэргэшил бүхий мэргэжилтнүүд байдаг.



Монгол Улс 2012 оноос эхлэн жендэрийн салбар зөвлөл, хороодод жендэрийн мэргэжилтнүүдийг тогтмол ажиллуулж ирсэн хэдий ч тухайн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж иржээ.

Тиймээс эдгээр ажилтныг орон тооны болгож, салбарын яамд, нутгийн захиргааны байгууллагад тогтвортой тогтолцоог бий болгох шаардлагатай

байгааг ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (Эм Эм Си Жи ХХК, 2021)-ний зөвлөмжид дурдсан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 09/2528 тоот бичгээр Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайдад Жендэрийн үндэсний хорооны ажлын алба болон жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны бүтэц, орон тооны асуудалд онцгой анхаарч, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг зөвлөсөн.

Энэ хүрээнд ЖЭТБХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.2, 18.3.4, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2023)-ний 3.4.3 дахь заалт, ЖҮХ-ны 2023 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн салбар болон орон нутагт бие даасан “Жендэрийн мэргэжилтэн”-г ажиллуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.





Ийнхүү нутгийн захиргааны байгууллагад жендэрийн мэргэжилтний чиг үүргийг хариуцаж буй төрийн албан хаагчдын ажлын ачаалалд дүн шинжилгээ хийсний үр дүнд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-т ажиллах “Жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 341 дүгээр тогтоолоор зөвшөөрсөн байна.

Энэ нь 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт “Жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан бие даасан мэргэжилтэн”-тэй болох үндэс суурь болж байгаа төдийгүй Тогтвортой хөгжлийн зорилго-2030 дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгыг практикт хэрэгжүүлэхэд томоохон ахиц дэвшил гарах юм. Харин яамдад жендэрийн бие даасан мэргэжилтэн ажиллуулах эсэх талаарх ажлын байрны шинжилгээнд үндэслэсэн албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажил хараахан дуусаагүй байна.

Түүнчлэн жендэрийн мэргэжилтний албан үүргийг хариуцсан бие даасан мэргэжилтэн ажиллуулах санаачилга БШУЯ, ХНХЯ-аас эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд бусад яам нь жендэрийн мэргэжилтний албан үүргийг бусад албан тушаалын чиг үүргийн хамт нэмэлт ажил байдлаар гүйцэтгэж байна. 2023 оноос Соёлын яам жендэр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтнийг томилон ажиллуулж байна. Цаашид жендэрийн асуудал хариусан мэргэжилтнийг салбар, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлалыг тусгах, жендэрийн чиглэлээр салбар, орон нутагт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр чадавхыг сайжруулах хэрэгцээ бий болж байна.

**Хүснэгт 9.** Жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны бие даасан жендэрийн мэргэжилтэн, 2022 он

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	Жендэрийн мэргэжилтний албан үүргийг хариуцсан бие даасан мэргэжилтэнтэй яам: БШУЯ, ХНХЯ	16	2	12.5%
2	Жендэрийн мэргэжилтний албан үүргийг хариуцсан бие даасан мэргэжилтэнтэй аймаг: Төв аймаг /Жендэр, хүн амын хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн/, Хэнтий аймаг /Жендэр, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх агшийг хамгаалах, гэрээ хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч/, Нийслэл /төрийн бас байгууллага, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн/, Нийслэлийн БГД /Төсөл хөтөлбөр, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн /	31	4	12.9%

2018 оноос хойш жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хүний болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэхэд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч цаашид жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны түвшинд анхаарч ажиллах шаардлагатай байна.

## 2.3. Үндэсний тогтолцоог бэхжүүлэх, чадавхжуулах бодлого, үйл ажиллагаа

### 2.3.1. Жендэрийн үндэсний хорооны үүрэг оролцоо

Жендэрийн үндэсний хороо нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг. Тайлант хугацаанд Хороо нь жендэрийн тэгш байдлыг хангах сургалт явуулах анхан, дунд, гүнзгий шатны сургалтын тогтолцоог бэхжүүлэх, төрийн байгууллагын албан хаагч, удирдах албан тушаалтан, Хорооны гишүүн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн жендэрийн мэдлэг ойлголтыг бүхэлд нь сайжруулах, чадамжыг бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа.

2017-2020 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг хэрэгжүүлэх хүрээнд нийт төрийн албан хаагчдын 45% (101,000), удирдах ажилтны 50 орчим хувийг (6000) сургасан бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-нд 2026 он гэхэд төрийн албан хаагчдын 85%, удирдах ажилтны 75 хувь (12,635)-ийг сургахаар тусгасан.


#### Хүснэгт 10. Жендэрийн сургалтын зорилго, чиглэл

- Төрийн албан хаагчдад жендэрийн тэгш байдлыг хангах талаар сургалт явуулах анхан шатны сургагч багш бэлтгэх;
- Төрийн албан хаагчдад жендэрийн тэгш байдлыг хангах талаар сургалт явуулах дунд шатны сургагч багш бэлтгэх;
- Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэхэд хөвгүүд, эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургагч багш бэлтгэх;
- Салбарын болон орон нутгийн жендэрийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах;
- Төрийн байгууллагын удирдах ажилтны жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Төрийн албан хаагчдын жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэх;
- Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, ангид орчин бүрдүүлэх, хандлага өөрчлөх;
- Хэвлэл мэдээллийн удирдах ажилтан, сэтгүүлчдийг бэлтгэх, чадавхжуулах;
- Эмэгтэй бизнес эрхлэгчдэд санхүү, бизнесийн боловсролыг жендэрийн мэдрэмжтэй олгох;
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх чадамж хөгжүүлэх.



2022 оны жилийн эцсийн байдлаар “Жендэр ба бодлого төлөвлөлт” сургагч багш бэлтгэх анхан шатны модулиар 250, “Жендэрийн дүн шинжилгээ” сургагч багш бэлтгэх дунд шатны модулиар 25, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хөвгүүд эрэгтэйчүүдийг татан оролцуулах сургагч багш бэлтгэх сургалтын модулиар 25, нийт 300 багшийг тус тус бэлтгээд байна. (<https://www.ncge.gov.mn/publications> ЖҮХ-ны Ажлын албаны тайлан, 2021, 2022)

График 11. Сургалтын тоо, хамрагдсан байгууллагаар




2021, 2022 онд ЖҮХ, яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-аас жендэрийн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх нийт 1284 сургалтад 6030 байгууллагын 104,364 (давхардсан тоогоор) хүн хамрагдсан байна.

Сургалтын тоо өмнөх оноос 2.5 дахин, сургалтад хамрагдсан байгууллагын тоо 2.6 дахин, оролцогчдын тоо 1.8 дахин нэмэгдсэн нь ЖҮХ, жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны үйл ажиллагаа тасралтгүй, идэвхтэй, өсөлттэй байгааг харуулж байна. Тухайлбал, яамд, агентлагийн түвшин дэх сургалтын тоо 2022 онд өмнөх оныхоос 2 дахин, тэдгээрийн харьяа агентлаг дахь сургалтын тоо 3 дахин өссөн байна.



График 12.Сургалтад оролцогч, хүйсээр



Орон нутгийн жендэрийн салбар хороод ажилтнуудын жендэрийн мэдлэг ойлголтыг сайжруулахад анхаарч ажиллаж байгаа нь мөн онуудад зохион байгуулагдсан сургалтын тоо 1.8, оролцогчдын тоо 2 дахин өссөнөөс харагдаж байна.

Хүйсийн хувьд үндэсний хэмжээнд 2021 онд жендэрийн сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын 50.7% эрэгтэй (дийлэнх нь цагдаагийн байгууллагын албан хаагчид) байсан бол 2022 онд 41.3% нь эрэгтэйчүүд байна.

Яамдын түвшинд 2021 онд эрэгтэйчүүд түлхүү оролцож байсан бол 2022 онд эмэгтэйчүүд, ЖҮХ-ноос зохион байгуулсан сургалт арга хэмжээнд эмэгтэйчүүд аль аль онд илүү хамрагдсан.

Төрийн байгууллагууд төдийгүй, аж ахуйн нэгж байгууллагуудаас жендэрийн сургалт захиалах хандлага өсөж байгаа нь сайшаалтай байгаагийн зэрэгцээ тайлант хугацаанд нийт сургалтад оролцогчдын 35% нь захиалгат сургалтад хамрагдагч эзэлж байна (<https://www.ncge.gov.mn/publications> ЖҮХ-ны Ажлын албаны тайлан, 2021, 2022).

Дээрх үр дүнгээс харахад 2026 он гэхэд төрийн албан хаагчдын 85 хувийг чадавхжуулах талаарх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-нд тусгагдсан зорилтыг хангах боломжтой байгаа бөгөөд цаашид сургалтад оролцогчдыг бүртгэлжүүлж, сургалтыг шинээр ажилд орж буй албан хаагчдад өгөх, чиглүүлэх болон давтан мэргэшүүлэх сургалтыг ялгаатайгаар бүртгэж, чанар үр дүнд үнэлгээ хийж ажиллах нь чухал байна.



Сургалтын давтамж, хамрах хүрээ өргөжиж байгаа нь яамд салбарын жендэрийн бодлого, аймаг, нийслэл, дүүрэг орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх болсонтой шууд холбоотой юм.

Цаашид сургалтын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд жендэрийн сургагч багш нарыг салбар, орон нутгийн онцлогт нийцүүлэн мэргэшүүлж, улмаар салбар, орон нутгийн түвшинд сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллахыг зорьж байна. Жишээлбэл Эрүүл мэндийн салбарт 19 жендэрийн сургагч багш бэлтгэсэн бөгөөд цаашид энэ туршлагыг түгээн, салбар тус бүрт сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Сургалт нөлөөллийн ажлууд тогтмолжиж байгаа хэдий ч төлөвлөөгүй, төсөвгүйгээс 2021 онд ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, Соёлын яам, Нийслэлийн Багануур, Сонгинохайрхан дүүрэг, 2022 онд ХНХЯ, Сэлэнгэ аймаг, Нийслэлийн Багахангай, Баянзүрх дүүрэг тус тус жендэрийн сургалт зохион байгуулаагүй гэж тайлагнасан байна.

**Хүснэгт 11.** Жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны зохион байгуулсан сургалтад оролцогчдын мэдээлэл, 2021, 2022 он

Сонгосон үзүүлэлт	Яамд, агентлаг		Аймаг, нийслэл, дүүрэг	
	2021 /14 яам, 22 агентлагаас/	2022 /16 яам, 26 агентлагаас/	2021 /21 аймаг, нийслэл, 9 дүүрэг/	2022 /21 аймаг, нийслэл, 9 дүүрэг/
Сургалт зохион байгуулсан Төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хувь	26 (72.2%)	29 (69%)	28 (90%)	29 (93.5%)
Сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо	1050 (6.0%)	213 (5.2%)	1121 (6.2%)	2702 (7.01%)
Сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	15 (0.09%)	20 (0.5%)	214 (1.18%)	1236 (3.2%)

2021 оны байдлаар салбар зөвлөлийн 72.2%, аймаг, нийслэл, дүүргийн салбар хороодын 90% нь, 2022 оны байдлаар салбар зөвлөлийн 69%, аймаг, нийслэл, дүүргийн салбар хороодын 93.5% нь жендэрийн сургалт зохион байгуулсан.

Сургалт семинарт төр хувийн хэвшлийн байгууллагууд, нийгмийн бүлгүүдийг өргөн хамруулах, тэдний ялгаатай онцлог хэрэгцээнд суурилсан сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг бий болгох хүрээнд оролцогчдын мэдээллийг хүйс, нас, албан тушаал, байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг шинжээр ангилан цуглуулж байна.



Энэ нь мэдлэг, мэдээллээс хандлага, үнэт зүйлийг төлөвшүүлэх, эерэг зан үйл, дадлыг бий болгох зорилт бүхий сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, хүрээг тогтоож, сургалтын бодлогод нэгтгэхэд чухал ач холбогдолтой байна. Тухайлбал, тайлант хугацааны сургалтын үйл ажиллагааны талаарх цуглуулсан мэдээллээс харахад яам, түүний харьяа агентлагийн хувьд оролцогчдын 5-6% нь удирдах ажилтан, 0.09-0.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аймаг, нийслэл, дүүргийн хувьд 6.2-7.0 хувь нь удирдах албан хаагч, 1.18-3.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь сургалтыг эдгээр бүлэгт чиглүүлэх хэрэгцээг харуулж байна.

### 2.3.2. Удирдлагын академийн үүрэг оролцоо

Үндэсний чадавх тэр дундаа төрийн албан хаагчдын жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх мэдлэг ойлголтыг албан сургалтын тогтолцоогоор байнга тогтвортой нэмэгдүүлэхэд ЗГХЭГ-ын дэргэдэх төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэг бүхий төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академи чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Удирдлагын академи жендэрийн эрх тэгш байдал, түүнийг хангахтай холбоотой мэдлэг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд албан ёсны сургалтаар дамжуулан төрийн албан хаагчид хүргэх үүргийнхээ дагуу Засгийн газрын 2022 оны 312 дугаар тогтоолоор хичээлийн агуулга, хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-т “Жендэрийн эрх тэгш байдал” хичээлийг цахим хэлбэрээр судлахаар болсон.

Мөн энэ тогтоолд зааснаар төрийн албан хаагч нь “Жендэрийн эрх тэгш байдал” хичээлийг бие даан цахимаар судалж, 1 багц цагийг биелүүлэх бөгөөд үүнийг төгсөлтийн шалгалтын өмнө тооцуулсан байна хэмээн үүрэгжүүлсэн нь жендэрийн эрх тэгш байдал, түүнийг хангах асуудлаар төрийн байгууллагын шийдвэр гаргалтад эергээр нөлөөлж байна. Тухайлбал, Удирдлагын академи 2021, 2022 онуудад төрийн албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдсан нийт 2097 төрийн албан хаагчдад **“Төрийн байгууллага дахь хүний эрх, ажлын байрны дарамтаас сэргийлэх”** (хичээлийн код Т724, Е742, А742) хичээлээр дамжуулан удирдах ажилтан нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг төрийн албанд хэрхэн хангах талаарх мэдлэг ойлголтыг өгч ажиллалаа.





**Хүснэгт 12.** Мэргэшүүлэх багц сургалтын хичээлийн агуулгаар дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийн мэдлэг, ур чадвар олгосон төрийн албан хаагчийн тоо

№	Сургалтын төрөл	Хичээлийн нэр	Сэдэв	2021	2022
1	Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	Төрийн байгууллага дахь хүний эрх, ажлын байрны дарамтаас сэргийлэх	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, удирдах ажилтан ажлын байранд жендэрийн мэдрэмжтэй хандах, хүний эрхийг хангах	88	105
2	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт			205	465
3	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт			424	810
	НИЙТ			717	1380

Удирдлагын академи нь Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулан холбогдох сургалтын **“Хүний эрх ба захиргаа”** (хичээлийн код N105) хичээлийн агуулгад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад захиргааны байгууллага болон төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлагын талаарх мэдлэг, ойлголт өгч ажилладаг бөгөөд энэ сургалтад 2021, 2022 онд нийт **1700** төрийн албан хаагч (2021 онд 818, 2022 онд 882) хамрагдсан байна. Түүнчлэн Удирдлагын академи нь Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөөнд 2022 оноос **“Жендэрийн эрх тэгш байдал”** (хичээлийн код: 401) бүрэн цахим хичээлийг заавал үзэхээр оруулсан бөгөөд энэхүү хичээлийг 2022 онд **107** төрийн албан хаагч судалж, цахимаар сертификатаа авсан байна (Хүснэгт 13.).

**Хүснэгт 13.** Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо

№	Сургалтын төрөл	Хичээлийн нэр	Сэдэв	2021	2022
1	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	Хүний эрх ба захиргаа	Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад захиргааны байгууллага болон төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлага	818	882
2		Жендэрийн эрх тэгш байдал		-	107

Түүнчлэн жендэрийн чиглэлээр цахим хичээлүүдийг Удирдлагын академийн багш нар боловсруулан бэлтгэж [surgalt.gov.mn](http://surgalt.gov.mn) платформд байршуулсан бөгөөд эдгээр сургалтад 2021-2022 онд нийт 8448 суралцагч бүрэн цахимаар суралцаж сертификатаа хүлээн авсан байна” гэснийг “Түүнчлэн жендэрийн чиглэлээр цахим хичээлүүдийг Канадын Засгийн газрын дэмжлэгээр Удирдлагын академийн багш нартай хамтран боловсруулан бэлтгэж цахим сургалтын платформд байршуулсан бөгөөд 2021-2022 онд нийт 8448 суралцагч цахимаар суралцаж сертификат авсан байна.

**Хүснэгт 14.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх цахим сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо

№	Сургалтын нэр	2021	2022
1	Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ	275	7073
2	Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо	27	179
3	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт-Нэгжийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь	0	894
	Нийт	302	8146

#### 2.4. Хөгжлийн олон талт хамтын ажиллагаа, түншлэл

Жендэрийн тэгш байдлыг хангах талаарх хууль, бодлогын хэрэгжилтийг дэмжихэд Монгол Улс дахь хөгжлийн түншлэгчдийн төсөл, хөтөлбөрийг чиглүүлж, нягт хамтран ажиллалаа.

Засгийн газар олон улс, бүс нутгийн хэмжээний хурал чуулганд 2021 онд 6, 2022 онд 7 удаа оролцож, 3 сургалтад хамрагдаж, 3 улсын хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагын зочид төлөөлөгчдийг хүлээн авч ажлын туршлага, амжилт, сургамжаа танилцуулан, хамтын ажиллагаа тогтоох, бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа (Хүснэгт 15).

2022 онд жендэрийн тэгш байдлыг хангах үйл хэрэгт харилцан туршлага солилцох, хамтран ажиллах зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулах, жендэрийн боловсрол олгох институт (KIGEPE), Эмэгтэйчүүдийн хөгжлийн институт (KWDI)-тэй тус тус хамтран ажиллах зөвшилцлийг хийж, 2023 онд санамж бичгийг албажууллаа.

**Хүснэгт 15.** Дэлхий дахин, бүс нутаг дахь оролцоо, гадаад хамтын ажиллагаа, 2021, 2022, 2023 он

Он	Арга хэмжээний нэр	Хамтран ажилласан олон улсын байгууллага, хөгжлийн түншлэгчийн нэр
2021	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлээс сэргийлэх газраас зохион байгуулсан “Ковид-19- ийн сургамж ба Жендэрийн мэдрэмжтэй гамшгийн эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах нь” олон улсын цахим хурал	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
2021	Эдийн засаг, хүрээлэн буй орчны 29 дүгээр форумын 1 дүгээр бэлтгэл уулзалт “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх замаар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын бүс нутагт аюулгүй байдал, тогтвортой байдал, тогтвортой хөгжлийг дэмжих” цахим уулзалт	ЕВРОПЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА



2021	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын "Эдийн засаг, хүрээлэн буй орчны 29 дүгээр форум"-ын хоёрдугаар бэлтгэл уулзалт	ЕВРОПЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА
2021	Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зохион байгуулсан "Монгол дахь жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын орчны үнэлгээний талаархи бодлогын хэлэлцүүлгийг дэмжих нь" хэлэлцүүлэг	ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК (ЕСБХБ)
2021	Бүгд Найрамдах Солонгос Улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн институт - "Феминист гадаад бодлого ба хөгжлийн албан ёсны туслалцаа" сэдэвт олон улсын хурал	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ
2021	Бүгд Найрамдах Солонгос Улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн институтээс зохион байгуулсан "Ази дахь эмэгтэйчүүдийн улс төрийн чадавхыг сайжруулах нь" олон улсын хурал	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ
2022	"Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг утсгах тухай конвенц"-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 10 дугаар тайланг Конвенцын Хорооны 82-р хуралд танилцуулах, хамгаалах цахим хэлэлцүүлэг	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
2022	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс (ЭАБК)-ын 66 дугаар чуулган /цахим/	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА
2022	Азийн хөгжлийн банкны Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр(CAREC)-ийн жендэрийн бүсийн бүлгийн ажлын даалгаврыг хэлэлцэх жендэрийн шинжээчдийн бүлгийн нээлтийн уулзалт	АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨВ АЗИЙН БҮСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА (CAREC)
2022	Жендэрийн тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүжилт, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээний талаар танилцах, туршлага солилцох уулзалт	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС, НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН
2022	Жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулах, жендэрийн боловсрол олгох институт (KIGEPE)-тэй хамтран ажиллах харилцан ойлголцлын "Санамж бичиг"	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ, ЖЕНДЭРИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ИНСТИТУТ
2022	Ази, номхон далайн уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдлийг даван туулах эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд "Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийн менежментийн жендэрийн мэдрэмжтэй бодлого, эрх зүйн орчин" сэдэвт бүсийн зөвлөгөөн	ФИЛИППИН, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
2022	"Жендэр, оролцоо, хөдөлмөрийн ирээдүй" сэдэвт бүсийн сургалт	ТАЙЛАНД, ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА
2022	Камбожийн эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын Монгол Улсад хийсэн айлчлал	КАМБОЖ



2022	Вьетнамын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөлийн Монгол Улсад хийсэн айлчлал	ВЬЕТНАМ
2022	Бүгд Найрамдах Солонгос Улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн институттэй байгуулсан хамтран ажиллах санамж бичиг	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ (KWDI)
2022	Асралын эдийн засгийн талаарх бүсийн зөвлөгөөн	ФИЛИППИН
2022	Жендэрийн тэгш байдлыг хангах Сингапур улсын туршлага сургалт	СИНГАПУР
2023	Нью-Йорк хотноо 2023 оны 3 дугаар сарын 6-ны Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс (ЭАБК)-ын 67 дугаар чуулган	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА, ХНХЯ
2023	Сонгуулийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Нажаа Хашеми, Босни-Херцеговин улсын Сонгуулийн Төв хорооны гишүүн Ирена Хаджиабдич, АНУ-ын Питсбургийн Их сургуулийн Социологийн профессор Мелани М.Хьюз болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн олон улсын олон нийттэй харилцах мэргэжилтэн Мионгшин Лий, жендэрийн зөвлөх Э.Энхчимэг, төслийн менежер Д.Монголжингоо нартай хийсэн санал солилцох уулзалт	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, КОЙКА
2023	2023 оны 3-р сарын 30-31-ний өдрүүдэд Японы нийслэл Токио хотод Азийн эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн оролцоог өргөжүүлэх Азийн хөгжлийн банкны Хүрээлэнгийн 3 дахь удаагийн чуулга уулзалт	АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
2023	Дэлхийн банкнаас Инго Видерхофер, Дэлхийн банкны Зүүн өмнөд Ази Бүсийн Тогтвортой, Хүртээмжтэй Нийгмийн хөгжлийн секторын менежер тэргүүтэй багтай хийсэн уулзалт	ДЭЛХИЙН БАНК
2023	ЖҮХ болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Эмэгтэйчүүдийн хөгжлийн хүрээлэн хоорондын хамтын ажиллагааны Санамж бичгийн талаар болон хэрхэн гарын үсэг зурж баталгаажуулах зүүм хурал	БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
2023	Гадаад харилцааны яаманд зохион байгуулагдсан “Эмэгтэйчүүд энх тайван аюулгүй байдлын уулзалт	ГХЯ
2023	Гадаад улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт эмэгтэй Элчин сайд болон ОУБ-ын Суурин төлөөлөгч нарыг оролцуулсан “Өглөөний уулзалт” хэлэлцүүлэг	ЖҮХ, ГХЯ



Тайлант хугацаанд хамтран ажилласан гадаад улс орон, Монгол Улс дахь хөгжлийн түншлэгчид, жендэрийн чиглэлээрх төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийн санг бүрдүүлж ажиллалаа. Тухайлбал,

- Швейцарын хөгжлийн агентлаг болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” техникийн туслалцааны төсөл;
- КОЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөл;
- Канад улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэй Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр хэрэгжүүлж буй “Монгол Улсад иргэн төвтэй мэргэжлийн төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл;
- Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техникийн туслалцааны төсөл;
- Дэлхийн банкны дэмжлэгтэй “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” төсөл;
- Канад Улсын Гадаад Хэргийн Яамны дэмжлэгтэйгээр Азийн сан хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл;
- Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны “Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөтөлбөр” төсөл;
- Канадын Засгийн газрын дэмжлэгтэй Мерит төслийн “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”;
- Бүгд Найрамдах Солонгос Улсын санхүүгийн дэмжлэгтэй “Хүн худалдаалахын хохирогчдод дэмжлэг үзүүлэх” төсөл;
- Азийн Хөгжлийн банкны дэмжлэгтэй “Монгол Улсын бэлчээрийн тогтвортой байдал” Уур амьсгалын болон хүрээлэн буй орчны өөрчлөлтөд дасан зохицох нь” төсөл.

Цаашид хөгжлийн түншлэгчдийн хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний бүртгэл, мэдээллийн санг Сангийн яаман дахь хөгжлийн санхүүжилтийн холбогдох мэдээллүүдтэй уялдуулан өргөтгөж, баяжуулах шаардлагатай.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд хөгжлийн түншлэгч, байгууллагын төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог үндэсний түвшинд хангах чиглэлд ахиц дэвшил гарч байгаа ч тэдгээрийн зорилго, үр нөлөөг салбар, орон нутгийн жендэрийн бодлого, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих, үр шимийг орон нутагт засаг захиргааны анхан шатны нэгжүүдэд хүргэхэд анхаарах шаардлагатай байна.



## ГУРАВ. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН

Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн урт ба дунд хугацааны бодлогын, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлох, салбар, орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах богино хугацааны стратеги, жендэрийн тусгай бодлого төлөвлөлт хийх үйл явцад Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо, түүний Ажлын алба хүчин чармайлт гаргасан бөгөөд **хэрэгжилт 50% буюу “хэрэгжих шатанд”** байна. Цаашид жендэрийн салбар зөвлөл, жендэрийн салбар хорооноос хөгжлийн богино хугацааны төлөвлөлт нэн ялангуяа улсын хөгжлийн жилийн төлөвлөлт хийхдээ жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлал нэвтрүүлэх туршлага, санаачилгыг нэмэгдүүлэх шаардлагатай.

### 3.1. Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, зорилт, хүрэх үр дүн

Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ыг баталсан.

Тус журамд зааснаар бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчмуудыг мөрдлөг болгохоос гадна Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулна хэмээн заасан нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлтөд нэгтгэхэд чухал үр дүнгээ өгч байна.

#### 3.1.1. Алсын хараа 2050-Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого ба жендэр

Монгол Улс “Иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно.” хэмээн хөгжлийн алсын хараагаа тодорхойлсон. Амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож, ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлж, өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжих эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал чухал нөлөөтэй.

Монгол Улсын хөгжлийн алсын харааг хэмжих шалгуур үзүүлэлтэд жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт болон хэрэглээний тэгш бус байдлын үзүүлэлт,





ажиллах хүчний оролцооны түвшин, Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн Засгийн газрын үр нөлөө, Зохицуулалтын чанар зэрэг үзүүлэлтүүдийг багтаасан бөгөөд энэ нь урт хугацааны хөгжлийн үр нөлөөг хүн, нийгэм, жендэрийн хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан тооцох явдлыг баталгаажуулсан юм.

**Хүснэгт 16. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин**


Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
				2025	2030	2050					
<b>ХОЁРХҮНИЙ ХӨГЖИЛ</b>											
4	Хүний хөгжлийн үзүүлэлт	индекс	0.74	0.77	0.85	0.9	2018 он суурь түвшин	Үндэсний статистикийн хороо	Статистик мэдээ	Жилд нэг удаа	Үндэсний статистикийн хороо
5	Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт (хэмжүүр)	индекс	0.301	0.25	0.2	0.1		Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр	Экспертийн ярилцлага	Жилд нэг удаа	Жендэрийн үндэсний хороо

Монгол Улс 2026 гэхэд жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлтийг 0.05 пунктээр, 2030 онд 0,1 пунктээр, 2050 он гэхэд 0,2 пунктээр бууруулахаар урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан.

**График 13. Жендэрийн тэгш бус байдлын индекс**



Жендэрийн тэгш бус байдлын индекс нь хүйсийн тэгш бус байдлаас шалтгаалах хүний хөгжлийн гурван хэмжүүр болох нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсролын байдал болон шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон аргачлалыг удирдлага болгож, улс орон бүр өөрийн аргачлалыг батлан хэрэглэдэг бөгөөд Монгол Улс 2011 оноос хойш тус индексийг үндэсний аргачлалаар тооцон гаргаж байна.

Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт 2022 оны үзүүлэлтээр өмнөх онтой харьцуулахад 0.091 пунктээр буурсан хэдий ч 2019 оны хүрсэн түвшнээс ухарсан байна. Графикаас харахад тэгш бус байдлын үзүүлэлт өсөх, буурах талдаа багагүй хэлбэлзэлтэй байгааг анхаарч бодлогын уялдаа тогтвортой байдлыг хангаж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Цаашид тухайн үзүүлэлтүүдийн бүрэлдэхүүн хэсгүүд болох эхийн эндэгдлийг бууруулах, өсвөр насны төрөлтийг бууруулах, ерөнхий боловсрол эзэмшсэн хүн амын тоог нэмэгдүүлэх болон нэн ялангуяа хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ахиц гаргаж чадвал 2026 он гэхэд жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлтийг 0.25 буюу зорилтот түвшинд хүргэх бүрэн боломжтой байна.

### **3.1.2. Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны бодлого (хөгжлийн зорилтот хөтөлбөр) ба жендэр**

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсад хөгжлийн дунд хугацааны бодлого нь хөгжлийн зорилтот хөтөлбөр байхаар заасан.

Монгол Улсын Ерөнхий сайдын тушаалаар байгуулагдсан Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг нь Нийгмийн хөгжил, Хүний хөгжил, Байгаль орчны хөгжил, Засаглалын хөгжлийн хөтөлбөрийн төсөлд жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг шууд болон шууд бус байдлаар дэмжих агуулгыг тусгаад байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганаар хэлэлцэж батлах эдгээр хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах чиглэлээр Жендэрийн үндэсний хороо, Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, эрдэмтэн судлаачидтай нягт хамтран ажиллаж байна.



### 3.1.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын зорилтыг жендэрийн арга зүйгээр дэмжих зорилгоор ЖЭТБХтХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (хэрэгжилт дундаас доогуур), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө (2017-2021)-ний хэрэгжилтийн үнэлгээ (80.4%)-ний үр дүнд тулгуурлан, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-г боловсруулж, ЖҮХ-ны 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан.

Энэ стратеги нь Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэх, олон улс, бүс нутаг, үндэсний түвшинд салбар дундын зохицуулалтыг өргөжүүлэх, төр, төрийн бус, хувийн хэвшлийн оролцоо бүхий хамтын зөвшилцлөөр баталгаажуулсан хөгжлийн төлөвлөлт, арга зүйн удирдамж, стратегийн баримт бичиг юм.

Энэ баримт бичгийг арван жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр боловсруулж баталсан бөгөөд стратегид тусгагдсан арга хэмжээ бүр нэг цогц төсөл арга хэмжээ болж хэрэгжихүйц өргөн агуулгыг багтаасан.

Тус стратеги төлөвлөгөөнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн захиргааны төв байгууллага болох 16 яам, нутгийн захиргааны байгууллага, НӨУБ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон төрийн бус байгууллагын санал зөвлөмжийг өргөнөөр тусгасан. Стратеги төлөвлөгөөг нийгмийн түншлэгч бүх талууд хамтран хэрэгжүүлснээр ЖЭТБХтХ-ийн хэрэгжилтийг дэмжихийн зэрэгцээ Монгол Улсын жендэрийн талаарх тэргүүлэх асуудлыг нэг цонхоор харж, түүнийг шийдвэрлэхэд харилцан суралцаж, хамтран ажиллах өргөн боломж бүрдсэн.

Салбар дундын стратеги төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээ бүрийн хэрэгжих хугацаа, хариуцах байгууллага, хэмжих шалгуур, суурь болон хүрэх түвшинг төлөвлөгөөний үе шат бүрээр тогтоосон. Стратеги төлөвлөгөөг үндэсний хэмжээнд танилцуулах ажлыг 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 5 дугаар сар хүртэл хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт төрийн захиргааны төв байгууллагад уулзалтын хэлбэрээр болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албадад цахим болон хэвлэмэл байдлаар хүргэж ажиллалаа.

ЖҮХорооны 2023 оны 03 дугаар тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-ний хэрэгжилтийг зохион байгуулах салбар дундын баг байгуулж ажиллуулахыг хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад даалгасан бөгөөд энэ хүрээнд салбар дундын 5 багийг стратеги төлөвлөгөөний зорилго тус бүрээр байгуулахаар ажиллаж байна.



Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах салбар дундын багуудад дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны давхцалаас сэргийлэх, уялдаа холбоог хангаж ажиллах, салбар дундын багийн үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд хүргэх, мэдээлэх, явцын болон үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах чиг үүргийг ЖҮХ-ны Ажлын алба хариуцан хэрэгжүүлж байна.

#### 3.1.4. Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого (2022-2031)

Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх үндсэн гол хөшүүрэг бол Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг хувийн хэвшлийн байгууллагын бодлого төлөвлөлтөд нэвтрүүлэх явдал юм.

Энэ хүрээнд хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр зэрэг салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, Хөдөлмөрийн тухай хуулийн жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой заалтуудыг аж ахуйн нэгж байгууллагуудад хэрэгжүүлж буй сайн туршлагын судалгааны ажлыг тус тус 2022 онд хийж гүйцэтгэлээ.

Эдгээр үнэлгээ, судалгааны үндсэн дээр “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого (2022-2031)-ыг Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 38 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг эхлүүллээ.

Тус бодлогыг 2022-2031 он хүртэл 2 үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны талууд хамтран хариуцаж, ЖҮХ нь нийгмийн түншлэлийн талуудад зөвлөн тусалж, бодлогын болон аргазүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллах юм.

Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг төв, орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудын хүний нөөцийн менежерүүдэд сурталчлан таниулах зорилгоор 2023 онд Улаанбаатар хот болон Дархан-Уул, Баянхонгор, Дорнод, Увс аймагт танилцуулах бүсийн сургалтуудыг зохион байгуулж, нийт 97 аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын 108 захиргаа, хүний нөөцийн ажилтанг хамруулаад байгаа бөгөөд цаашид аж ахуйн нэгж байгууллагуудад чиглэсэн сургалтын агуулгыг боловсруулж, сургалт нөлөөллийн ажлуудыг тогтмолжуулах чиглэлд нийгмийн түншлэлийн талуудтай хамтран ажиллах юм.



## 3.2. Салбар, орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах богино хугацааны стратеги төлөвлөлт, онцлог

### 3.2.1. Салбарын хөгжлийн үзэл баримтлал, стратеги төлөвлөлт

Засгийн газар нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ын дагуу салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийг хийхдээ “тэнцвэртэй байх зарчим”, “бүх талын оролцоог хангасан байх зарчим”, “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим”-ыг хангаж ажиллахын зэрэгцээ бодлого хөтөлбөрийн төсөлд иргэд нийгмийн бүлгүүдийн оролцоо төлөөллийг бүрэн бодитой хангах, хүн, нийгэм, байгалийн тэнцвэртэй байдлыг хангах, хөгжлийн төлөвлөлтийг судалгаа шинжилгээнд үндэслэхэд анхаарч ажиллаж байна.

Тус журамд заасны дагуу Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулахад онцгой анхаарч, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/, салбарын болон орон нутгийн жендэрийн бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжин ажиллаж байна.

Засгийн газраас тайлант хугацаанд баталсан бодлого, стратегид үнэлгээ хийж үзэхэд 2020 онд стратеги, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө баталсан нийт 9 тогтоолын 4 нь жендэрийн шууд хамааралтай байгаагаас 57,1%, 2021-2022 онуудад нийт 10 тогтоолын 1 нь жендэрийн шууд хамааралтай байгаагаас 100% жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлал тусгасан байна.

**Хүснэгт 17.** Бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө баталсан Засгийн газрын тогтоол, 2020-2022 он

Он	Засгийн газрын тогтоол, бүгд	Бодлого, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө баталсан тогтоол	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлал тусгасан байх шаардлагатай	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлал тусгасан
2020	221 <sup>1</sup>	9	4	57.1%
2021	224	5	1	100%
2022	251	5	-	

Эх сурвалж: legalinfo.mn

<sup>1</sup> 2020 оны 10 сарын байдлаар (эх сурвалж: ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2021)

Тухайлбал, Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 1.4-т “Цахим ажлын байр бий болгох, цахим хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хүүхдээ асарч буй эцэг, эх, залуу гэр бүлд алсын зайнаас ажиллаж, орлого олох боломжийг нэмэгдүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь жендэрийн практик хэрэгцээг харгалзсан төлөвлөлт болсон. Цаашид эдийн засгийг сэргээх хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулах зорилт, арга хэмжээнд жендэрийн үзэл баримтлал тусгахад анхаарах шаардлагатай.

Салбарын сайдын тушаалаар батлан мөрдүүлсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого чиглэлүүд мөн хэрэгжиж байна. Тухайлбал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 21-ны А/553 дугаар тушаалаар батлагдсан “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл”-д тус чиглэлийг хэрэгжүүлэх зарчим хэсэгт хүний сурч боловсрох эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ялгаатай хэрэгцээг хүндэтгэх, хамгаалах зэрэг заалт туссан.

Тэгш хамран сургах суралцагчдын бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй, алслагдмал болон малчин өрхийн, шилжин суурьшсан өрхийн, үндэстний цөөнх, хэл, соёлын ялгаатай бүлгийн, ядуу, орлого багатай өрхийн, сургуулийн гадна байгаа болон сургууль завсардсан, сурлагын хоцрогдолтой, эрх нь хязгаарлагдсан, асрамж, халамжийн газарт байгаа, хилийн чанадад байгаа, бэлгийн цөөнх, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, залуус, иргэдийг багтаасан байна.

Засгийн газраас ЖЭТБХтХ-ийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг дараах байдлаар авч хэрэгжүүлснээр 2020 оны суурь үзүүлэлттэй харьцуулахад боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцоо, салбарын тэнцвэргүй байдлыг шийдвэрлэх зэрэгт анхаарал хандуулж, эрх зүйн орчин, бүтэц тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалтын хувьд тодорхой үр дүн гаргах бодит нөхцлийг бүрдүүлсэн байна.





**Хүснэгт 18.** ЖЭТБХтХ-ийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, 2021, 2022 он

Тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ/ЖЭТБХтХ/	Тусгай арга хэмжээний хүрээнд гаргасан хүчин чармайлт, бодлого, арга хэмжээ
<p>7.2.1. эх, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр батлах;</p>	<p><b>Эх хүүхдийн эрүүл мэнд:</b> Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ 2023 оны эхний 5 сарын байдлаар 47.6 хувьтай байна. Энэ нь зорилтот түвшний 99.2 хувьд хүрсэн байна.</p> <p>Улсын хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар 27,488 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 2,839 төрөлтөөр буюу 11.5 хувиар өссөн байна. 2023 оны эхний 5 сарын байдлаар улсын хэмжээнд эхийн эндэгдлийн 7 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 25.3 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.0 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Улсын хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 350 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.7 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.3 пунктээр буурсан байна. Шалтгаанаар нь авч үзвэл перинаталь үеийн эмгэг 54.6 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 18.9 хувь, амьсгалын тогтолцооны эмгэг 12.0 хувийг тус тус эзэлж байна.</p> <p>Улсын хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 413 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 пунктээр буурсан байна. Шалтгаанаар нь авч үзвэл нийт эндэгдлийн 89.3 хувь нь өвчнөөр, 10.7 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна.</p>



	<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/93 дугаар тушаалаар “Нярайн шарлалтын оношилгоо, эмчилгээний заавар” батлуулан хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 563 дугаар тушаалаар батлагдсан “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг зохицуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, санал авч байна.</p> <p>“Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/107 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Өсвөр үеийнхэнд зориулсан “Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдвийн хүрээнд 60 сургагч багшийг 2023 оны 02 дугаар сарын 10-11-ний өдөр үндэсний хэмжээнд бэлтгэсэн.</p> <p>БШУЯ, ХНХЯ-тай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж байна. “Монгол Улс дахь эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдал, төрөлхийн хөгжлийн гажгийн тархвар зүйн бүрдэл судалгаа-IX”-г хийж байна.</p> <p><b>Хүүхэд хамгаалал:</b> Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулсан 50 гаруй журам, дүрэм, стандарт, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Энэ хүрээнд хүүхдийн эрхийг хангах асуудлаарх салбар дундын бодлого, зохицуулалтыг сайжруулах замаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн хөгжлийн орчин, үйлчилгээний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэхэд анхаарч бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлээ.</p> <p>Хүүхдийн хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2020 онд 6.4 тэрбум төгрөг, 2021, 2022 онуудад тус бүр 8.0 тэрбум төгрөг болж нэмэгдсэн. Хэдийгээр хүүхэд хамгааллын төсөв нэмэгдсэн боловч хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй, тогтвортой хүргэх, хамгааллын үйлчилгээний үе шат, кейс менежментийг бүтэн зургаар нь тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хянаж санхүүжүүлэх зохицуулалт хангалтгүй, хамтарсан багийн үйлчилгээнд зардал хуваарилахгүй байгаа зэрэг асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орууллаа.</p> <p>Хүүхэд хамгааллын тухай хууль болон санхүүгийн шинэчлэл хийх ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг батлан мөрдүүлээ.</p>
--	---



	<p>Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд 2020 онд хийсэн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээ, “Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалтын дүн шинжилгээ” болон 2021 онд хийсэн “Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал тодорхойлох судалгаа”-ны зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.</p> <p>Улсын хэмжээнд нийт 35 Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж, аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Мөн Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэгдсэн 21 байгууллагын 31 асрамж халамжийн төвд 976 хүүхэд амьдарч байна.</p> <p>Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2022 онд нийт 111,776 дуудлага ирж, өмнөх оноос 20.5 хувиар нэмэгдсэн бол хүүхдийн эрх, хамгааллын дуудлага 16,300 бүртгэгдсэн нь өмнөх оноос 13.5 хувиар буурсан байна.</p> <p>Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/236 дугаар тушаалаар байгуулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран шинэчлэн баталлаа.</p> <p>Тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс ангид байх зарчмыг баримтлахаар тусгасан. Гэр бүлийн тухай хуулийн төслийг <a href="http://www.mojha.gov.mn">www.mojha.gov.mn</a> цахим хуудаст байршуулан олон нийтээр хэлэлцүүлж санал авах ажлыг зохион байгуулж ажиллалаа.</p>
<p><b>7.2.2. улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх;</b></p>	<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхалтыг хориглосон бөгөөд намуудаас нэр дэвшигчдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг тэгш байх, улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас доошгүй байх тухай хуулийн заалтыг 40 хувьд хүргэх нөлөөллийн ажлуудыг идэвхтэй зохион байгуулж, ЖЭТБХТХ-д өөрчлөлт орууллаа.</p> <p>ЖЭТБХТХ-д заасан улс төрийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах баталгааны хэрэгжилтийг хангах хүрээнд улс төрийн намууд Жендэрийн үндэсний хороонд жил тутам тайлангаа хүргүүлж байх зохицуулалтыг ЖЭТБХТХ болон Улс төрийн намын тухай хуульд тусгалаа.</p> <p>Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар тусгасан.</p>



<p>7.2.3. тодорхой салбар дахь хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ авах, эсхүл аль нэг ажил, мэргэжлийн хүйсийн тэгш бус төлөөллийг тэнцвэржүүлэхэд түлхэц өгөхүйц хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, эсхүл тэтгэлэг тогтоох;</p>	<p>Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад 650-аас 750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувийг, элсэлтийн ерөнхий шалгалтад 751-ээс дээш оноо авсан бол 100 хувь сургалтын төлбөрөөс “Сургалтын төрийн сан”-тай байгуулсан гэрээний дагуу тус тус чөлөөлөхөөр зохицуулсан.</p> <p>Энэ хүрээнд “Багш тэтгэлэг”-т 591 оюутан хамрагдсанаас 61 буюу 10.3 хувь нь эрэгтэй оюутан байсан. Эдгээр оюутнуудын 292 нь “Байгалийн шинжлэх ухааны чиглэлээр сурч байгаагийн 39 нь буюу 13.4%-ийг эрэгтэй оюутан эзэлж байна. Мөн эдгээр оюутнуудын 106 нь эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаагийн 1 нь буюу 0.9%-ийг эрэгтэй оюутан эзэлж байна.</p> <p>Цаашид ЖЭТБХТХ-д заасан тусгай арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх талаар анхаарах шаардлагатай.</p>
<p>7.2.4. энэ хуулийн 6.5.6-г үндэслэн сургалтын байгууллагын элсэлтийн нөхцөл, шаардлагыг хүйсээс хамааран ялгаатай тогтоох.</p>	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2021-2024)-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх түр тусгай арга хэмжээ хэрэгжүүлэн элсэгчдийн тоонд хүйсийн квот үе шаттай тогтоох ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар батлагдсан мэргэжлийн чиглэл, индексийн дагуу дээд боловсролын түвшинд элсэгчдийн мэдээллийг жил бүр шинэчлэн гаргаж, үнэлгээ хийж байна.</p> <p><b>2020-2021 оны хичээлийн жилд:</b> Нийт 25.165 элсэгч их дээд сургуульд элсэн орсон байна. Нийт элсэгчдийн 2,866 буюу 11.4 хувь нь боловсролын салбарын мэргэжлүүдэд элсэж, тэдгээрийн 479 буюу 16.7 хувь нь эрэгтэй элсэгч байна. Тус салбарт элсэгчдээс сургуулийн өмнөх болон бага ангийн багш мэргэжлээр элсэгч 710 байгаагийн 17 нь эрэгтэй элсэгч байна.</p> <p>Нийт элсэгчдийн 3,032 буюу 12.0 хувь нь шинжлэх ухаан, технологи, инженерчлэлийн салбар, математикийн чиглэлийн мэргэжлүүдийг сонгон элсэж, тэдгээрийн 977 буюу 32.2 хувь нь эмэгтэй элсэгч байна.</p> <p>Нийт элсэгчдийн 1,038 буюу 4.1 хувь нь мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжлүүдийг сонгон элсэж, тэдгээрийн 233 буюу 22.4 хувь нь эмэгтэй элсэгч байна.</p> <p><b>2021-2022 оны хичээлийн жилд:</b> Нийт 30.545 элсэгч их дээд сургуульд элсэн орсон байна. Нийт элсэгчдийн 3,283 буюу 10.7 хувь нь боловсролын салбарын мэргэжлүүдэд элсэж, тэдгээрийн 573 буюу 17.4 хувь нь эрэгтэй элсэгч байна. Тус салбарт элсэгчдээс сургуулийн өмнөх болон бага ангийн багш мэргэжлээр элсэгч 842 байгаагийн 20 нь эрэгтэй элсэгч байна.</p> <p>Нийт элсэгчдийн 3,920 буюу 12.8 хувь нь шинжлэх ухаан, технологи, инженерчлэлийн салбар, математикийн чиглэлийн мэргэжлүүдийг сонгон элсэж тэдгээрийн 1,181 буюу 30.1 хувь нь эмэгтэй элсэгч байна.</p> <p>Нийт элсэгчдийн 1,655 буюу 5.4 хувь нь мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжлүүдийг сонгон элсэж, тэдгээрийн 375 буюу 22.6 хувь нь эмэгтэй элсэгч байна.</p> <p>Цаашид ЖЭТБХТХ-д заасан тусгай арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх талаар анхаарах шаардлагатай.</p>



### 3.2.2. Салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт

ЖЭТБХТХ-ийн 19.1-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг заасан.

Тодруулбал, тус хуулийн 19.1.1-д тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах; 19.1.3-т салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгийн төслийг жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийсэн үнэлгээний тайлан, зөвлөмжийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлэх үүрэгтэйг заасан.

Энэ хүрээнд салбар, орон нутаг бүрт өөрийн болон оролцооны үнэлгээг хийж гүйцэтгэн тэдгээрт суурилсан 14 салбарын жендэрийн бодлого, 21 аймаг, нийслэл 9 дүүрэгт жендэрийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж, олон улсын түвшинд сайн туршлага болж байна.

ЭЗХЯ нь хэрэгжүүлэх чиг үүргийн онцлогоос хамаарч тусдаа салбарын жендэрийн бодлого батлан гаргахгүй бөгөөд бусад салбар, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, зохицуулалтад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, удирдамж заавраар ханган ажиллах үүрэг хүлээн ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагад хэрэгжих жендэрийн бодлого нь 2018-2021 онд хэрэгжиж дууссан бөгөөд дараагийн шатны бодлогыг боловсруулахаар ажиллаж байна. Орон нутгийн түвшинд нийт 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн жендэрийн бодлого батлагдан хэрэгжсэнээс 20 нь хэрэгжиж дууссан, хэрэгжиж байгаа 11 дэд хөтөлбөр байна.

### 3.2.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэн, Монгол Улсын хөгжлийн дараа жилийн төлөвлөгөөг баталдаг.



Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд салбар, орон нутгийн тулгамдаж буй асуудлыг шийдэх арга хэмжээнүүд, түүнд зарцуулагдах төсвийн төлөвлөлт тусгагддаг.

2022, 2023 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийн тодруулахад яамд, нутгийн захиргааны байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар, орон нутгийн жендэрийн бодлоготой уялдуулан батлан хэрэгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг төрийн бодлого төлөвлөлтөд нэгтгэх, тайлагнах чиглэлд ахиц гарч байгаа хэдий ч анхаарах асуудлууд байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эрэгтэй, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн практик асуудлыг шийдэхэд чиглэсэн 5 арга хэмжээ, стратегийн 3 арга хэмжээг төлөвлөсөн байна.

Харин 2023 оны төлөвлөгөөнд салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг тусгаагүйн зэрэгцээ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй шууд уялдах цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс өөрөөр өмнөх жил хэрэгжсэн онцгой ач холбогдолтой зарим арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн практик асуудлыг шийдэхэд чиглэсэн 5 арга хэмжээ, тэдгээрийн 2 нь өмнөх арга хэмжээг үргэлжлүүлэхээр, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх, хот, сум, суурин доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай зэрэг орчин нөхцөлийг сайжруулах, ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ зэргийг төлөвлөсөн байна (Хүснэгт 19).





### Хүснэгт 19. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээ, 2022, 2023 он

2022 оны жилийн төлөвлөлт (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2023)	2023 оны жилийн төлөвлөлт (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2023)
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шууд чиглэсэн	
<ul style="list-style-type: none"> <li>• Яамдын жендэрийн салбар зөвлөлийн жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах</li> <li>• Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд жендэрийн бодлогын хэрэгжилтийг хангах</li> </ul>	
Жендэрийн практик хэрэгцээг харгалзсан арга хэмжээ	
<ul style="list-style-type: none"> <li>• Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>• “Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах</li> <li>• Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох</li> <li>• Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах</li> <li>• Хүүхдийн ялгаатай онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлэхэд бүх шатны байгууллагад дэмжлэг үзүүлэх г.м</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>• Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэх</li> <li>• Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх</li> <li>• Хот, сум, суурин доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах</li> <li>• Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх г.м</li> </ul>
Жендэрийн стратегийн хэрэгцээг харгалзсан арга хэмжээ	
<ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх,</li> <li>• Ажилтныг бүтэн бус цагаар, зайнаас, уртын ээлжээр ажиллуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон хөдөлмөр, цалин хөлсний уян хатан зохицуулалтыг бий болгох</li> <li>• Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах</li> </ul>
Эх сурвалж: <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709935321&amp;showType=1">https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709935321&amp;showType=1</a>	Эх сурвалж: <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530576060701&amp;showType=1">https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530576060701&amp;showType=1</a>

Цаашид ядуурлыг бууруулах, хөнгөлөлттэй зээл олгох, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөхөд дэмжлэг туслалцаа шаардлагатай эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг харгалзах, шалгуур үзүүлэлт, хүрэх наад захын түвшинг тодорхойлж нэгтгэх хүрээнд тухайн арга хэмжээнд холбогдох өнөөгийн суурь түвшинг тодорхойлох, улмаар бодлого төлөвлөлтөд нэгтгэх жендэрийн дүн шинжилгээний чадамжыг бэхжүүлэхэд анхаарч байна.

Түүнчлэн нийтлэг ажиглагдаж буй дутагдал бол Жендэрийн салбар зөвлөл болон салбар хороо нь тогтсон хугацаанд үйл ажиллагаагаа төлөвлөж, салбар, орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд бүрэн гүйцэт нэгтгэж чаддаггүй байдал ажиглагдаж байна.

Энэ нь салбар зөвлөл, хороод тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэхээс өмнө, цаг хугацаанд нь хуралдаж, төлөвлөгөөг албажуулж хэвшээгүй байгаатай холбоотой.

Түүнчлэн жендэрийн асуудлыг салбарын бодлого төлөвлөлтөөс тусад нь авч үздэгээс шалтгаалан яамдын салбарын бодлого төлөвлөлт хариуцсан нэгжийн жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг бодлого төлөвлөлтөд нэгтгэх оролдлого бага байна.

2022 оноос яамдын Бодлого төлөвлөлтийн газрын удирдлагын жендэрийн тэгш байдлыг хангах талаарх манлайллыг бэхжүүлэх зорилгоор улирал тутмын уулзалтыг зохион байгуулан, арга зүйн зөвлөмж, удирдамжаар хангаж, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласан боловч ирц 50 хүрэхгүй хувьтай байгаа нь анхаарах асуудал юм.

Иймээс удирдах ажилтны хүлээх үүрэг, хариуцлагын хөшүүрэг, зохицуулалтыг бий болгож, жендэрийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлтөд тусгах салбар дундын зохицуулалтыг сайжруулахад тогтолцооны түвшинд шийдвэрлэх асуудлууд бий болж байна.

### **3.3. Жендэрийн статистик ба хүйсээр ангилсан мэдээллийн бүрдүүлэлт, ашиглалт**

Тогтвортой хөгжлийн зорилт 2030-ын “Жендэрийн тэгш байдлыг хангах охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, бодлого төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэхэд хүйсээр ангилсан статистик мэдээллийн тогтолцоо чухал үүрэгтэй.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/173 тоот тушаалаар 141 үзүүлэлтийн хүрээ, жендэрийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг тус тус баталсан. Үндэсний статистикийн хорооны нээлттэй мэдээллийн сан цахим хуудасны “Жендэр” цэснээс 59 жендэрийн үзүүлэлтийг шууд, бусад мэдээллийн цэснээс 141 жендэрийн үзүүлэлтийг татан үзэх боломжтой.



Түүнчлэн ЖҮХ-ны цахим хуудас болон тус хуудастай холбосон [www.tentsuu.mn](http://www.tentsuu.mn), [www.gender.hub.mn](http://www.gender.hub.mn) цахим хуудсуудаар дамжуулан жендэрийн судалгаа дүн шинжилгээ, төрөлжсөн мэдээллийг авах боломж бүрдсэн.

ЖҮХ нь 2020 оноос эхлэн аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн хүйсийн мэдээг Үндэсний статистикийн хорооны аргачлалын зөвлөлөөр хэлэлцүүлж, батлагдсан маягт, нөхөх зааврын дагуу холбогдох мэдээллийг программаар хүлээн авч байгаа бөгөөд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан тус маягт, нөхөх зааварт ойлголт, тодорхойлолт, нэр томъёолол, төрлийн хувьд холбогдох өөрчлөлтийг тусгаж, Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн А/105, А/106 тоот тушаалаар шинэчлэн баталж, мөрдөж байна.


Шинэчлэн батлагдсан маягт, нөхөх заавар нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн насны бүлгийг 18-24, 25-34, 35-44, 45-54, 55, түүнээс дээш гэсэн нарийвчлалтай гаргахаар заасан.

ЖҮХ хуульд заасны дагуу жендэрийн статистик мэдээллийн цуглуулалт, бүрдүүлэлтэд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа бөгөөд Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт зааврын дагуу жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайлан мэдээг 16 жендэрийн салбар зөвлөл, 31 жендэрийн салбар хороодоос хүлээн авч нэгтгэн, нэгдсэн мэдээллийг цахим сайтад байршуулан ажиллаж, бодлого төлөвлөлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглаж байна.

НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж буй төслийн дэмжлэгтэйгээр “Иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь эмэгтэйчүүд”, “Төрийн улс төр, төрийн захиргааны удирдах албан тушаал дахь эмэгтэйчүүд” гэсэн 2 төрлийн статистик эмхэтгэлийг анх удаа боловсруулан гаргалаа.

Улс төрийн салбарын жендэрийн статистикийг тогтмол гаргах маягтуудыг бэлтгэж турших ажил хийгдэж байна.

2021 оны байдлаар 4 яам, нийслэлийн 3 дүүрэг, 2022 онд 3 яам, 1 аймгаас бусад нь жендэрийн сатистик мэдээлэл гаргаж байгаагаа тайлагнасан байна.



ЭТХЯ зэрэг зарим яамдад статистикийн бие даасан газар нэгжүүд байгуулагдаж, бодлого төлөвлөлтөд захиргааны болон албан ёсны статистикийг ашиглах, нэн ялангуяа хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн статистикийг хэрэглэх, ашиглах боломжийг улам бүр нэмэгдүүлж жендэр статистикийг бүрдүүлэлт, хөгжүүлэлтэд чухал хувь нэмэр оруулж байна.

Салбарын яамдын хувьд төрийн үйлчилгээний үр шим хүртэгчдийн судалгааг гаргах хүрээнд зарим ахиц гарч байна. Тухайлбал, Соёлын яам 2021 онд 19 иргэнд тусгай зөвшөөрөл олгосноос 17 нь эрэгтэй, 2 нь эмэгтэй, БХБЯ 2021, 2022 онд нийт 219 иргэнд тусгай зөвшөөрөл олгосноос 158 эрэгтэй, 61 эмэгтэй байна.

БОАЖЯ зэрэг зарим яамдын хувьд аж ахуйн нэгж байгууллагад тусгай зөвшөөрөл олгодог, тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран зарим тохиолдолд орон нутгаас олгогддог, зөвшөөрлийн нэгдсэн системийг бий болгохоор ажиллаж байгаа тул тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоон мэдээллийг нарийвчилсан байдлаар гаргаж өгөх боломжгүй байгаа талаар тайландаа дурдсан байна.

Хэдийгээр арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаж байгаа ч хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлж, нэгтгэх, бодлого төлөвлөлтөд үр дүнтэй ашиглах туршлага дутмаг байгаа нь цуглуулж нэгтгэсэн мэдээллийг төлөвлөлтөд тусгахад хүндрэл учруулж байна.

Тухайлбал, ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд гэрийн хөлсгүй хөдөлмөрийг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан хувь нэмэр хэмээн үнэлэн тооцох талаарх зөвлөмж өгсөн хэдий ч Үндэсний статистикийн хорооноос тодорхой давтамжтайгаар хийж ирсэн цаг ашиглалтын түүвэр судалгааг энэхүү зорилгод үр дүнтэй ашиглаж, тодорхой үр дүн гаргаж чадахгүй байна.

Иймээс ХНХЯ, ЖҮХ, Үндэсний статистикийн хороо хамтран холбогдох, зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэхэд тодорхой алхмыг ойрын хугацаанд эхлүүлэх шаардлагатай байна.



## ДӨРӨВ. ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН

### 4.1. Улсын төсвийн санхүүжилт, хэрэгжилт, тайлагналт

Монгол Улсын төсвийн тогтолцоо нь жендэрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэх үндсэн бодлогын хэрэгсэл бөгөөд түүнийг нэвтрүүлэх зорилтыг анх 2013 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2013-2016)”-д тусгаж, ажлыг эхлүүлсэн бөгөөд хэрэгжилт **30% буюу “хэрэгжилт хангалтгүй”** байна.

Тус зорилтыг анх Засгийн газрын 2013 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2013-2016)”, дараа нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017-2021), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-т тус тус тусгаж үе шаттай хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсөв батлахдаа Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)”-ийн хэрэгжилтэд зориулж 300.0 сая төгрөгийг баталж<sup>2</sup>, байсан бол Монгол Улсын ЗГҮАХХАХ (2020-2024)-нд нийт 1 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна.


ЖҮХ-ны Ажлын албаны 2021 оны нийт төсвийн 54.2%, 2022 оны нийт төсвийн 70% нь техник тусламж, олон улсын байгууллагын санхүүжилт дэмжлэгийн эх үүсвэртэй байна.

Өөрөөр хэлбэл, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төсвийн дийлэнхийг олон улсын хөгжлийн албан ёсны түншлэгчид олгожээ.

Энэ төлөв 2020 оны төлөвтэй адил бөгөөд харин 2021 онд цар тахлын үед улсын төсөв ялимгүй буурч, 2022 онд өмнөх онуудын төлөвт хүрч өссөн байна.

Цаашид хөгжлийн албан ёсны түншлэгчдийн санхүүгийн дэмжлэгтэй уялдан жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилт хэрхэх вэ гэдэгт анхаарал хандуулах, тэрчлэн улс, орон нутгийн төсвийн санхүүжилтийг тогтвортой нэмэгдүүлэх шаардлагатай.

<sup>2</sup> Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2019 оны үйл ажиллагааны тайлан



**График 14.** ЖҮХ-ны Ажлын албаны үйл ажиллагааны санхүүжилт төгрөгөөр, 2021, 2022 он



Эх суралж: ЖҮХ-ны Ажлын албаны санхүүгийн тайлан, 2021, 2022 <sup>3</sup>

**Хүснэгт 20:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилт, мянган төгрөгөөр, 2011-2022 он

Он	Улсын төсөв: ЖҮХ-ны Ажлын албаны төсөв санхүүжилт	Улсын төсөв: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн санхүүжилт	Орон нутгийн санхүүжилт	Олон улсын байгууллага, төслийн санхүүжилт (ЖҮХ-ны Ажлын алба)	Яамдын санхүүжилт	Бүгд
2011	45,735.0	-	-	228,200.0	-	273,935.0
2012	86,896.0	-	-	144,949.0	-	231,845.0
2013	-	-	-	-	-	-
2014	223,891.7	-	-	247,051.8	-	470,943.5
2015	-	-	-	-	-	-
2016	-	-	-	-	-	-
2017	-	200,000.0	-	-	-	200,000.0
2018	-	300,000.0	189,000.0	882,700.0	-	1,371,700.0
2019	406,809.3	300,000.0	766,100.0	232,204.4	464,000.0	2,169,113.7
2020	355,900.0	200,000.0	478,400.0	489,000.0	-	1,523,300.0
2021	350,705.4	0	2,200,614.9	415,492.7	45,331.9	3,012,145.0
2022	277,705.6	0	2,321,671.0	639,834.0	434,754.0	3,673,965.0

Эх үүсвэр: ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ЖҮХ-ны ажлын албаны 2021, 2022 оны санхүүгийн тайлан, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц үр дүнгийн 2021, 2022 оны цахим тайлан.

<sup>3</sup> Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2021, 2022 оны санхүүгийн тайлан





Салбарын жендэрийн бодлогын тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт нь төсвийн төлөвлөлтийн календарьт хугацаанд нийцэж байгаа эсэх, тухайн салбарт Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх чадавх бүрдсэн эсэхээс ихээхэн хамааралтай.

Санхүүжилт аль ч түвшинд нэмэгдсэн нь сайн хэдий ч жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний бодлого төлөвлөгөөний зорилт хүрэх үр дүнтэй харьцуулахад төдийлөн хангалттай биш байна. Тухайлбал, 2021 онд ГХЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ, Сангийн яам, ЗТХЯ **45331.9** мянган төгрөг зарцуулснаас 70% нь улсын төсөв, Сэлэнгэ, Хөвсгөл аймгаас бусад 19 аймаг, Баянзүрх, Багахангай дүүргээс бусад 7 дүүрэг, нийт **2200614.9** мянган төгрөг зарцуулснаас 65% нь улсын төсвийн санхүүжилт байна.


2022 онд ЗТХЯ, Сангийн яам, УУХҮЯ, ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, ЭХЯ нийт 434754.0 мянган төгрөг зарцуулснаас 5% нь улсын төсөв, 95% нь гадаадын техник тусламжийн хөрөнгө, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ аймгаас бусад 18 аймаг, нийслэл болон Багахангай, Баянзүрх, Чингэлтэй дүүргээс бусад 6 дүүргийн хувьд нийт **2321671 мянган төгрөг** зарцуулснаас 72% нь улсын төсөв, 28% нь олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө байна.

Түүнчлэн жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд орон нутгийн түвшинд харилцан адилгүй төсөв зарцуулж байна, тухайлбал 2021 онд аймгууд 2-250 сая хүртэлх төгрөг, дүүргийн түвшинд 11.7- 539 сая хүртэлх төгрөг зарцуулсан бол 2022 онд аймгууд 4,7- 352 сая хүртэлх төгрөг, дүүргийн түвшинд 6,7- 921 сая хүртэлх төгрөг зарцуулсан байна.

#### **4.2. Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт арга зүй нэвтрүүлэх үйл явц, үр дүн**

Монгол Улсын төсвийн тогтолцоо нь жендэрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэх үндсэн бодлогын хэрэгсэл бөгөөд Засгийн газраас жендэрийн тэгш байдлыг хангах талаар системтэйгээр уялдуулан үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлт, төсөв боловсруулах үе шатуудад ил тод байдлыг хангах, төсвийн зарлага, санхүүгийн эгэх хариуцлага (PEFA)-ын үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх томоохон зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги (2022-2031)-д тусгагдсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлэх 3 дугаар зорилгын “жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх түвшинд нэвтрүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд Засгийн газар, Сангийн яам нь үр дүнд суурилсан төсөв, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тогтолцоог бүх шатны байгууллагуудад нэвтрүүлэх, онол, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.



Тогтвортой хөгжлийн үндэсний хороо (ТХҮХ) 2022 оны 8-р сарын 12-ны өдрийн ээлжит хуралдаанаараа тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрүүдийг татах, хөгжлийн бодлоготойгоо уялдуулах гол хэрэгсэл болох **Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги** (ҮСНС)-ийн төслийг авч хэлэлцэн, дэмжсэнээр Монгол Улс энэхүү үндэсний санхүүжилтийн стратегийг анхлан хэрэгжүүлэх улс орны нэг боллоо.

Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, үр дүнд чиглэсэн, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх, өрийн тогтвортой байдлыг хангах, шинэлэг, ногоон санхүүгийн хэрэгслүүдийг хөгжүүлэх, Байгаль Орчин Нийгэм Засаглал (БОНЗ)-ын тайлагналын стандартыг нэвтрүүлэх, тогтвортой хөгжилд эерэг үр нөлөө бүхий хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг олон чухал арга хэмжээ энэхүү стратегид туссан.

Тус стратегийн гол агуулгад төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор байгаль орчны татварын шинэчлэл, орлогын тэгш бус байдлыг багасгах татваруудыг нэвтрүүлэх, татварын удирдлагыг боловсронгуй болгох замаар татварын бааз суурийг өргөтгөх, эдийн засгийн төрөлжилт, өсөлтийг дэмжих зорилгоор жижиг, дунд үйлдвэрүүдэд тулгарч буй санхүүжилтийн бэрхшээлийг бууруулах, хөрөнгө оруулалтаар дэмжих болон эрх зүйн орчинг таатай болгох, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгохын тулд жендэрийн тэгш байдлыг хангах зарчмууд тусгагдсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийн 60%-аас доошгүйг эмэгтэйчүүд эзэмшдэг боловч тэдгээрийн 70% нь санхүүжилт огт авдаггүй эсвэл хангалтгүй авдаг, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин 52%, дээд шатны удирдлагын зөвхөн 29% нь эмэгтэйчүүд байгаа тул хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгохын тулд тэгш оролцоог хангах шаардлагатайг энэхүү стратеги онцолж байна.

Түүнчлэн тус стратегид 1/хувийн хэвшлийн санхүүжилтэд жендэрийн мэдрэмжтэй, үр дүнд суурилсан төсөвлөлт нэвтрүүлэх, 2/экспорт, жижиг, дунд үйлдвэрийг санхүүжүүлэх, баталгаа батлан даалт гаргах зэргээр эдийн засгийн төрөлжилтийг дэмжих албан институцуудыг байгуулах, жендэрийн тэгш байдлыг хангах зэргээр макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх талаарх чиглүүлэх стратегийг тусгасан.

Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо, Удирдлагын академийн зүгээс хөгжлийн хөтөлбөр, төслүүдтэй хамтран жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын түвшинд нэвтрүүлэх туршилтын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллалаа.



**Хүснэгт 21.** Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хүрээнд захиргааны төв болон орон нутгийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах үйл ажиллагаа

Чадавхжуулах үйл ажиллагаа	Он	Зохион байгуулагч	Санхүүжүүлэгч	Оролцогчид
“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт: Чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн Модуль 1, 2, 3 сургалт	2021	Сангийн яам	Дэлхийн банк	Яамд
Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт: Чадавх бэхжүүлэх зааварчилгаа, маягт	2022	Сангийн яам	Дэлхийн банк	Яамд

Сангийн яамнаас Засгийн газрын төсөв боловсруулах үйл явцад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэгтгэх хүрээнд Европын холбоо (ЕХ)-ны санхүүжилттэй Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх” төсөлтэй хамтран ажиллаж, дараах эхлэлийн алхмыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:


-Жендэрт нийцсэн бодлого төлөвлөлт, төсөвлөлтийн талаарх Засгийн газрын амлалтыг нэмэгдүүлсэн. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө” (2022-2031)-нд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх шатанд нэвтрүүлэх зорилтыг тусгасан;

-Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлагналын чухал урьдач нөхцөл болох жендэрийн статистикийг боловсронгуй болгох ажлуудыг үе шаттай хэрэгжүүлсэн. Татвар, Нийгмийн даатгал, Банкны салбар / зээл, хадгаламж/, Аж ахуйн нэгжийн бүртгэл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон зарим салбар дахь жендэрийн статистик, хүйсээр ангилсан мэдээллийн бүрдүүлэлт ашиглалыг сайжруулсан;

-Жендэрийн бодлого төлөвлөлт, төсөв боловсруулах чадавхыг нэмэгдүүлсэн. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, холбогдох сургалтыг зохион байгуулж, 300 эмэгтэй, 200 эрэгтэй хамруулсан;

-Сангийн яам болон Төсвийн захирагч нарт жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн 8 жилийн замын зураглалын төслийг боловсруулсан. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн байнгын үйл ажиллагааг бий болгох; жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хэрэгслийг төлөвлөлтийн явцад нэгтгэх; жендэрийн мэдрэмжтэй гүйцэтгэлийн тайлан, ил тод байдлыг сайжруулах алхмуудыг туршсан;

-Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үйл явцад шинэ байгууллагуудыг татан оролцуулсан. Үндэсний аудитын газар, Эдийн засаг, хөгжлийн яам,



Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын Их Хурал зэрэг байгууллагуудыг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиглэлээр сургах, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах алхмуудыг хийсэн;

**-Монгол Улсын жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн загвар, Жендэрийн мэдрэмжтэй төсөв, санхүүгийн удирдлагад нэгтгэх 9 алхмыг тодорхойлсон.** 2022, 2023 онд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн маягт, заавар, удирдамжийг боловсруулж, 2 төсвийн жилийн хүрээнд туршсан;

**-Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн суурь мэдээллийн урьдач нөхцөл, чадавхын үнэлгээ хийж гүйцэтгэсэн.** Үнэлгээгээр төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч нарын жендэрийн талаарх ойлголт мэдлэг зөрүүтэй, жендэрийн бодлогын баримт бичиг байгаа талаар мэдээлсэн ч, жендэрийн зөрүүг хэсэгчлэн баримтжуулж, салбарын бодлогын баримт бичигт нэгтгэсэн туршлага байхгүй байна.

Салбарын стратеги, бодлого нь тухайн салбарын болон салбар дундын жендэрийн бодлоготой төдийлөн уялдаагүй, хүйсээр ангилсан болон жендэрийн статистик мэдээлэл байхгүй эсхүл зарим өгөгдөл байгаа боловч түүнийг ашигладаггүй гэж мэдээлсэн байна.

ЖҮХ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд зарцуулах төсөв, түүний гүйцэтгэлийн мэдээллийг салбар зөвлөл болон хороодын жендэрийн мэргэжилтнүүдээр дамжуулан Үндэсний статистикийн хорооны цахим програмаар хүлээн авч байгаа бөгөөд цаашид Сангийн яамны жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэх арга хэмжээтэй нэгтгэж, үйл ажиллагааны давхардлыг арилгахад анхаарах шаардлагатай.

Сангийн яамнаас 2022 онд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг туршин хэрэгжүүлэх хүрээнд бүх яамдын төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, ЖМТ-НМ-01, ЖМТ-НМ-02 маягтыг бэлтгэн хүргүүлсэн. ЖМТ-НМ-01 маягт нь ЖМТийн суурь мэдээллийн урьдач нөхцөл болон дотоод чадавхын үнэлгээ, ЖМТ-НМ-02 маягт нь 2023 оны төсвийн жилд төлөвлөсөн жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулж буй үйл ажиллагааны тойм мэдээллийг тусгасан.

БШУЯ, ХНХЯ-нд зориулан ЖМТ-НМ-02 маягт гаргаж өгсөн ба тус маягт нь жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн 2023 оны төсвийн саналыг бэлтгэхэд зориулагдсан.

Цаашид улсын төсвөөс жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг туршин хэрэгжүүлсэн яамдаас



туршилтын үр дүнд ямар хүчин зүйлс нөлөө үзүүлж байгааг тодруулах шаардлагатай. БШУЯ 2022 онд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд зохих хэмжээний төсөв зарцуулаагүй хэвээр, харин ХНХЯ 61 сая төгрөг төсөвлөж, 56 сая төгрөг зарцуулсан бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг хөгжлийн түншлэгчдийн техник тусламж, дэмжлэгийн хүрээнд авчээ.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх ажил эхэлсэн ч туршилт хийж буй хоёр яамны хувьд жендэрийн мэдрэмжтэй төсвийн талаарх ойлголт мэдлэг тааруу, төлөвлөх, тайлагнахдаа жендэрийн үзэл баримтлалын үүднээс хандах үр чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Тодруулбал, Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг туршихаар сонгогдсон яамдын нэг болох БШУЯ нь 2020-2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламжид 2020 онд 166 төсөл арга хэмжээнд 86,145.5 тэрбум төгрөг, 2021 онд 149 төсөл, арга хэмжээнд 33,687.4 тэрбум төгрөг, 2022 онд 189 төсөл, арга хэмжээнд 118,117.8 тэрбум төгрөг, нийт 504 төсөл, арга хэмжээнд 237,950.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Үүний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 50, 100, 150, 200, 240, 280, 320 ортой нэг маягийн болон тухайлсан зураг төсвөөр ашиглалтад оруулсан барилга байгууламж 7,435 ортой 54 барилга 2020 онд, 5,535 ортой 35 барилга 2021 онд, 7,070 ортой 39 барилга 2022 онд, нийт 20,040 ортой 128 барилга тус тус ашиглалтад оруулсан байна.

БШУЯ нь хүүхдээ асарч буй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд чухал нөлөөтэй жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт болох хүүхэд асаргаа болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж, тэдгээрийн өргөтгөлд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хэдий ч ийнхүү холбож тайлагнаагүй байна.

**Хүснэгт 22.** Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээний төсөл арга хэмжээ, санхүүжих дүн, 2020-2022 он

№	Огноо	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая төг/	Санхүүжих дүн / сая төг /
1	2020	166.0	242,260.90	86,145.50
2	2021	149.0	248,164.50	33,687.40
3	2022	189.0	449,857.20	118,117.80
	<b>Дүн</b>	<b>504.0</b>	<b>940,282.60</b>	<b>237,950.70</b>

**Хүснэгт 23.** 2020-2022 онд ашиглалтад орсон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга байгууламж

№	2020 он		2021 он		2022 он		2020-2022 он	
	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал
1	54	7,435	35	5,535	39	7,070	128	20,040

Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах, гүйцэтгэлийн үр дүнтэй уялдуулан урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараах эрх зүйн актыг боловсруулан, Засгийн газрын тогтоол болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын үндсэн цалингийн доод хэмжээг өмнөх сүлжээний 5 дугаар шатлалын түвшинд тогтоож, 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж ажилласан.

**Хүснэгт 24.** Цалингийн сүлжээний шатлал (Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл				
	ТҮБД-1	ТҮБД-2	ТҮБД-3	ТҮБД-4	ТҮБД-5
1	587,385.0	703,623.0	749,728.0	818,762.0	885,763.0
2	591,812.0	709,224.0	755,608.0	825,523.0	893,200.0
3	603,058.0	723,450.0	770,545.0	842,702.0	912,097.0
4	631,589.0	759,541.0	808,442.0	886,281.0	938,498.0
5	663,418.0	799,806.0	850,717.0	934,899.0	964,899.0

**Хүснэгт 25.** Цалингийн сүлжээний шатлал (Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол)

Цалингийн өсөлт	Албан тушаалын зэрэглэл				
	ТҮБД-1	ТҮБД-2	ТҮБД-3	ТҮБД-4	ТҮБД-5
Дундаж	663,418.0	799,806.0	850,717.0	934,899.0	964,899.0

ТҮБД 3-1, 3-2 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 14,957 багшийн цалин 13 хувиар, ТҮБД 3-3 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 4,729 багшийн цалин 10 хувиар, ТҮБД





3-4 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 4,733 багшийн цалин 5 хувиар, ТҮБД 3-1, 3-2, 3-3 шатлалд хамрагдаж байсан СӨБ-ийн 5,361 багшийн цалин 11-14 хувиар, ТҮБД 3-4 шатлалд хамрагдаж байсан СӨБ-ийн 1,198 багшийн цалин 5 хувиар тус тус нэмэгдсэн.

**Хүснэгт 26. Цалингийн сүлжээний шатлал (Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол)**

Цалингийн сүлжээний шатлал	ЕБС Албан тушаалын зэрэглэл			СӨБ Албан тушаалын зэрэглэл		
	ТҮБД-3	Багшийн тоо	Нэмэгдсэн хувь	ТҮБД-4	Багшийн тоо	Нэмэгдсэн хувь
1	749,728.0	7,720.0	13%	818,762.0	2,134.0	14%
2	755,608.0	7,237.0	13%	825,523.0	2,087.0	13%
3	770,545.0	4,729.0	10%	842,702.0	1,140.0	11%
4	808,442.0	4,733.0	5%	886,281.0	1,198.0	5%
5	850,717.0	9,207.0	0%	934,899.0	2,587.0	0%
Хамгийн их	850,717.0	33,626.0	13%	934,899.0	9,146.0	14%
Хамгийн бага	749,728.0	7,237.0	0%	818,762.0	1,140.0	0%
Дундаж	787,008.0	6,725.2	8%	861,633.4	1,829.2	9%

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн “Төрийн өмчит болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 дугаар тушаалыг батлан, батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжихээр тусгасан.

**Хүснэгт 27. Үндсэн цалингийн өсөх хувь (Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122-р тушаалаар шинэчилсэн)**

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл				
	ТҮБД-1	ТҮБД-2	ТҮБД-3	ТҮБД-4	ТҮБД-5
5	757,907.0	911,443.0	1,005,130.0	1,063,537.0	1,126,198.0

Ингэснээр өмнөх цалингийн сүлжээнээс (Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472-р тогтоолоор) ТҮБД 3-1, 3-2 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 14,957 багшийн цалин 33-34 хувиар, ТҮБД 3-3 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 4,729 багшийн цалин 30 хувиар, ТҮБД 3-4 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 4,733 багшийн цалин 24 хувиар, ТҮБД 3-5 шатлалд хамрагдаж байсан ЕБС-ийн 9,207 багшийн цалин 18 хувиар, ТҮБД 3-1, 3-2, 3-3 шатлалд хамрагдаж байсан СӨБ-ийн 5,361 багшийн цалин

29-30 хувиар, ТҮБД 3-4 шатлалд хамрагдаж байсан СӨБ-ийн 1,198 багшийн цалин 20 хувиар, ТҮБД 3-5 шатлалд хамрагдаж байсан 2,587 багшийн цалин 14 хувиар тус тус нэмэгдсэн.

**Хүснэгт 28.** Үндсэн цалингийн өсөх хувь /Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122-р тушаалаар шинэчилсэн./

цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл /ЕБС/			Албан тушаалын зэрэглэл /СӨБ/		
	ТҮБД-3	Багшийн тоо	Нэмэгдсэн хувь	ТҮБД-4	Багшийн тоо	Нэмэгдсэн хувь
1	749,728.0	7,720.0	34%	818,762.0	2,134.0	30%
2	755,608.0	7,237.0	33%	825,523.0	2,087.0	29%
3	770,545.0	4,729.0	30%	842,702.0	1,140.0	26%
4	808,442.0	4,733.0	24%	886,281.0	1,198.0	20%
5	850,717.0	9,207.0	18%	934,899.0	2,587.0	14%
Хамгийн их	850,717.0	33,626.0	34%	934,899.0	9,146.0	30%
Хамгийн бага	749,728.0	7,237.0	18%	818,762.0	1,140.0	14%
Дундаж	787,008.0	6,725.2	28%	861,633.4	1,829.2	24%

Багш нарын дундаж цалингийн өсөлт нь цалин хөлсний жендэрийн зөрүүг бууруулахад чухал нөлөөтэй.

Цалин хөлсний жендэрийн зөрүү нь эрэгтэй, эмэгтэйчүүд ялгаатай ажил хөдөлмөрийг ялгаатай салбаруудад төвлөрөн гүйцэтгэдэгтэй холбоотой байдаг.

Иймд эмэгтэйчүүд төвлөрөн ажилладаг нийгмийн үйлчилгээний салбарын цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилттой уялддаг.

Ийнхүү боловсролын салбар хүүхэд асардаг эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх боломжийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд зонхилон ажилладаг салбарын ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх замаар цалин хөлс дэх жендэрийн зөрүү нэмэгдэхээс сэргийлэхэд анхаарч төсвийн хөрөнгийг зарцуулахаар төсөвлөж, хэрэгжүүлж байгаа тул жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтөд анхаарч ажилласан хэмээн дүгнэж байна.

Цаашид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гол зарчим болох төсөвлөлтийн жендэрийн үр дүнг үнэлэх, илэрсэн сургамжийг шийдвэрлэх, мөн иргэний нийгмийн оролцоог хангах, төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах бүхий л үе шатанд жендэрийн агуулгыг нэвтрүүлэх шаардлагатай байна.



### 4.3. Орон нутаг ба байгууллагын хөгжлийн түвшний жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн арга зүй, туршилтын явц, үр дүн

Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо, Удирдлагын академийн зүгээс жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нутгийн захиргааны байгууллагын түвшинд нэвтрүүлэх туршилтын төсөл, хөтөлбөрийг Канад улсын Засгийн газраас санхүүжүүлж буй мерит төсөлтэй хамтран хэрэгжүүллээ.


Энэ хүрээнд Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн орон нутгийн удирдамж аргачлалыг туршиж, 4 аймгийн төсөв санхүү, хөрөнгө оруулалтын чиг үүрэг бүхий төрийн албан хаагчид болон иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллийг сургаж чадавхжууллаа.

Тухайлбал, 2022 онд Дорнод, Төв, Дундговь, Сүхбаатар аймгийн захиргааны ажилтнууд болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нийт 167 хүнийг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалтад хамрууллаа.

Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо, Удирдлагын академи, Мерит төсөл хамтран жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн орон нутгийн удирдамжийг турших явцад олж авсан туршлага сургамжийг үндэсний хэмжээнд хуваалцах, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд төрийн өндөр түвшний оролцоог нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, жендэрийн тэгш байдлыг хангах институцийн хэтийн төлвийн талаар нэгдмэл ойлголттой болох, олон улсад хэрэгжүүлж буй туршлагаас суралцах зорилгоор “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форумыг 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр танхим, цахим хосолсон хэлбэрээр анх удаа зохион байгуулж, Монгол Улсын бүх яам, 21 аймаг, зарим сумд, нийслэлийн төвийн 6 дүүргийн төрийн албан хаагчид, Монгол Улстай хамтран ажилладаг олон улсын байгууллагын нийт 130 хүн биечлэн танхимаар, 400 гаруй хүн цахимаар оролцлоо.

Тус форумаас 6 зүйл зөвлөмж гаргасан бөгөөд тус зөвлөмжид дараах гол агуулгуудыг тусгасан. Үүнд:

- төрийн бодлого, хөтөлбөрт жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг нэн тэргүүнд тавих, улс төрийн манлайлал, дэмжлэг, үүрэг амлалтыг хэрэгжүүлэх;
- жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг амжилттай хэрэгжүүлэхэд салбар, орон нутаг хоорондын ажил, чиг үүргийн уялдаа холбоог хангах;
- жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг төр, салбар, орон нутгийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, төсвийн бүхий л үе шатуудад тусгаж, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг үндэсний хэмжээнд үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэх;



- жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хүртээмжтэй, хариуцлагатайгаар хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд, иргэд олон нийт, бусад оролцогч талуудын идэвхтэй оролцоог хангаж, тэднийг бодлогын шийдвэр гаргахад оролцуулах, хяналтын тогтолцоог бий болгох;

- бодлого, хөтөлбөр, үйлчилгээний үр нөлөөг үнэлэхдээ нийгмийн бүлгүүдийн онцлогийг тусгасан, хүйсээр ангилсан тоон мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, жендерийн зөрүүтэй байдлыг бууруулахад чиглэсэн, нотолгоонд суурилсан бодлого боловсруулж, шийдвэр гаргаж, төсөвлөж, хэрэгжүүлж хэвших;

- төрийн бүх шатны албан хаагчдын жендэр, жендерийн тэгш байдал, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэн, чадавхыг бэхжүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

Тус форумын үр дүнд жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тогтвортой хэрэгжүүлэх бодлогыг системтэй төлөвлөн, үр дүнд хүргэх механизмыг бүрдүүлж ажиллах чиглэлд Засгийн газар, Сангийн яам, олон улсын хөгжлийн хөтөлбөр, салбар дундын болон орон нутаг хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлд Жендерийн үндэсний хороо, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн үндэсний чадавхыг бүрдүүлж, бэхжүүлэхэд Удирдлагын академи тус тус үүрэг амлалт авч, төрийн бусад бүх байгууллага шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган хэрэгжилтийг ханган ажиллахаар нэгдсэн зөвшилцөлд хүрсэн.

Цаашид үр дүнд суурилсан төсвийн шинэчлэлийн үйл явцад жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хэрхэн нэгтгэх, түүнийг бодитойгоор хэрэгжүүлэх арга зам, үе шатуудыг тодорхойлж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлага тулгарч байна.



## ТАВ. ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН

Яам, орон нутгийн бүх түвшинд бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулж, үнэн зөв, бодитой, бүрэн гүйцэд тайлагнахад суралцаж тодорхой ахицтай байгаа бөгөөд хэрэгжилт 50% буюу “хэрэгжих шатанд” байна.


Төрийн бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг жендэрийн мэдрэмжтэй арга зүйгээр дэмжих ажил үе шаттай хэрэгжиж байна. Тайлант хугацаанд ЗГХЭГ, ХНХЯ, Сангийн яам болон ЖҮХ-ноос зарим журам, заавар, зөвлөмж, аргачлал, маягтыг батлан, салбар зөвлөл, хороодод хүргэж ажилласан нь үндэсний, салбар, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг боловсронгуй болгоход хувь нэмэр орууллаа.

Тухайлбал, Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх шинэчилсэн журам, Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх зөвлөмж, Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх шинэчилсэн журам, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал удирдамж, 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл дэх тусгай маягт, Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн цахим тайлангийн маягт, бөглөх заавар удирдамж, “Аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн жилийн мэдээ”-г хүлээн авах маягт, бөглөх заавар, Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг баталж мөрдүүллээ.

Салбарын жендэрийн бодлого болон орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг мөрдүүлж, жендэрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл явцыг эргэн харах, бодлого төлөвлөлтийг тухай бүр үнэлж, сайжруулах боломжийг бий болгож ажиллалаа.

2022 онд “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал”-ыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2 дугаар тогтоолоор баталсан нь Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр тооцон тайлагнадаг “Эмэгтэйчүүд, бизнес ба хууль эрх зүй” индексийн Монгол Улсын одоогийн хүрсэн байгаа амжилтыг урагш ахиулахад чухал нөлөө үзүүлсэн байна.

Тус аргачлалыг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааны цар хүрээ, түвшин, нөхцөл зэрэгтээ



тохируулан хэрэглэх боломжтой бөгөөд цаашид аргачлалын талаарх мэдээллийг бүх нийтэд түгээхэд анхаарч ажиллаж байна.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн “Үлгэрчилсэн заавар”-ыг батлан төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагад хүргэн ажилласан нь тайлант хугацаанд хамгийн олон салбар, байгууллагыг хамарлаа.

Цаашид хууль, бодлогын хөтөлбөрийн төслийн нийгэм- жендэрийн үр нөлөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, оролцоонд суурилсан жендэрийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг салбар, орон нутгийн төрийн байгууллагуудад бүрдүүлэх анхаарч байна.

### **5.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, ахиц дэвшил**

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын жендэрийн тэгш байдлыг хангах талаарх чиг үүргийг ЖЭТБХТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (2020)-гээр зарим анхаарах асуудлыг илрүүлж зөвлөмж өгсөн.

Тухайлбал, салбарын яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын түвшинд хүйсээр ангилсан мэдээллийг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг үнэлэх, салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгийн төслийг жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийсэн үнэлгээний тайлан, зөвлөмжийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлэх, төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж ажиллах талаар зөвлөсөн байдаг.

Тайлангийн хугацаанд салбарын болон орон нутгийн жендэрийн 15 бодлого төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээг хөгжлийн түншлэгчдийн санхүүгийн дэмжлэгтэй тухайн салбар, орон нутгийн төрийн бус байгууллага, судалгааны байгууллагаар гэрээлж гүйцэтгүүлсэн байна.

Түүнчлэн ЗТХЯ зэрэг зарим салбарын яамдад статистик, судалгаа, дүн шинжилгээ хариуцсан бие даасан нэгж байгуулагдах хэрэгцээ шаардлагыг судалж, санал гаргаснаар Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Ажлын байрны жагсаалт, орон тоог шинэчлэн






батлах тухай” Б/55 дугаар тушаалаар Бодлого, төлөвлөлтийн газарт Судалгаа, стандарт статистикийн хэлтэс гэсэн бүтцийг шинээр бий болгосон байна.

Яам, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын 61% нь ЖЭТБХТХ-ийн 10, 19 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, чиг үүргийн хэрэгжилт **50-аас дээш хувь буюу “хэрэгжих шатанд”** байна. Тухайлбал, яамдыг үйл ажиллагааны болон хүрэх үр дүнгийн 41 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 50-аас дээш хувийн үнэлгээтэй 4 яам, нутгийн захиргааны байгууллагыг 31 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 50-аас дээш хувийн үнэлгээтэй 18 аймаг, 7 дүүрэг байна.

График 15. ЖЭТБХТХ-иар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, яамдаар, 2022 он



Тус үнэлгээг хийхдээ яамдын түвшинд ижил шалгуур үзүүлэлтүүдийг авч үнэлсэн бөгөөд хууль эрх зүйн болон бүтэц тогтолцооны ялгаатай байдлыг харгалзан зарим нэг шалгуурыг БХЯ-ны хувьд хэрэглээгүй болно. ХЗДХЯ, БХБЯ, ХНХЯ, ГХЯ тус тус хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт **50-аас дээш хувь буюу “хэрэгжих шатанд”** бусад яамдын хувьд хэрэгжилт хангалтгүй байна. (График 15)

Нутгийн захиргааны байгууллагуудын 2022 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үйл ажиллагааны болон хүрэх үр дүнгийн 4 бүлэг 30 дэд шалгуур үзүүлэлтээр үнэлж үзэхэд үнэлгээний нэгдсэн үр дүнгийн үзүүлэлтээр Ховд, Дундговь, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Булган, Төв, Хөвсгөл, Сүхбаатар, Дорнод, Дархан-Уул, Завхан, Архангай, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Говьсүмбэр аймаг, Сүхбаатар, Хан-Уул, Багахангай, Сонгинохайрхан, Налайх, Багануур, Баянгол дүүрэг тус тус **50-аас дээш хувь буюу буюу “хэрэгжих шатанд”** бусад аймаг, нийслэл, дүүрэг хэрэгжилт хангалтгүй байна. (График 17, 18)

График 16. ЖЭТБХТХ-иар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, аймаг, нийслэлээр, 2022 он





График 17. ЖЭТБХТХ-иар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, дүүргээр, 2022 он



**5.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ**

Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)”-ийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд 2021 онд тус хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээг судалгаа зөвлөх үйлчилгээний хөндлөнгийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн 6 зорилго, 59 дэд зорилтын хэрэгжилт **80.4%-тай** үнэлэгдсэн боловч цар тахлын нөхцөл байдал бусад хүчин зүйлсээс шалтгаалан тодорхойлсон зарим шалгуур үзүүлэлтийн хувьд хүрэх түвшинд хүрээгүй, хол зөрүүтэй байсан.

Иймд дээрх хэрэгжээгүй зорилт арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж үр дүнд хүргэх зорилгоор жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дараагийн бодлого төлөвлөлтийг боловсруулж батлуулсан бөгөөд өмнөх Үндэсний хөтөлбөрийн зорилтот түвшиндээ хүрээгүй цөөн зорилт арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан.

2022 оны жилийн эцсийн байдлаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн 2021 онд хэрэгжилт хангагдаагүй гэж үнэлэгдсэн 5 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуурын хэрэгжилтийг хангаж, бусад зорилт арга хэмжээний хэрэгжилтийг ахиулж, хэрэгжилт **95% буюу “тодорхой үр дүнд хүрсэн”** байна. (Хүснэгт 29)



**Хүснэгт 29.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн зорилт тус бүрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт, 2021, 2022 оны ахисан үзүүлэлтээр

Д/Д	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилтын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт, 2021 он	Зорилтын хэрэгжилтийн дотоод өөрийн үнэлгээ, ахиц дэвшил, 2022 он
2.2.1.	нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх.	<p><b>Хэрэгжилт 85.3%</b> Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөсөн дэд зорилтуудын хэрэгжилт сайн байгаа бол хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх дэд зорилтуудын хэрэгжилт цаг хугацааны хувьд нэлээд хожуу хэрэгжсэнээс уялдаа бүхий бусад арга хэмжээндээ нөлөөлсөн байна.</p>	<p><b>Хэрэгжилт-95%</b> Хөдөлмөрийн тухай хууль /ХтХ/ шинэчлэн батлагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдон дагаж гарах журам, стандартууд батлагдаж тодорхой үр дүнд хүрсэн байна. Хөдөлмөрийн тухай хуульд гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах, бүтэн бус цагаар ажиллах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн уян хатан зохицуулалт шинээр тусгагдсан.</p> <p>“Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх” зарчим тусгагдсан бөгөөд Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого, Адил үнэлэмж бүхий ажил хөдөлмөрт ижил тэгш цалин хөлс олгох аргачлал зэрэг эрхзүйн баримт бичгүүдийг албажуулж хэрэгжилтийг эхлүүлсэн.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/07 дугаар тушаалаар “Хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэх” журам батлагдаж, хамтын гэрээг харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллага бүртгэж, мэдээллийн сан бүрдэж байна.</p> <p>Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр 2022 оны жилийн эцэст нийт <b>2570 аж ахуйн нэгж</b> байгууллага, ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд хамтын гэрээ байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн байна.</p> <p>Түүнчлэн салбарын яамдаас салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын гэрээ, түүний агуулгыг судалж, зөвлөмж өгч ажиллах туршлагауд бий болж байна. Тухайлбал,</p>

№	Яамд	Хамтын гэрээ байгуулдаг салбарын аж ахуйн нэгж байгууллагын тоо			Хамтын гэрээнд ЖЭТБХТХ-ийн 11.2-т заасан арга хэмжээг тусгасан салбарын аж ахуйн нэгж байгууллагын тоо		
		2020	2021	2022	2020	2021	2022
1	ЭХЯ	22	24	27	18	20	24
2	ХХАА ХҮЯ	54	54	54	54	54	54
3	Соёлын яам	10	10	10	10	10	10
4	УУХҮЯ	20	20	20	20	20	20
5	ЗТХЯ	3	3	3	3	3	3
6	ЦХХХЯ	8	8	9	8	8	9
7	БХБЯ			26			26
Нийт		117	143	147	114	115	120

**Эрчим хүчний салбарын 2020-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн агуулгад** “Шинээр батлагдан гарсан хөдөлмөрийн харилцаа, хүний эрх болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хуулиудыг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг компанийн захиргаа, ҮЭ-ийн хороо хамтран зохион байгуулна.” (2.2.1), “Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудад чиглэсэн бодлого явуулж жендэрийн тэгш оролцоог хангаж, дарамт хүчирхийлэлгүй орчныг бүрдүүлнэ.”(2.2.2.)

**Агаарын тээврийн салбарын хамтын хэлэлцээрийн агуулгад** Эрэгтэй, эмэгтэй ажилтанд ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор ажил амралтын зохицуулалт, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нэмэгдэл хөлс олгох нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн хамгаалал, аюулгүй байдлыг хангах талаар талуудын хүлээх эрх үүрэг,

**Авто тээврийн салбарын хамтын хэлэлцээрийн агуулгад** Цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангах, нийгмийн түншлэлийн асуудал,

**Авто замын салбарын хамтын хэлэлцээрийн агуулгад** Цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал, ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх асуудал,



			<p>Барилга, хот байгуулалтын яам, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо ТББ, Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо ТББ-тай 2019-2021, 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын Хамтын хэлэлцээрийн агуулгад:</p> <p>6.19. Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “Ажил олгогч нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.” гэж заасны дагуу ЖЭТБХТХ тогтоомж, үндэсний хөтөлбөр, Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын зорилт, үйл ажиллагааг салбарт сурталчлах, хэрэгжүүлэх, чиглэлд хамтран ажиллах;</p> <p>6.20. “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх талаар гаргасан бодлогын зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын албан хаагчдын дунд санал асуулга явуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, ажлын ачаалал, хөдөлмөрийн цаг, нормыг баримтлан хэрэгжүүлэх;</p> <p><b>Барилга, хот байгуулалтын яам, Монголын барилгачдын нэгдсэн холбоо ТББ, Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо ТББ-тай хамтран 2019-2021, 2021-2022 онд байгуулсан Барилгын салбарын Хамтын хэлэлцээрийн агуулгад:</b></p> <p>5.1. Барилга, хот байгуулалтын салбарын хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт тусгагдсан ажлууд, түүний дотор, хүүхэд гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх, хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ,</p> <p>5.2. “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх талаар гаргасан бодлогын зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана,</p> <p>5.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг дагаж мөрдөх, мөрдүүлэх болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхал, хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байрны дарамт, жендэрт суурилсан хүчирхийллийг үл тэвчих, урьдчилан сэргийлэх, хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлд өмчийн хэлбэр үл харгалзан байгууллагууд тодорхой ажлууд зохион байгуулах, үүнтэй холбоотой асуудлуудыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжүүлнэ гэж тус тус заасан байна.</p>
--	--	--	---



<p>2.2.2.</p>	<p>жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх.</p>	<p><b>Хэрэгжилт 95.0%-ийн гүйцэтгэлтэй.</b></p> <p>Жендэрийн төлөв байдал, бодлого, хөтөлбөрт дүн шинжилгээ хийх дэд зорилтуудын хэрэгжилт сайн байгаа бол судалгаа, дүн шинжилгээний үр дүнд үндэслэн арга хэмжээ авах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх тал дээр хэрэгжилт хангалтгүй байна.</p>	<p><b>Хэрэгжилт 95%</b></p> <p>Жендэрийн төлөв байдал, бодлого, хөтөлбөрт дүн шинжилгээ хийх ажил эрчимжиж, нийт салбар орон нутгийн жендэрийн бодлогын хэрэгжилтийн үе шатны үнэлгээг цаг тухай бүрт хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж ажиллаж байна.</p> <p>Гэвч салбарын хууль, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөв байдалд жендэрийн дүн шинжилгээ хийх ажил дутмаг байгаагаас салбарын стратеги, улсын хөгжлийн жилийн төлөвлөлт, төсөвлөлтөд тусган хэрэгжүүлэх туршлага хангалттай бүрдэж чадахгүй байна.</p> <p>Цаашид жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал, удирдамжийг албажуулж, нэвтрүүлэх үйл явцыг хурдасгах шаардлагатай.</p>
<p>2.2.3.</p>	<p>эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх.</p>	<p><b>Хэрэгжилт 83.5%-ийн гүйцэтгэлтэй.</b></p> <p>Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх дэд зорилтуудын хэрэгжилт сайн байгаа бол дээд боловсролын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, тодорхой мэргэжлийн хүрээн дэх хүйсийн зохистой харьцааг хангах тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, хэвлэл мэдээллийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг дэд зорилтуудын чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч үр дүн нь хараахан гараагүй байна. Соёл урлагийн салбарт жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх дэд зорилтыг холбогдох яам хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай.</p>	<p><b>Хэрэгжилт 95%</b></p> <p>Соёлын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого батлагдаж, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний зорилт дахь салбарын хувь нэмрийг тодорхойлсон. Цаашид хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг нарийвчлан төлөвлөж, жил бүрийн хөгжлийн төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>Нийт 11 их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 30 гаруй хичээлийн агуулгад жендэрийн агуулга тусгасан, тодорхой мэргэжлийн хүрээн дэх хүйсийн зохистой харьцааг хангах тусгай арга хэмжээг боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн бөгөөд цаашид үр дүн, үр нөлөөг үнэлэх ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p>





2.2.4.	жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх.	<p><b>Хэрэгжилт 87.0%-ийн гүйцэтгэлтэй.</b> Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, ЖҮХ-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэгжүүдийг дэмжин ажиллуулах, сургагч багш бэлтгэх зэрэг дэд зорилтын хэрэгжилт сайн байгаа бол заавар, журам, сургалтын модулийг боловсруулах, тэдгээрийг сурталчлан таниулах чиглэлээр тавьсан дэд зорилтуудын хувьд тодорхой ажлууд хийгдсэн байна. Орон нутгийн захиргааны анхан шатны нэгж болон хувийн хэвшилд хүрч ажиллах чиглэлд эхлүүлсэн ажлаа улам бататган үргэлжлүүлэх сайжруулах шаардлагатай байна.</p>	<p><b>Хэрэгжилт 95%</b> Сургалтын тогтолцоог бэхжүүлэх ажлыг тогтмол давтамжтай үндэсний хэмжээнд зохион байгуулж ажиллалаа. Жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг төрийн албан хаагчийг мэргэшүүлэх хөтөлбөрүүдэд тусгалаа.</p> <p>Жендэр ба бодлого төлөвлөлт анхан шатны сургагч багшаар 250, Жендэрийн дүн шинжилгээ дунд шатны сургагч багшаар 25, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хөвгүүд эрэгтэйчүүдийн сургагч багшаар 51 багшийг бэлтгэж, сургалтуудыг салбар, орон нутагт тогтмол зохион байгуулж ажилласан.</p> <p>ЖҮХ, ХНХЯ, Сангийн яамнаас зарим журам, заавар, зөвлөмж, аргачлал, маягтыг батлан, салбар зөвлөл, хороодод хүргэж ажилласан нь үндэсний, салбар дундын, салбар, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад чухал үр нөлөө үзүүлсэн.</p> <p>Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг баталснаар хувийн хэвшлийн байгууллагуудад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтрүүлэх ажлын гол суурь тавигдсан.</p>
2.2.5.	хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.	<p><b>Хэрэгжилт 90.0%-ийн гүйцэтгэлтэй.</b> “Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах заавар боловсруулан ХЭҮК болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, холбогдох ажилтанд хүргүүлж, сургалтад хамруулах” 5.1 дэх дэд зорилтын хүрээнд 2021 онд тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн хэдий ч үр дүн нь хараахан гараагүй байна.</p>	<p><b>Хэрэгжилт 95.0%</b> Зөрчлийн тухай хуулийн 26.1 зүйлд заасан Ажлын байрны бэлгийн дарамт учруулах зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх талаарх зөвлөмж, үлгэрчилсэн заавар, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэж ажилласан.</p> <p>Нэг цэгийн үйлчилгээний төв 1, түр хамгаалах байр 2-оор нэмэгдүүлснээр түр хамгаалах байр 17, нэг цэгийн үйлчилгээний төв 18, нийт 35 байр үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Бэлгийн дарамтыг гэмт хэрэгт тооцох асуудлаар Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулахаар хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p>

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого зорилтын хэрэгжилтийг тухай бүр үнэлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж буй хэдий ч зорилтот түвшинд хүрээгүй, цаашид онцгой анхаарах зорилт, арга хэмжээ байсаар байна. Тухайлбал,

Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ хийгдсэн хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг шалгуур үзүүлэлтүүдийн хувьд ахиц дэвшил гараагүй хэвээр байна (Хүснэгт 30).

**Хүснэгт 30.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин, 2021, 2022 оны харьцуулалт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2015 он	2021 он	Зорилтот түвшин, 2021 он	Суурь үетэй харьцуулахад	
						2021 он	2022 он
1	Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг дотоод журамдаа тусгасан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	хувь	-	0.3	35	0.3%-аар нэмэгдсэн буюу бараг ахиц дэвшил гараагүй	20%, ахиц дэвшил гарсан. Дата мэдээллийн чанар дунд, цаашид цахим хэлбэрээр тайлан бүртгэлийг сайжруулах шаардлагатай.
2	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет, тусгай кабинет	тоо	11 0	35 4	35 30	24 нэгжээр нэмэгдэж, ахиц дэвшил гарсан.	Нарийн мэргэжлийн тусгай кабинетийн тоог 18-аар нэмэгдүүлж ахиц гарсан.
3	Монгол Улсын жендэрийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээ	тоо	-	1	1	Үнэлгээ хийгдэж, ахиц дэвшил гарсан.	Зорилтот түвшинд хүрсэн.
4	Яамд (салбар)-ын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн тоо	тоо	Яам-3 аймаг-3	Яам-9, аймаг, дүүрэг -30	бүх яам аймаг, дүүрэг -30	Хөтөлбөртэй болсон яамны тоо 6-аар, аймаг, дүүргийн тоо 27-оор нэмэгдэж ахиц дэвшил гарсан.	Зорилтот түвшинд хүрсэн.



№	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин 2015 он	2021 он	Зорилтот түвшин, 2021 он	Суурь үетэй харьцуулахад	
						2021 он	2022 он
5	Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийсэн яам (салбар), аймаг, дүүрэг	тоо	яам-3 аймаг, дүүрэг -0	яам-10 аймаг, дүүрэг -28	бүх яам аймаг, дүүрэг -30	Үнэлгээ хийсэн яамны тоо 7-оор, аймаг, дүүргийн тоо 28-аар нэмэгдэж, ахиц дэвшил гарсан.	Зорилтот түвшинд хүрсэн.
6	Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд	хувь	18	18	50	Суурь түвшингээс өөрчлөгдөөгүй буюу ахиц дэвшил гараагүй.	Хэрэгжилт хангалтгүй, Зорилтот түвшинтэй харьцуулахад маш хол зөрүүтэй 2021-2022 Нийт 30.545 элсэгчдийн 3,283 буюу 10.7 хувь нь боловсролын салбарын мэргэжлүүдэд элсэж, тэдгээрийн 573 буюу 17.4 хувь нь эрэгтэй элсэгч байна. Тус салбарт элсэгчдээс сургуулийн өмнөх болон бага ангийн багш мэргэжлээр элсэгч 842 байгаагийн 20 нь эрэгтэй элсэгч байна.



№	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин 2015 он	2021 он	Зорилтот түвшин, 2021 он	Суурь үетэй харьцуулахад	
						2021 он	2022 он
7	Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	30	30	50	Суурь түвшингээс өөрчлөгдөөгүй буюу ахиц дэвшил гараагүй.	Хэрэгжилт хангалтгүй, Зорилтот түвшинтэй харьцуулахад маш хол зөрүүтэй 2021-2022 оны хичээлийн жилд нийт элсэгчдийн 1,655 буюу 5.4 хувь нь мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжлүүдийг сонгон элсэж, тэдгээрийн 375 буюу 22.6 хувь нь эмэгтэй элсэгч байна.
8	Жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ хийгдсэн хэвлэл мэдээллийн байгууллага	тоо	2	2	20	Суурь түвшингээс өөрчлөгдөөгүй буюу ахиц дэвшил гараагүй.	Зорилтот түвшинтэй харьцуулахад маш хол зөрүүтэй.
9	Жендэрийн үндэсний сургагч багшийн тоо	тоо	90	104	180	14-өөр нэмэгдсэн буюу бараг ахиц дэвшил гараагүй.	275 Зорилтот түвшинд хүрсэн. Жендэр ба бодлого төлөвлөлт анхан шатны сургагч багшаар 250, Жендэрийн дүн шинжилгээ дунд шатны сургагч багшаар 25, Жендэрт суурилсан хүчирхийлэл тэй тэмцэх хөвгүүд эрэгтэйчүүдийн сургагч багшаар 51 хүн сургагдсан.



№	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин 2015 он	2021 он	Зорилтот түвшин, 2021 он	Суурь үетэй харьцуулахад	
						2021 он	2022 он
10	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан (УА), төрийн албан хаагч (ТАХ)	хувь	УА-15 ТАХ-25	УА-48 ТАХ-60	УА-65 ТАХ-75	Сургалтад хамрагдсан УА-ны эзлэх хувь тоо 33 пунктээр, ТАХ-дын эзлэх хувь 35 пунктээр нэмэгдэж, ахиц дэвшил гарсан.	Давхардсан тоогоор тооцоход зорилтот түвшинд хүрсэн.
11	Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь ТББ-аас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо	тоо	-	15	30	0 байсан түвшингээс 15 нэгжээр нэмэгдэж, ахиц дэвшил гарсан.	Орон нутгийн 15 дэд хөтөлбөр, салбарын 5 стратеги бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. Зорилтот түвшинтэй харьцуулахад 70%-ийн гүйцэтгэлтэй, ахиц дэвшил гарсан.
12	Аймаг, нийслэл, дүүрэгт ажиллаж байгаа хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	тоо	10	НЦҮТ-17 ХБ-15 Нийт 32	30	Хохирогч хамгаалах нэгжийн тоо 22-оор нэмэгдэж ахиц дэвшил гарсан.	Зорилтот түвшингээс давуулан биелүүлсэн.

### 5.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн

Одоогоор ЭЗХЯ-наас бусад бүх яам салбарын жендэрийн бодлого, бүх аймаг нийслэл, дүүрэг орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж, хэрэгжилтийн үнэлгээг бодлогын үе шат бүрд гүйцэтгэхийг зорьж ажиллаж байна.



### 5.3.1. Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Салбарын жендэрийн бодлогууд нь салбарын хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дэмжихийн зэрэгцээ ЖЭТБХТХ, үндэсний болон салбар дундын бодлого төлөвлөлтийг дэмжихэд чиглэгддэг.

Хэрэгжилтийн хугацаа дууссан болон эхний үе шат дууссан 6 салбарын бодлогын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн болон дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийг хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 31.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээ /2023 оны 9 сарын 19-ний байдлаар/

№	Төрийн захиргааны төв байгууллага	Бодлого батлагдсан он/ Хэрэгжих үе шат	Хэрэгжилт (өссөн дүнгээр)	Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байдал, үнэлгээ хийсэн байгууллага
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	2018-2021	84% Тодорхой үр дүнд хүрсэн	Бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХЗДХЯ, ХШҮДАГ, 2022)
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2018-2021 2022-2026	(30-70%) Эрчимжүүлэх шаардлагатай	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо, 2022)
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2018-2021 2022-2025	(30-70%) Эрчимжүүлэх шаардлагатай	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (МОНЭС, 2022)
4	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	I үе шат: 2014-2016 II үе шат: 2017-2020 III үе шат: 2021-2030	(30-70%) Эрчимжүүлэх шаардлагатай	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Хараат бус судалгааны хүрээлэн, 2018) II шатны үнэлгээг яаралтай хийх шаардлагатай.
5	Боловсрол, шинжлэх ухааны яам	2017-2020 2021-2024	35% Эрчимжүүлэх шаардлагатай	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (МУИС, 2023)
6	Батлан хамгаалах яам	2019-2022 2023-2024	89% Тодорхой үр дүнд хүрсэн	Бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (БХЯ, ХШҮДАГ, 2022)
7	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	2019-2022 2023-2026	(30-70%) Эрчимжүүлэх шаардлагатай	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Хараат бус судалгааны хүрээлэн, 2023)
8	Барилга, хот байгуулалтын яам	2018-2021 2022-2025	50,4% Тодорхой үр дүнд хүрсэн	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ, 2023)





9	Сангийн яам	2016-2021 2022-2024	-	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болсон, үнэлгээ хийгдээгүй.
10	Гадаад харилцааны яам	2020-2022 2023-2025	-	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ 2023 онд хийх шаардлагатай.
11	Зам тээврийн хөгжлийн яам	2021-2024	-	
12	Эрүүл мэндийн яам	2021-2026	-	Үнэлгээ хийх хугацаа болоогүй.
13	ЦХХХЯ	2023-2026	-	
14	Соёлын яам	2023-2031	-	
15	Эрчим хүчний яам	2023-2032	-	
16	Эдийн засаг, хөгжлийн яам	-	-	ЖЭТБХТХ, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөлтийг хөгжлийн урт, дунд, богино хугацааны төлөвлөлттэй уялдуулах арга хэмжээ авч ажиллаж байна.
Салбарын жендэрийн бодлогууд нь салбарын хүний нөөцийн жендэрийн тэгш байдлыг хангахад түлхүү чиглэдэг бөгөөд 6 салбарын бодлогын хэрэгжилт дунджаар <b>41% буюу "эрчимжүүлэх шаардлагатай"</b> байна.				

2021 онд 2, 2022 онд 5 салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байснаас 4 бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн, 1 бодлогын хэрэгжилтэд тухайн яамны дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний газар хийсэн байна.

Эдгээр үнэлгээний талаас илүү хувь нь бодлогод заасан хугацаанд хийгдээгүй байна. Тухайлбал, Боловсрол, шинжлэх ухааны салбарын жендэрийн бодлого, стратеги (2017-2024)-ийн дунд хугацааны хэрэгжилтийн үнэлгээ, Барилга, хот байгуулалтын салбарын жендэрийн бодлогын эхний шатны хэрэгжилтийн үнэлгээ товлосон хугацаанаас 2 жилийн дараа, Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нэг жилийн дараа тус тус хийгдсэн байна.

### 5.3.2. Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ

Орон нутгийн жендэрийн бодлогууд нь орон нутгийн байгууллагын хүний нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дэмжихийн зэрэгцээ ЖЭТБХТХ, үндэсний болон орон нутгийн, салбар дундын бодлого төлөвлөлтийг дэмжихэд чиглэгддэг.


2022 оны 12 сарын 31-ний байдлаар хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан нийт 22, үе шатны үнэлгээ хийх хугацаа болсон нийт 8, хугацаагүй болоогүй 1 дэд хөтөлбөр байна. Үүнээс 11 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн болон дотоод (тухайн шатны засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс) хяналт шинжилгээ хийсэн байна. Үлдсэн 19 аймаг, дүүргийн дэд хөтөлбөрт явцын болон эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

**Хүснэгт 32.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний нэгдсэн мэдээ /2022 оны 12 сарын 31-ний байдлаар/

№	Нутгийн захиргааны байгууллага	Бодлого хэрэгжих хугацаа	Хэрэгжилт (хувь)	Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байдал, үнэлгээ хийсэн байгууллага
1	Баянхонгор	2019-2022	77.8%	Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Баянхонгор аймгийн Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ, 2021 он
2	Булган	2013-2020	61%	Бодлогын хэрэгжилтийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Булган аймгийн ТББ-ын нэгдэл сүлжээ байгууллага-Гэрэлт ирээдүй оршихуй ТББ, 2021 он
3	Говь-Алтай	2018-2022	83,3%	Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, ЗДТГ, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
4	Дархан-Уул	2019-2021	60%	Бодлогын хэрэгжилтийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Дархан-Уул аймгийн ТББ-ын сүлжээ байгууллага, 2021 он
5	Дорнод	2018-2021	55%	Бодлогын хэрэгжилтийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Дорнод аймгийн Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ сүлжээ, 2021 он
6	Дундговь	2019-2022	84,2%	Бодлогын хэрэгжилтийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ, ЗДТГ, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, 2022 он
7	Өмнөговь	2019-2021	61.8%	Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Өмнөговь аймгийн ТББ-ын сүлжээний нэгдэл байгууллагууд 2021 он
8	Увс	2017-2021	83.8%	Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, ЗДТГ, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
9	Ховд	2017-2021	92%	Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Ховд аймгийн ТББ-ын сүлжээ байгууллагууд, 2021 он
10	Багануур дүүрэг	2020-2024	60.5%	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээ, үнэлгээ, Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ын Багануур дүүргийн салбар байгууллага, 2021 он



11	Сүхбаатар дүүрэг	2018-2021	90%	Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн судалгааны баг (IRIM) 2021 он
12	Архангай	2020-2024		Бодлогын хэрэгжилтийн явцын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
13	Баян-Өлгий	2018-2021		Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
14	Говьсүмбэр	2019-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
15	Дорноговь	2017-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
16	Завхан	2018-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
17	Өвөрхангай	2019-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
18	Орхон	2020-2023	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
19	Сүхбаатар	2019-2022	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
20	Сэлэнгэ	2018-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
21	Төв	2018-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
22	Хөвсгөл	2019-2021	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
23	Хэнтий	2020-2023	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
24	Нийслэл	2020-2025	--	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
25	Багахангай	2020-2025	--	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
26	Баянгол	2020-2025	--	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
27	Баянзүрх	2019-2024	--	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
28	Сонгинохайрхан	2020-2025	--	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
29	Чингэлтэй	2018-2020	--	Хэрэгжиж дууссан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.
30	Налайх	2020-2025	--	Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгаа
31	Хан-Уул	2022-2025	--	Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа болоогүй.



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүний хөгжил, нийгэм, эдийн засаг, засаглалын хүрээнд урт хугацаанд эерэг үр нөлөөг гаргаж байна. Тухайлбал: Хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийг бий болгож, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх, хууль эрх зүйн зөвлөгөө авах үйлчилгээгээр хангагдах, түүнчлэн эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулж, андрологийн эмч, эмнэлгийн ажилтан, хүний нөөцийг бэлтгэж ажилласан нь залуучууд, эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тэгш хамрагдах, эрүүл мэндийн аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж, эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгаж, чанартай урт наслахад эерэг үр нөлөөг бий болгож байна.

Орон нутгийн хөгжлийг жендэрийн арга зүйгээр дэмжин ажиллахад өөрийн орон нутгийн хэрэгцээ, жендэрийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлсэн жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар сайн туршлагуудыг үндэсний хэмжээнд нэвтрүүлж ажиллаж байна.

Энэ хүрээнд Архангай аймгийн Онцгой байдлын газар дээр хэрэгжүүлсэн “Байгууллагын түвшинд ажил-ар гэр амьдралын тэнцвэрт байдлыг хангах бодлогыг төлөвлөн хээгжүүлэх”, Баянхонгор аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төв “Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх цогц үйлчилгээний туршлага, арга зүйг ТББ-уудад нэвтрүүлэх, чадавхжуулах”, Орхон аймгийн Эрүүл мэндийн төв “Эрэгтэйчүүдийн кабинет байгуулан ажиллуулах”, Увс аймгийн Бөхмөрөн сумын ерөнхий боловсролын сургууль “Бага боловсролд хамрагдаж буй малчин өрхийн хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицоход туслах”, Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс “Орон нутгийн жендэрийн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэгчдэд хүргэх” зэрэг асуудлаар аймгийн салбар хороо, түүний гишүүн байгууллагууд хамтран ажиллаж байна.

Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн жендэрийн статистик мэдээллийг хөгжүүлэх, түүнийг бодлого хөтөлбөрт тусгаж, ашиглахад төрийн албан хаагчид суралцаж чадавхжихын эзрэгцээ иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд түлхэц дэмжлэг болж байна.



## ЗУРГАА. ЖЕНДЭР СУДЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН

Жендэр судлалыг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж, алхам хийснээс хойш Засгийн газар богино хугацаанд тодорхой ажлуудыг эхлүүлж, нэн ялангуяа Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлгийг албан ёсоор байгуулж, бүлгийн ахлагч ЖҮХ-ны бүрэлдэхүүнд ажиллаж байна.

Жендэрийн асуудлыг бүх шатны сургалтын хөтөлбөр агуулгад нэгтгэх, их дээд сургуулийн ахисан түвшний хөтөлбөрт тусгах зэрэг үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт **50% буюу “хэрэгжих шатанд”** байна.

Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны дүрмийг шинэчлэн баталсан. Дүрмийн 2.3-д “Хороо нь шаардлагатай бол жендэрийн тэгш байдлыг хангах тодорхой асуудлаар зөвлөл, ажлын хэсэг, шинжээчдийн бүлэг байгуулан ажиллуулж болох бөгөөд бүрэлдэхүүнийг Хорооны хуралдаанаар батална” гэж заасан бөгөөд энэ дагуу ЖҮХ-ны бүрэлдэхүүнд албан ёсоор Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлэг /бүлгийн ахлагч/ багтан, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл хэрэгт дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж байна.

Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлэг нь их, дээд сургуулийн жендэрийн чиглэлээр мэргэжсэн, жендэр чиглэлээр холбогдох хичээлийг бакалаврын болон ахисан түвшинд заадаг багш, судлаачдын сайн дураар нэгдсэн бүлэг юм. 2022 онд ЖҮХ-ны бүрэлдэхүүнд тус бүлгийн ахлагчийг Хорооны гишүүнээр багтаасантай холбоотойгоор ЖҮХ-ны үйл ажиллагаан дахь оролцоо, хамтын ажиллагаа сайжирч байна.

Жендэрийн асуудлаарх эрдэмтэн судлаачдын бүлгийн гишүүдийг жендэрийн талаарх үндэсний, салбарын, орон нутгийн түвшний уулзалт, хэлэлцүүлэг, онол практикийн хурал, судалгаа үнэлгээний ажилд татан оролцуулж хамтран ажиллаж байна. Тухайлбал, тус бүлгийн гишүүн эрдэмтэн судлаачид ЖЭТБХТХ-ийн үр дагаврын үнэлгээ судалгааны үр дүнг олон нийтэд түгээх видео (2021)-д илтгэгч, Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт (2021)-д илтгэгч, “Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” судалгааны дүнг танилцуулах үндэсний хэлэлцүүлэг (2021)-т илтгэгч, Жендэрийн үндэсний хорооноос санаачлан, Азийн Хөгжлийн Банк, Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Жендэр ба Хөгжил-2021” Үндэсний чуулган (2021)-д панелист, модератор, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хэлэлцүүлэг (2022)-т оролцогч, Жендэрийн эрх



тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэлэлцүүлэг (2022)-т оролцогч, “ЖЭТБХТХ батлагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан хуулийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” онол практикийн хуралд илтгэгч, Эрчим хүчний салбарын жендэрийн нөхцөл байдлын үнэлгээний үр дүнгийн хэлэлцүүлэг (2023)-т илтгэгч, Эрчим хүчний салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөөний хэлэлцүүлэг (2023)-т илтгэгч, модератороор урьж оролцуулан, мэдлэг туршлагаа хуваалцаж ажиллалаа.

Салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг жендэрийн асуудлаарх эрдэмтэн, судлаачдын бүлгийн гишүүдээр гэрээлэн гүйцэтгүүлж байна. Тухайлбал, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, боловсрол, шинжлэх ухааны салбарын жендэрийн бодлого, нийслэлийн Сүхбаатар дүүргийн жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг дэд проф С.Түмэндэлгэр, докторант Ц.Одгэрэл, доктор, проф. А.Солонго, доктор, дэд проф. Н.Болдмаа нар амжилттай гүйцэтгэж зохих дүгнэлт, зөвлөмжийг хүргэж ажиллалаа.

ЖҮХ-ноос жендэр судлалыг хөгжүүлэх үүднээс “Жендэр судлал” сэтгүүлийг санаачлан гаргадаг бөгөөд сүүлийн 2 жилийн хугацаанд уг сэтгүүлийг хянан магадлагаа бүхий эрдмийн сэтгүүл болгон хөгжүүлэхээр эрдэмтэн, судлаачдын бүлэгтэй хамтран ажиллаж, тус сэтгүүлийн 4, 5 дахь дугаарыг бэлтгэн гаргалаа.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хөдөөгийн эмэгтэйчүүдийн амьжиргааг дээшлүүлэх жендэрийн судалгааг дэмжих зорилгоор эрдэмтэн судлаачдын санал болгосон судалгааны төслийг шалгаруулж, Азийн хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд тэтгэлэг олгож ажиллалаа.

Тус судалгааны төслийн тэтгэлэгт 28 судлаач төсөл ирүүлснээс төсөл шалгаруулах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 5 судлаачийн төслийг сонгон шалгарууллаа. Судлаачид судалгааны үр дүнд тулгуурлан уур амьсгалын өөрчлөлтөд үр дүнтэйгээр дасан зохицох, хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн амьжиргааг дээшлүүлэх арга зам, хувилбарыг санал болгосон бөгөөд тэтгэлэг авсан судлаачдын эрдэм шинжилгээний 5 өгүүллийг “Жендэр судлал” сэтгүүлд хэвлүүлж, олон нийтийн хүртээл болголоо.

Азийн хөгжлийн банкны 2019-2021 оны хооронд хэрэгжсэн “Жендэр ба хяналт шинжилгээ, үнэлгээ” техник туслалцааны хүрээнд жендэр судлаач, эрдэмтдийн судалгааны ажлыг олон нийтэд хүргэх, олон нийтийн жендэрийн боловсролыг ахиулах зорилгоор цуврал хэлэлцүүлгийг цахим, танхим хосолсон байдлаар нийт 10 удаа зохион байгуулж ажиллалаа.






Тус цуврал хэлэлцүүлгийн 6 хэлэлцүүлэгт нь жендэр судлаачид хэлэлцүүлгийг хөтлөх, өөрсдийн судалгааны үр дүнг танилцуулах, зохих зөвлөмжийг хүргэх зэргээр оролцсон. Үүнд:

- Цуврал хэлэлцүүлэг-1. “Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл, тулгамдаж буй асуудал” нээлттэй хэлэлцүүлэг (2020 оны 5 дугаар сарын 29-ний өдөр);
- Цуврал хэлэлцүүлэг- 2. “Мэргэжилд хүйс байхгүй” хэлэлцүүлэг (2020 оны 6 дугаар сарын 26-ны );
- Цуврал хэлэлцүүлэг-6. “Эмэгтэйчүүдийн иргэний нийгмийн байгууллагуудын хөгжил - иргэний нийгмийн төлөвшил” нээлттэй хэлэлцүүлэг( 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр);
- Цуврал хэлэлцүүлэг-7. “Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн асуудлууд” хэлэлцүүлэг (2021 оны 3 дугаар дугаар сарын 2-ны өдөр);
- Цуврал хэлэлцүүлэг- 8. “Мэдэхгүйгээ үл тоомсорлож, өнгөрсөн хойно нь харамссаар байх уу? цахим орчин дахь хүний эрхийн мэдрэмжтэй, хүчирхийллийн агуулгагүй харилцаа” хэлэлцүүлэг( 2021 оны 5 дугаар дугаар сарын 12-ны өдөр);
- Цуврал хэлэлцүүлэг- 9. “Эрэгтэйлэг шинж ба залуусын нийгэмшил” хэлэлцүүлэг( 2021 оны 6 дугаар сарын 4-ний өдөр).

Жендэр судлалыг хөгжүүлэх хүрээнд их, дээд сургуулийн бакалавр, ахисан шатны сургалтын хөтөлбөрт жендэрийн агуулга бүхий хөтөлбөр нэгтгэх санаачилгыг дэмжиж ажиллалаа. Тухайлбал, ЖҮХ-ноос сэтгүүлч, нийгмийн ажлын хөтөлбөрт жендэрийн боловсрол олгох зорилго бүхий хөтөлбөр, гарын авлага боловсруулах жижиг төсөл хэрэгжүүлсний үр дүнд МУИС, МУБИС, ШУТИС, АШҮИС, ХУИС болон сэтгүүл зүй, нийгмийн ажилтан бэлтгэх хөтөлбөр бүхий хувийн зарим их, дээд сургуульд бие даасан курс хичээлийг судалж байна.

Түүнчлэн МУИС, МУБИС-д бакалавр болон ахисан түвшний сургалтад АШУИС, ШУТИС, ХУИС, Идэр, Отгонтэнгэр их сургууль, Дархан дээд сургууль, Утга зохиол, нийгмийн ажилтны сургууль, Хөдөлмөр, нийгмийн харилцааны их сургууль, Улаанбаатар-Эрдэм дээд сургуульд бакалаврын хөтөлбөрт 1-7 хичээлийг оюутнууд сонгон судлах боломж бүрдсэн.

Эрх зүйн бакалаврын хөтөлбөр дэх “Хүний эрх” хичээлийн хөтөлбөрт жендэрийн агуулгыг нэгтгэх үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ эрх зүйч бэлтгэх сургуулиудад зориулж, холбогдох хичээлийн агуулга тус бүрт жендэрийн агуулгыг нэгтгэх сургалтын жишиг хөтөлбөрийг боловсрууллаа.



**Хүснэгт 33.** Жендэрийн боловсрол олгох зорилго бүхий хичээлийн хөтөлбөрийг сургалтад нэвтрүүлсэн байдал, 2023 он

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ /МУИС/	7 хичээл, нийт 22 кредит	Бакалавар
	2 хичээл, нийт 5 кредит	Магистр, доктор
МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ /МУБИС/	4 хичээл, нийт 8 кредит	Бакалавар
	1 хичээл, нийт 2 кредит	Магистр
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ /АШУУИС/	2 хичээл, нийт 4 кредит	Бакалавар
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ /ШУТИС/	2 хичээл, нийт 4 кредит	Бакалавар
ХУИС	2 хичээл, нийт 3 кредит	Бакалавар
ИДЭР ДЭЭД СУРГУУЛЬ	2 хичээл, нийт 6 кредит	Бакалавар
ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ /ОТИС/	1 хичээл, нийт 3 кредит	Бакалавар
	3 хичээл, нийт 6 кредит	Магистр
ДАРХАН ДЭЭД СУРГУУЛЬ	1 хичээл, нийт 2 кредит	Бакалавар
УТГА ЗОХИОЛ, НИЙГМИЙН АЖИЛТНЫ ДЭЭД СУРГУУЛЬ	1 хичээл, нийт 2 кредит	Бакалавар
ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ДЭЭД СУРГУУЛЬ	2 хичээл, нийт 5 кредит	Бакалавар
УЛААНБААТАР ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ	1 хичээл, нийт 2 кредит	Бакалавар

Удирдлагын академи нь албан сургалтын тогтолцоогоор дамжуулан жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх мэдлэг ойлголтыг төрийн албан хаагчдад байнга тогтвортой түгээж байгаа нь жендэр судлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Жендэр судлалын салбар дундын магистрын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх санаачилга МУИС, Отгонтэнгэр их сургуульд Жендэр судлалын, Эрдмийн их сургууль (ХУИС)-д Гэр бүл судлал, жендэр судлалын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх санаачилга гарч, 2023-2024 оны хичээлийн жилээс элсэн суралцах боломжийг бүрдүүлээд байна.

Жендэрийн асуудлаарх эрдэмтэн, судлаачдын бүлэг нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаачдын нэгдэл, бүлэг болохын хувьд зургаан их сургуулийн дундын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг бий болгож, сургууль тус бүрийн эрх зүйн актад тусгаж ажиллалаа.



Жендэр судлалын төв байгуулах, сургууль дундын магистрын хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн.

2023 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулах, жендэрийн боловсрол олгох институт (KIGEPE), Эмэгтэйчүүдийн хөгжлийн институт (KWDI)-тэй хамтран ажиллахаар “санамж бичиг” байгуулсан нь жендэрийн мэргэжилтэн, судлаачдыг сургаж бэлтгэх, чадавхжуулах ажилд чухал алхам боллоо.

Жендэрийн асуудлаарх суурь болон хавсарга судалгааны чиглэлд эрдэмтэн, судлаачдын бүлэг онцгой анхаарч ажиллаж байгаа бөгөөд өөрсдийн санал, санаачилгад тулгуурлан хамтарсан судалгааны төсөл бичих, төслийг санхүүжүүлэх талаар холбогдох уулзалт яриаг салбарын яам, байгууллагуудтай хийж ажиллалаа.

Цаашид салбарын яамд болон төрийн бусад байгууллагын захиалгат хавсарга судалгааг жендэр судлаач, эрдэмтдээр гүйцэтгүүлэх, тэднийг татан оролцуулах, хамтран ажиллахад тухайлан анхаарах шаардлагатай байна.

## ДОЛОО. СУРГАМЖ БА СОРИЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Засгийн газраас 2021, 2022 онд жендэрийн тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг 1/жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, 2/бодлого төлөвлөлт, 3/төсөвлөлт, 4/хэрэгжилт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээ, 5/жендэр судлал гэсэн таван бүлэг асуудлаар үнэлэхэд хэрэгжилт 50% буюу “хэрэгжих шатанд” байна.

Засгийн газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг доорх байдлаар дүгнэж, цаашид анхаарах чиглэлийг танилцуулж байна.

### 7.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, хүний нөөцийн удирдлага, манлайлын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлэх хүрээнд Засгийн газар бүс нутаг, олон улсын төсөл, хөтөлбөрт манлайлан оролцох, гадаад улс орон, хөгжлийн байгууллагуудтай хамтарсан санал санаачилгыг хэрэгжүүлэх зэргээр үйл ажиллагааны хүрээг өргөжүүлсэн.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд төр, төрийн бус байгууллага, улс төрийн нам, бизнес, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, оролцоо, санаачилгыг дэмжих, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилго бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн нэгдмэл байдлыг хангах, төрийн бодлого, арга хэмжээтэй нийцүүлж, уялдаа холбоог хангах хүрээнд үндэсний болон салбар дундын бодлого зохицуулалтыг боловсронгуй болгож, идэвх санаачилгыг нэмэгдүүлсэн.

Засгийн газраас ЖЭТБХтХ-ийн хэрэгжилтийг бодлого, аргазүйгээр хангаж ажиллах бие даасан тогтвортой бүтцийг үндэсний түвшинд бүрдүүлэн ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар ЦХХХЯ, Соёлын яам, ЭЗХЯ зэрэг яамдыг шинээр байгуулснаар, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого үйл ажиллагааг далайцтай үр дүнтэй хэрэгжүүлэх бодлогын болон институцын томоохон өөрчлөлтийг хийж, тогтвортой үр дүн гаргах боломжийг бүрдүүлсэн. Жендэрийн салбар зөвлөл болон салбар хороодын бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулах, салбар зөвлөл, хороодыг тогтмол хуралдуулах, салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийг хийх, үр дүнгээ тайлагнахад дэвшил гарч байгаа ч төсвийн мөчлөгтэй уялдуулах байдал дутмаг хэвээр байна.



Жендэрийн салбар зөвлөл болон хороодын үйл ажиллагааны үр дүнд жендэрийн мэргэжилтний тогтвор суурьшил, ажил үүргээ биелүүлэх боломж нөхцөл бүрдсэн байдал нөлөөлж байна.

Жендэрийн мэргэжилтэн нь жендэрийн тэгш байдлыг хангах талаар хуульд заасан чиг үүргийг үндсэн чиг үүргээс гадна хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд ажил үүргээ бүрэн дүүрэн гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа зарцуулах боломж бага байгаа нь аймаг, нийслэлийн жендэрийн мэргэжилтний ажлын ачаалалд хийсэн шинжилгээгээр илэрсэн.

Энэ хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-т “Жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан бие даасан мэргэжилтэн” ажиллуулах зорилгоор албан тушаалын тодорхойлолтын загварыг Төрийн албаны зөвлөлөөс батлан мөрдүүлэхийг зөвшөөрсөн нь бодлогын чухал дэмжлэг болсон.

Төрийн байгууллагуудаас жендэрийн сургалт захиалах хандлага өсөж байгаа нь сайшаалтай. Сургалтын давтамж, хамрах хүрээ өргөжиж байгаа нь салбар, орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөлтийг батлан хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой байна.

**Зөвлөмж 1.** Хөгжлийн түншлэгчдийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг салбар, орон нутгийн жендэрийн бодлого, дэд хөтөлбөрийг дэмжихэд чиглүүлж, уялдуулахад анхаарах шаардлагатай.

**Зөвлөмж 2.** ЖҮХ-ны хэрэгжүүлж буй үйл ажиллагаа өргөжин тэлж байгаагийн хэрээр Ажлын алба, жендэрийн салбар зөвлөл болон салбар хорооны ажлын ачаалал нэмэгдэж байгааг харгалзсан бүтэц, орон тоо, хүний нөөцийн уян хатан зохицуулалтууд шаардлагатай.

**Зөвлөмж 3.** Төсвийн мөчлөгтэй уялдуулан төлөвлөлтийг оновчтой цаг хугацаанд нь хийх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, заавар, зөвлөмж, удирдамжийг чанаржуулж, чадавх бэхжүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай.

**Зөвлөмж 4.** Яамдад жендэрийн бие даасан мэргэжилтэн ажиллуулах эсэх талаарх судалгаа шинжилгээнд суурилсан албан тушаалын тодорхойлолтыг гаргах ажил хараахан дуусаагүй байгааг эрчимжүүлэх шаардлагатай.

**Зөвлөмж 5.** Өмнөх жилүүдийн сургалтын зорилго, агуулга, арга зүйд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, мэдлэгээс хандлага, үнэт зүйлсийг төлөвшүүлэх, эерэг зан үйл, дадлыг бий болгох зорилт бүхий сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, шатлалыг тогтоож өгөх шаардлагатай.



## 7.2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт

Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журам нь ерөнхий утгаараа Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө, салбар, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт тусгагдсан үзэл баримтлал, арга хэмжээг бодлого, төлөвлөлтөд нэгтгэхэд чухал дэмжлэг болсон.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”-г батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тус стратеги төлөвлөгөөнд салбар, орон нутгийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх, бодлогын хэрэгжилтийг үнэлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэхээр тусгасан.

Нийт 16 яамны 15 нь буюу 94% нь салбарын жендэрийн бодлого, нийслэл, 21 аймаг, 9 дүүрэг бүгд орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр баталж, жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг бодлого төлөвлөлтөд нэгтгэсэн байна.

Гэвч салбар хороо, зөвлөлүүд тогтсон хугацаанд төлөвлөлтөө хийдэггүй, салбар, орон нутгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд жендэрийн асуудлуудыг тусгадаггүй байдал нийтлэг ажиглагдаж байна.

**Зөвлөмж 1.** Ядуурлыг бууруулах, хөнгөлөлттэй зээл олгох, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөхөд дэмжлэг туслалцаа шаардлагатай эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлэгт чиглэсэн арга хэмжээг багтаах, шалгуур үзүүлэлтэд хамгийн бага байх түвшинг тодорхойлон тусгах шаардлагатай байна.

**Зөвлөмж 2.** Бодлого төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлалыг нэгтгэх хүрээнд эрхзүйн орчны шинэчлэлийг улам боловсронгуй болгох, Хууль тогтоомжийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмуудад жендэрийн нарийвчилсан аргазүй аргачлалуудыг нэгтгэх шаардлагатай.

**Зөвлөмж 3.** Удирдах ажилтны хүлээх үүрэг хариуцлагын хэрэгжилтийг хянах, хариуцлагын механизмыг оновчтой болгох шаардлагатай байна.

**Зөвлөмж 4.** Салбар, орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хэрэгжиж дууссан салбар, орон нутаг г өмнөх бодлогын хэрэгжилт, үр дүнд үндэслэн, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-тэй уялдуулан дараагийн шатны төлөвлөлт, төсөвлөлтийг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.





### 7.3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, санхүүгийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны дийлэнх санхүүжилтийг олон улсын хөгжлийн албан ёсны түншлэгчид олгосон буюу бүхэлдээ хандивлагч, түншлэгчдээс ихээхэн хамааралтай байна.

Салбар, орон нутгийн байгууллагуудад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийх чадавх бүрдүүлэх ажил Сангийн яамны манлайлал, санаачилгатайгаар хэрэгжиж эхэлж байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг ХНХЯ, БШУЯ дээр туршсан боловч дээрх хоёр яамны төсвийн бүрэлдэхүүн хэсэг болон хэмжээнд тодорхой өөрчлөлт гараагүй байна.

Орон нутагт жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд төсөв зарцуулах байдал 2021 онтой харьцуулахад буурсан.

Сангийн яамнаас санаачлан хэрэгжүүлж буй жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хэмжээнд орон нутгийн захиргааны байгууллагыг албан ёсоор хамруулаагүй байна.

**Зөвлөмж 1.** Жендэрийн мэдрэмжтэй, үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүй, удирдамжийг турших, сайжруулах ажлыг улам эрчимжүүлэх, шаардагдах санхүүжилтийг улсын ба орон нутгийн төсөвт бүрэн тусгаж санхүүжүүлэхэд анхаарах шаардлагатай.

**Зөвлөмж 2.** Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг туршин хэрэгжүүлсэн яамдын туршилтын жилийн үр дагаварт ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг тодруулах үнэлгээг хийх, туршилтыг яамдаас гадна орон нутагт хийх, хамрагдах яам, нутгийн захиргааны байгууллагын тоог нэмэгдүүлж, үр дүнг сайжруулах шаардлагатай.

**Зөвлөмж 3.** Хөгжлийн түншлэгчдийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг салбар, орон нутгийн жендэрийн бодлого, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд чиглүүлж, уялдуулах, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын талаар мэдээллийн санг бий болгох шаардлагатай.

**Зөвлөмж 4.** Орон нутгийн бодлого төлөвлөлтөд жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх ажлыг үндэсний салбарын бодлого төлөвлөлттэй нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай.



#### 7.4. Жендэрийн мэдрэмжтэй бодлогын гүйцэтгэл, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт

ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс “Тайлан, төлөвлөгөө ирүүлэх тухай” албан бичгийг жил бүр төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлснээр төлөвлөлт, тайлагналт сайжирсан.

Гэвч тайлан, мэдээллийг тогтсон цаг хугацаандаа тайлагнах байдал зарим яамд, орон нутагт дутагдалтай хэвээр байна.

Жендэрийн статистик бүрдүүлэх чиглэлээр салбар зөвлөл, хороодын ажилд тодорхой ахиц гарч байгаа ч жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийн явцыг эргэж харах, ахиц дэвшил болон саад бэрхшээл, нийгмийн бодит хэрэгцээг тодруулахад статистик мэдээлэлд үндэслэх, баримтжуулах нь дутмаг хэвээр байна.

Салбарын жендэрийн бодлого болон орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоодын болон хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж эхэлсэн бөгөөд хөндлөнгийн үнэлгээ хийгдсэн салбаруудын тайлангаас үзэхэд, бодлогын хэрэгжилтийн явцын болон эцсийн үнэлгээ төлөвлөсөн хугацаанд хийгдэхгүй байгаагийн зэрэгцээ хөндлөнгийн болон дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн зөрүүтэй байна.

**Зөвлөмж 1.** Тайлагнах үйл явцад гарч буй саад бэрхшээл, агуулга болон техникийн бусад шалтгааныг тодруулж, тайлагналтын чанар болон үйл явцын талаарх аргачлал, зөвлөмж гаргаж, сургалтын чанарыг эрс ахиулахад анхаарах шаардлагатай.

**Зөвлөмж 2.** Жендэрийн үндсэн ойлголтын мэдлэгийг ахиулахын сацуу хүйсээр ангилсан мэдээллийг бодлого, үйл ажиллагаанд ашиглах чадавхыг практик сургалтаар нэмэгдүүлж, яамдын түвшинд салбарын статистик судалгаа, дүн шинжилгээний нэгжийг байгуулж ажиллах хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгааг анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Зөвлөмж 3.** Батлагдсан бодлого, дэд хөтөлбөр, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавх бэхжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголт мэдлэгийг сайжруулахад Удирдлагын академитай хамтран ажиллах шаардлагатай байна.



### 7.5. Жендэр судлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүн, сургамж, сорилт

Жендэр судлал нь монгол хүн судлал, нийгэм судлалын нэг үндсэн чиглэл бөгөөд улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлт хийх чухал хэрэглүүр юм. Жендэр судлалыг хөгжүүлэх хүрээнд жендэрийн асуудлыг бүх шатны сургалтын хөтөлбөр агуулгад нэгтгэх ажил амжилттай хэрэгжиж байна.

“Сургууль дундын магистрын хөтөлбөр”, “Жендэр судлалын төв” ажиллуулах санаачилгыг эхлүүлж, нийт 11 их сургуулийн бакалавар, магистрын 30 гаруй хичээлийн хөтөлбөрт жендэрийн агуулгыг нэгтгэсэн байна.

**Зөвлөмж 1.** Шинжлэх ухаан, технологийн сангийн судалгааны санхүүжилтын дэмжлэгийг жендэр судлалын судалгааны бүтээлийг санхүүжүүлэхэд болон салбарын яамд, төрийн байгууллагын захиалгат хавсарга судалгааг жендэр судлаач, эрдэмтдээр гүйцэтгүүлэхээр чиглүүлэхэд ЖҮХ, түүний Ажлын алба, БШУЯ-тай хамтран ажиллаж, бусад яамдад зөвлөмж өгч ажиллах шаардлагатай байна.

--oOo--



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011
3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993
4. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, 2016
5. Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль, 2019
6. Улс төрийн намын тухай хууль, 2005
7. Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга), 2023
8. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2021
9. Зохиогчийн эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2021
10. Патентын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2021
11. Үндэсний их баяр наадмын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022
12. Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2022
13. Төрийн хэмнэлтийн тухай хууль, 2022
14. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022
15. Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022
16. Шүүх шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022
17. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022
18. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, 2021
19. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
20. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль
21. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2021
22. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль, 2021
23. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, 2021
24. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2021
25. Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль, 2022
26. Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, 2022
27. Генетик нөөцийн тухай хууль, 2021
28. Таримал ургамлын үр, сортын тухай хууль /шинэчилсэн найруулга, 2021
29. Хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга, 2021
30. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, 2021




31. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, 2022
32. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга, 2022
33. Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2021
34. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2021
35. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2021
36. Цахим гарын үсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2021
37. Кино урлагийг дэмжих тухай хууль, 2021
38. Музейн тухай хууль, 2021
39. Соёлын тухай хууль /шинэчилсэн найруулга, 2021
40. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, 2022
41. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль, 2022
42. Алсын хараа-2050 Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого
43. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

#### Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэр

44. МУЗГ-ын 2021 оны “Төлөвлөгөө батлах тухай” 42 дугаар тогтоол дараагийн мөрний тав аваад-Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө (2021-2027)
45. МУЗГ-ын 2017 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 129 дүгээр тогтоол дараагийн мөрний тав аваад - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)
46. МУЗГ-ын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоол
  - Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал,
  - Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал,
  - Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал,
  - Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.
47. МУЗГ-ын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” 470 дугаар тогтоол
  - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам
48. МУЗГ-ын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол
  - Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам

#### Гурав. Салбарын сайдын тушаал, шийдвэр

49. Төрийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм



хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлхэд чиглэсэн үлгэрчилсэн заавар, 2021

50. Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлхэд чиглэсэн үлгэрчилсэн заавар, 2021
51. Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал, 2022

#### **Дөрөв. Үндэсний хороо, зөвлөлийн шийдвэр**

52. “Салбар дундын стратеги төлөвлөгөө батлах тухай” ЖҮХ-ны 2022 оны 2 дугаар тогтоол
53. “Бодлого батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 38 дугаар тогтоол
54. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч, нарийн бичгийн даргын мэдээний “Маягт ,нөхөх зааврыг зөвшөөрөх тухай” ҮСХ-ны 2022 оны а/106 дугаар тушаал
55. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн цахим тайлангийн “Маягт нөхөх заавар зөвшөөрөх тухай,” Үндэсний статистикийн хорооны даргын 2020 рны А/49 дүгээр тушаал

#### **Тав. Аргачлал, удирдамж, зөвлөмж**

56. Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтэд оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, ЖҮХ, 2020
57. Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, ЖҮХ, 2020
58. Хууль тогтоомжийн жендэрийн үнэлгээ, ЖҮХ, 2019
59. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх зөвлөмж, ЖҮХ, 2021
60. Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загвар, ЖҮХ, 2021

#### **Зургаа. Судалгаа, үнэлгээний тайлан**

61. Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, (Эм Эм Си Жи ХХК, 2021)
62. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, (Эм Эм Си Жи ХХК, 2022)





63. Тогтвортой хөгжлийн зорилгын Үндэсний Сайн Дурын Илтгэл, (Монгол Улс, 2023)
64. Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХЗДХЯ-ны ХШҮДАГ, 2022)
65. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (МЭХДХ, 2022)
66. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (МОНЭС, 2022)
67. Байгаль орчны салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Хараат бус судалгааны хүрээлэн, 2018)
68. Боловсрол, шинжлэх ухааны салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (МУИС, 2022)
69. Батлан хамгаалах салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (БХЯ-ны ХШҮДАГ, 2022)
70. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого /2019-2026/"-ын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Хараат бус судалгааны хүрээлэн, 2022)
71. Барилга, хот байгуулалтын салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (ЛЕОС ТББ, 2023)
72. ЖҮХ-ны тайлан, 2021, 2022
73. ЖҮХ-ны Ажлын албаны тайлан, 2021, 2022
74. Жендэрийн салбар зөвлөлүүдийн тайлан, 2021, 2022
75. Жендэр салбар хороодын тайлан, 2021, 2022
76. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ, 2021, 2022
77. Жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлт, тайлан (Дэлхийн эдийн засгийн форум, 2023)
78. Эмэгтэйчүүд, бизнес, хууль эрхзүйн үзүүлэлтийн тайлан (Дэлхийн банк, 2023)

--oOo--





**Хаяг / Байршил:** Монгол Улс,  
Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг,  
6-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-20  
Жендэрийн үндэсний хорооны байр  
**Утас:** (976) 70071116  
**И-мэйл:** [secretariat@ncge.gov.mn](mailto:secretariat@ncge.gov.mn)  
**Вэб сайт:** <https://ncge.gov.mn/>